

Лиахоно

**Судрууд хэрхэн
орчуулагддаг вэ?
20-р хуудас**

Манай шинэ төлөөлөгч,
ахлагч Роналд А.Расбандын
талаар мэдэж авцгаая,
12-р хуудас

Ахмад номлогчид:
Үйлчлэхээр дуудагдлаа,
26-р хуудас

Нөхрүүд нь порнографтай
тэмцэхэд эхнэрүүд нь ч
мөн эдгэрч илаарших
хэрэгтэй, 34-р хуудас

10 минутад дуулал тоглож
сурах нь, 54-р хуудас





*“Учир нь болгоогтун, Их
Эзэн ийн хэлжээ, Ай
Израилын угсаа, би
чамайг усан үзмийн
талбайдаа нэгэн хүний
авч арчилсан, чидуны
таримал модтой
адилтгана; . . .*

*“ . . . Мөн та нар
адислагдсан болой;
учир нь та нар надтай
хамт миний талбайд
шаргуугаар хөдөлмөр-
лөж байлаа, мөн
миний зарлигуудыг
дагасан, мөн талбай
минь дахин муудаагүйн
учир, надад унаган
жимсийг дахин
авчирлаа, мөн муу
нь зайлуулагдсан,
болгоогтун та нар
надтай хамт талбайн
минь үр жимсний
учир баясах болно.”*

Иаков 5:3, 75

Газар дундын тэнгисийн орнуудад ихээр таригддаг чидун жимс нь чидуны навч зуусан тагтаа Ноа дээр ирснээс эхлээд, Чидун уулан дээр Аврагчийн заасан болон чидуны моддын тухай Иаковын ёгтлол хүртэлх урт удаан хугацааны судрын түүхтэй юм.



ЗАХИАСУУД

4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Бошиглол ба хувийн илчлэлт
Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

7 Айлчлагч багшийн захиас бичиг: Мөнхийн Эцэгийнхээ охид

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

12 Ахлагч Роналд А.Расбанд: Авьяаслаг удирдагч, үнэнч эцэг
Ахлагч М.Расэлл Баллард
Хайраар дүүрэн нөхөр, эцэг болох ахлагч Расбанд олон жилийн турш шилдэг бизнесийн болон санваарын удирдагчдын зөвлөгөөг дагаснаар удирдах чадвараа хөгжүүлсэн.

18 Тэр бишоп гэж үү?
Патрик Ж.Кронин III
Тэр эмэгтэй намайг бишопоор үйлчилж байгаа гэдэгт яагаад итгэж чадахгүй байгааг би ойлгож байлаа. Гучин жилийн өмнө би их өөр хүн байсан юм.

20 Судрын орчуулга: Зүрх сэтгэлийнхээ хэл рүү хөрвүүлэх нь
Р.Вал Жонсон
Судруудыг эх хэл дээрээ унших нь сүнслэг байдлаараа гэртээ ирж буй мэт байдаг.

26 Ахмад номлогчийн хором
Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон
Ахмад номлогчийн энэхүү гайхалтай хормыг хамтдаа бүтээх боломжийн төлөө залбираарай.

28 Ахмад номлогчид: Хэрэгтэй бөгөөд адислагдаж, хайрлагдсан хүмүүс
Ричард М.Ромни
Хосууд номлолд үйлчлэх нь бодсоноос ч илүү уян хатан, өртөг багатай, илүү таатай болохыг ойлгож авдаг.

34 Порнограф гэр бүлд нөлөөлсөн үед эхнэр, нөхөр хоёр хоёулаа эдгэрч илаарших хэрэгтэй
Нэрийг нууцлав
Порнографын асуудалд холбогдсон нөхрүүдэд төдийгүй эхнэрүүдэд нь ч мөн адил Аврагчийн эдгээлт хэрэгтэй байдаг талаар хэрхэн тусалдгаа нэгэн бишоп хуваалцсан юм.

38 Цамхаг дээрх харуулууд
Бошиглогчид хэрхэн цамхаг дээрх харуул мэт байдаг талаар суралцаж, бошиглогчдын талаарх ойлголтоо сайжруулаарай.

ӨГҮҮЛЛҮҮД

8 Эргэцүүлэл: Зааварчилгаа ойлгомжтой байна уу?
Рут Силвэр

9 Сүмд үйлчлэх нь: Таны үйлчлэлд баярлалаа
Нэрийг нууцлав

10 Сайн мэдээний сонгодог бүтээл: Санваар бол найдвартай зангуу
Ахлагч Л.Том Пэрри

40 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой

80 Биднийг дахин уулзтал: Сүнсний бэлгүүдийг эрэлхийлэх нь
Ерөнхийлөгч Жорж К.Каннон

ХАВТСАН ДЭЭР

Нүүрний хавтсан дээрх болон ар талын хавтасны дотор талын гэрэл зургийг Лэс Нилссон. Нүүрний хавтасны дотор таад: Гэрэл зургийг RayTango/Thinkstock



44 Сатаны худал хуурмагийг таних нь
Дэннис Гаунт
Бид Сатаны цуурхал ба Христийн сургаалуудын хоорондох ижил төстэй биш, харин ялгаатай зүйлсийг олж харснаар Сатаны худал хуурмагийг таньж мэдэж чадна.

48 Залуучуудын тухай хөрөг өгүүлэл: Мадагаскарын адислалыг хэмжих нь
Минди Энн Сэлү
Солофо Равеложона зовлон бэрхшээл ихтэй улс оронд амьдарч байгаа ч амьдралаа адислалуудаар дүүрэн болохыг мэдэрдэг.



Энэ дугаарт нуусан Лиакхонаг олоорой. Дөхүүлэх санаа: Энэхүү нууцын сэжүүрийг гаргахын тулд бошиглогчийг дага.

50 Сүнслэг тогтвортой байдал: Живдэггүй усан онгоц барих нь
Ахлагч Дэйл Г.Рэнланд

54 10 минутад дуулал тоглож сур
Даниел Картэр

57 Болихоор шийдсэн нь
Грэтчин Блэкбурн
Би төгөлдөр хуур тоглохоо болихын тулд юу ч хийхэд бэлэн байсан бөгөөд намайг 50 дуулал тоглоод сурчихвал цаашид тоглохоо больж болно гэж эцэг эхийгээ хэлэхэд нь дууллаудыг тоглож сурахаар болж, эхлэв.

58 Цочрол, харуусал, Бурханы төлөвлөгөө
Паола Кажупи
Би амьдралынхаа хамгийн аймшигтай үйл явдлыг эргэн хараад, тэр цаг үеийн туршид Тэнгэрлэг Эцэг надтай хамт байсныг мэдсэн юм.

60 Та ичимхий байсан ч
Ахлагч Хосе А.Тэхэйра
Их Эзэнд найд. Сайн мэдээг хуваалцах хичээл зүтгэлүүдэд тань Тэрээр та нарыг адислах болно.

62 Бидний орон зай

63 Зурагт хуудас: Идчихмээр гоё байна уу?

64 Асуулт, хариултууд
"Би хожмын үеийн гэгээнтэн гэдгээсээ болж сургууль дээрээ шоолуулдаг. Би итгэдэг зүйлийнхээ төлөө зогсох хэрэгтэйг мэддэг ч энэ нь үнэхээр хэцүү байдаг! Би хэрхэн хангалттай зоригтой болох вэ?"



66 Төлөөлөгчийн хариулт: Төлөөлөгчид юу хийдэг вэ?
Ахлагч Дэвид А.Бэднар

67 Зүрх сэтгэлийн амар амгалан
Кэрол Ф.Макконки
Би бошиглогчийг харж, ярихыг нь сонсохдоо амар амгаланг мэдэрсэн.

68 Итаны гэрчлэл
Ларри Хиллэр
Итанаас бусад нь гэрчлэлтэй юм шиг санагдаж байлаа.

70 Тэнгэрлэг Эцэгт өгөх песо
Анжела Пениа Доли
Мөнгө үлдээгүй тул Ана "Маргааш бид юу идэх юм бол?" гэж бодов.

72 Бошиглогч, төлөөлөгчдийг дагах нь
Женна Кофорд
Та энэ сард бошиглогчийг хэрхэн дагах вэ?

74 Мормоны Номын баатрууд: Алма наманчилсан нь

75 Би Мормоны Ном уншиж чадна

76 Мормоны Номын түүхүүд: Алма олон хүнд баптисм хүртээсэн нь

79 Будах хуудас: Хүндэтгэлийн өдөр бол онцгой өдөр

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,
Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Рассэлл М.Нэлсон,
Даллин Х.Өүкс, М.Рассэлл Баллард, Робэрт Д.Хэйлс,
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк,
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд
А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд

Эрхлэгч: Иосеф В.Ситати

Туслах редакторууд: Жэймс Б.Мартино, Кэрл Ф.Макконки

Зөвлөхүүд: Бриэн К.Эштон, Рэндэлл К.Бэннэтт, Крэг
А.Кардон, Шэрил А.Эсплин, Кристоффэл Голдэн, Даглас
Д.Холмэс, Ларри Р.Лорэнс, Кэрл М.Стэфэнс

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр

Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:

Винсэнт А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборт

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Мэган Вэрхөф

Редакцийн баг: Бриттани Бийти, Дэвид Диксон,
Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр,
Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жилл Хакин,
Шарлотт Ларкэбэл, Минди Аннэ Сэлу, Майкл Р.Моррис,
Салли Жонсон Оджөрк, Жосуа Ж.Пэркий, Жан Пинбороу,
Ричард М.Ромни, Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй
П.Андрус, Манди М.Бэнтли, С.Кимбалл Ботт, Том Чайлд,
Нэйт Гайнс, Коллийн Хинкли, Эрик П.Жонсон, Сюзан
Лодгрэн, Скотт М.Моой, Марк В.Робисон, Брэд Тизери,
К.Никол Вокэнорт

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун

Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Конни Ваугорп Бриж, Жоли Бардэтт, Кэти
Данкан, Брайн В.Гайги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон,
Гэйл Тэйт Раффэрти

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жэфф Л.Мартин

Хэвлэлийн захирал: Крэйг К.Сэдвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсэн.

Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон
үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон
тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт

liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд,
испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш,
маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш,
португали, румын, свахили, самоа, себуано, солонгос,
тагалог, тай, тахити, тонга, украин, унгар, урду, физи,
фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех,
швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх
дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2016 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гарт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиан олшруулж
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаягаар, эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

April 2016 Vol. 17 No. 2. LIAHONA (USPS 311-480) Mongolian
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,
June, July, October, and December) by The Church of Jesus
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake
City, UT 84150. USA subscription price is \$5.00 per year;
Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid
at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change
of address. Include address label from a recent issue; old and
new address must be included. Send USA and Canadian
subscriptions to Salt Lake Distribution Center at address below.
Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders
(Visa, MasterCard, American Express) may be taken by phone.
(Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлэл, үйл ажиллагаануудыг оруулав.
Доор нэг жишээ өгөгдсөн болно.



"Та ичимхий байлаа ч," 60-р хуудас: Та гэр бүлийнхээ үдшийг сайн мэдээ хуваалцахад ашиглаж болно! Таныг сайн мэдээг хуваалцахад ямар айдас саад болдог талаар гэр бүлээрээ ярилц. Сайн мэдээг хуваалцах итгэлтэй болоход тань туслахыг Их Эзэнээс гүйн, гэр бүлээрээ залбирч болох бөгөөд гэр бүлийнхээ үдэшт хэнийг урих талаар залбираарай. Энэ хичээлийн үеэр гэр бүлийн гишүүн бүрийг гэрчлэлээ хуваалцахад урь. Та Сэргээлт эсвэл Авралын төлөвлөгөө гэсэн сэдвээр хичээл заахаар сонгож болно. Санал бодлоо тэмдэглэлдээ бич.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИНТЕРНЭТЭЭС ҮЗЭЖ БОЛНО

Лиахона болон Сүмийн бусад материалыг олон хэлээр languages.lds.org хаягаар орж үзэж болно. Сүнслэг захиас, гэр бүлийн үдшийн санаа, найзуудтайгаа болон гэр бүлийнхэнтэйгээ хуваалцаж болох зүйлүүд зэргийг олж мэдэхийг хүсвэл [facebook.com/liahona.magazine](https://www.facebook.com/liahona.magazine) хуудас руу орно уу (англи, португаль, испани хэл дээр байгаа).

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Авьяас, 40, 54

Айлчлагч багшлалт, 9

Амар амгалан, 50, 67

Аравны нэг, 62, 70

Ариун Сүнс, 44, 50

Баптисм, 75, 76

Бошиглогч, төлөөлөгчид, 10, 12, 66, 67, 72

Бурханлаг шинж чанар, 7

Гэрчлэл, 64, 68

Дуудлагууд, 18

Дуулгавартай байдал, 8, 34, 62, 72

Дуу хөгжим, 54, 57

Есүс Христ, 20, 34, 43, 58

Заах, 75

Залбирал, 41, 64

Зарлигууд, 8, 72

Зориг, 48, 64

Идэвхжүүлэх нь, 18

Иллэлт, 4, 10, 20, 41, 42, 50, 70, 72

Итгэл, 34, 48, 58, 60

Мормоны Ном, 43, 44

Наманчлал, 18, 74

Номлолын ажил, 26, 28, 60

Өршөөл, 34

Порнограф, 34

Судрууд, 20

Сүнслэг бэлгүүд, 80

Уй гашуу, 58

Үйлчлэл, 9, 26, 28, 41

Үнэнч шударга байдал, 62

Хайр, 40

Худал хуурмаг, 44, 63

Хүндэтгэлийн өдөр, 79

Хөрвөлт, 43, 58, 75, 76

Цагаатгал, 34

Шавь байх нь, 12, 26



**Ерөнхийлөгч
Хэнри Б.Айринг**

Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх

Бошигглол БА ХУВИЙН ИЛЧЛЭЛТ

Есүс Христийн үнэн Сүм сэргээгдсэн бөгөөд өнөөдөр дэлхий дээр оршин байна. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм тэнгэрээс удирдамж байнга хүлээн авдаг амьд бошиглогч, төлөөлөгчдөөр удирдуулсаар ирсэн билээ.

Энэ бурханлаг хэв маяг эрт дээр үед ч байсан юм. Бид Библиээс “Үнэхээр Эзэн БУРХАН зарц нар, эш үзүүлэгчдэдээ Өөрийн нууцыг илчлэхээс нааш Тэр юуг ч хийхгүй” (Амос 3:7) гэдгийг мэдэж авдаг.

Бурхан бошиглогч Иосеф Смитээр дамжуулан бидний цаг үед дахин ярьсан. Тэр бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Есүс Христийн сайн мэдээний бүрэн дүүрэн байдлыг илчилсэн. Тэр Өөрийнхөө ариун санваарыг түлхүүрүүд ба бүх эрх, чадал, санваарын хүчийн ариун чиг үүргүүдийн хамт сэргээсэн билээ.

Бидний өдрүүдэд амьд бошиглогч, төлөөлөгчид Бурхан Эцэг ба Их Эзэн Есүс Христээс хүлээн авсан эрх мэдлээр үг хэлэх, сургах, удирдан чиглүүлэх эрхтэй. Их Эзэн бошиглогчид “Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, мөн би өөрийгөө зөвтгөх нь үгүй; мөн тэнгэр хийгээд газар үгүй болсон ч, миний үг алга болох нь үгүй, харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” хэмээн хэлжээ (С ба Г 1:38).

Бид жилд хоёр удаа болдог Ерөнхий чуулганы үеэр Их Эзэний бидэнд хандсан үгийг Түүний үйлчлэгчдээс сонсох боломжоор адислагддаг. Энэ бол үнэлж баршгүй боломж юм. Гэхдээ уг боломжийн үнэ цэн нь бид

тэдгээр үйлчлэгчид өгөгдсөн үгсийг яг тэр Сүнсний нөлөөн дор хүлээн авч чадаж байгаа эсэхээс хамаардаг (С ба Г 50:19–22-ыг үзнэ үү). Тэд тэнгэрээс удирдамж хүлээн авдаг шиг бид ч бас хүлээн авч байх ёстой. Энэ нь биднээс адил хэмжээний сүнслэг хүчин чармайлт гаргахыг шаарддаг.

“Гэрийн даалгавраа хий”

Хэдэн жилийн өмнө Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийн нэг нь надаас түүний Ерөнхий чуулганд бэлтгэсэн үгийг уншиж өгөхийг хүссэн юм. Би тэр үед тухайн чуулгын шинэхэн гишүүн байлаа. Надад итгэл найдвар хүлээлгэн, Их Эзэний ярих байсан үгийг олоход түүнд туслах боломжтой болсон нь миний хувьд нэр төрийн хэрэг байлаа. “Энэ бол хэлэх үгийн маань 22 дахь ноорог байгаа юм” гэж тэр надад инээмсэглэн хэлэв.

Тэгэхэд би бидний хайрт, хүндэт ерөнхийлөгч Харолд Б.Лий (1899–1973) гуайн ихэд анхааруулж хэлж байсан: “Сонс, хэрэв чи илчлэлт хүлээн авахыг хүсэж байгаа бол гэрийн даалгавраа сайн хийж бай” гэсэн зөвлөгөөг санаж билээ.

Би тэрхүү 22 дахь нооргийг сайтар уншиж, тунгаан бодоод, залбирсан юм. Би Ариун Сүнсний нөлөөн дор хамаг чадлаараа түүнийг судлав. Чуулганы гишүүн үгээ хэлэх цаг болох үед би гэрийн даалгавраа хийсэн байлаа. Би түүнд тусалсан эсэхээ мэдэхгүй ч тэрхүү үгийг сонсохдоо өөрчлөгдсөн гэдгээ мэддэг. Миний уншсан



болон түүний хэлж байсан үгсээс илүү утга учир бүхий захиас надад ирсэн юм. Үг бүр нь нооргон дээрээс уншсанаас илүү агуу утга учиртай байлаа. Тэрхүү захиас надад зориулагдаж, миний хэрэгцээнд тохирсон зүйл байв.

Бурханы үйлчлэгчид илчлэлт ба сүнслэг удирдамж хэрэгтэй хүмүүст зориулан Түүний өгөх захиасыг хүлээн авахын тулд мацаг барьж, залбирдаг. Энэ явдлаас мөн үүнтэй адилхан олон туршлагаас миний мэдэж авсан зүйл бол бид амьд бошиглогч, төлөөлөгчдийг сонсоод агуу үр

ашгаас нь хүртэхийн тулд өөрсдөө илчлэлт хүлээн авах төлөөсийг төлсөн байх ёстой явдал юм.

Их Эзэн захиасыг нь сонсдог хүн бүрд хайртай бөгөөд хүн бүрийн зүрх сэтгэл, нөхцөл байдлын талаар сайн мэддэг. Тэр хэрхэн засаж зүгшрүүлэн, ямар урам дэм өгөхийг мөн эрэгтэй, эмэгтэй хүн бүрд мөнх амьдралд хүрэх замаа олж сонгоход сайн мэдээний ямар үнэн хамгийн их тус болж чадахыг мэднэ.

Бид Ерөнхий чуулганы захиасуудыг сонсож, үзсэнийхээ дараа “Би юуг хамгийн сайн санаж байгаа

билээ?” гэж асуух нь бий. Их Эзэн бидний хүн нэг бүрийг: “Би Тэнгэрлэг Эцэгээ болон Аврагчаа баярлуулахын тулд юу хийх ёстойг хэлэх Сүнсний дуу хоолойг зүрх сэтгэлдээ мэдэрсэн тэр агшныг хэзээ ч мартаггүй” гэж хариулна хэмээн найддаг.

Ерөнхийлөгч Лийгийн хэлсэнчлэн, бид бошиглогч, төлөөлөгчдийг сонсохдоо үүнийг хүлээн авна гэсэн итгэлтэйгээр хөдөлмөрлөвөл тэрхүү хувийн илчлэлтийг хүлээн авч чадна. Би энэ нь үнэн гэдгийг өөрийн туршлагаас мөн Сүнс гэрчилснээр мэддэг. ■

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Ерөнхийлөгч Айрингийн чуулгынхаа гишүүний Ерөнхий чуулган дээр хэлэх үгийн нооргийг судалсан тухай түүхийг чанга унших талаар бодож үз. Та “Илчлэлт хүлээн авахын үнэ цэн юу вэ?” гэж асууж болно. Та ярилцсаныхаа дараа

зочлон очиж буй хүмүүсээ ирэх Ерөнхий чуулганы захиасыг “тэдгээр үйлчлэгчид өгөгдсөн яг тэр Сүнсний нөлөөнд” хүлээн авах талаар тунгаан бодож, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхэд урьж болно.

Тэнгэрлэг Эцэг Ерөнхий чуулганы үгээр дамжуулан надтай ярьсан

Анн Лалэска Алвэс дэ Суза

Би их сургуульд юу судлахаа мэдэхгүй эргэлзэж байлаа. Ихэнх хүн миний судлахыг хүссэн хичээлийн талаар ам муутай байсан учраас би Их Эзэнд хандан миний шийдвэрийг зөвшөөрөх эсхийг нь мэдэх гэж залбирсан юм.

Маргааш нь намайг *Лиахона* дээр гарсан Ерөнхий чуулганы үгийг уншиж байхад хариулт маань ирэв. Тэнгэрлэг Эцэг надад хандан, миний өмнөөс сонголт хийж чадахгүй гэдгээ хэлж байгаа мэт, энэ шийдвэрийг би өөрөө л гаргах ёстой гэж санагдаж билээ. Би юуг ч сонгосон бай, амжилттай байхын тулд шаргуу хөдөлмөрлөх ёстой гэдгээ мэдэж байлаа.




Би миний залбирал хариулагдсан гэдгийг мэднэ. Ариун Сүнсний баталгаа шийдвэр гаргахад маань тусалсан. Би хамаг хүчээ хэрхэн дайчлахыг сурсан бөгөөд Тэнгэрлэг Эцэг надад тусална гэдгийг мэднэ.

Зохиогч нь Бразилийн Сэржистид амьдардаг.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Бошиглогчийг дага

Бошиглогч, төлөөлөгчид Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христийн өмнөөс ярьдаг. Тэд бидэнд Есүсийг хэрхэн дагахыг зааж сургадаг. Бошиглогч, төлөөлөгчдийн биднээс хийхийг хүссэн зарим зүйлд хүргэх замыг дагаарай.



Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ олж мэдэхийг эрэлхийл. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийн талаар ойлголттой байх нь хэрхэн Бурханд итгэх итгэлийг тань нэмэгдүүлж, айлчлагч багшийн ажлаар дамжуулан харж ханддаг хүмүүсийг тань адислах вэ? Нэмэлт мэдээлэл авах бол reliefsociety.lds.org хаягаар орж үзнэ үү.

Мөнхийн Эцэгийнхээ охид

Суарууд “бид Бурханы үр удам” гэдгийг бидэнд заадаг (Үйлс 17:29). Бурхан бошиглогч Иосеф Смитийн эхнэр Эмма Смитэд “охин минь” хэмээн хандан ярьсан байдаг (С ба Г 25:1). Гэр бүлийн тунхаг нь бид бүгдийг “тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг . . . охин нь юм”¹ гэж заадаг.

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Кэррол М.Стэфэнс “Бид тэрхүү [мөнх бус байдлын өмнөх] амьдралд эмэгтэй хүнийхээ мөнхийн онцлог шинж чанарын талаар суралцсан” гэж хэлсэн билээ.

“Бидний энэ дэлхий дээрх мөнх бус амьдралын аян эдгээр үнэнийг өөрчлөөгүй.”²

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд “Тэнгэр дэх Эцэг тань таны нэрийг болон таныг ямар нөхцөл байдалд байгааг мэддэг” гэж хэлсэн. “Тэр таны залбирлыг сонсдог. Тэр таны найдвар, мөрөөдөл, айдсыг болон санааг тань зовоож буй зүйлсийг мэддэг.”³

“Бидний хүн нэг бүр Бурханы гэр бүлд харьяалагддаг бөгөөд энэ гэр бүлд хэрэгтэй байдаг” гэж



Стэфэнс эгч хэлжээ. “Дэлхий дээрх гэр бүлүүд бүгд өөр өөр бөгөөд өөр хоорондоо адилгүй байдаг. Бид бат бэх уламжлалт гэр бүлийг бий болгохоор чадах бүхнээ хийж болох ч Бурханы гэр бүлийн гишүүн байх эсэх нь өөр бусад ямар ч харилцаанаас эсвэл өөр ямар ч нөхцөл байдлаас, тухайлбал гэрлэсэн болон эцэг эх болсон эсэх, мөн санхүүгийн болон нийгмийн байдал, эсвэл бүр олон нийтийн мэдээллийн хуудсан дээр хуваалцсан зүйлс зэрэг ямар ч зүйлсээс хамаардаггүй билээ.”⁴

Нэмэлт судрууд

Иеремиа 1:5; Ром 8:16; Сургаал ба Гэрээ 76:23–24

ЭШЛЭЛҮҮД

1. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Liahona*, 2010 оны 11-р сар, 129.
2. Кэррол М.Стэфэнс, “Бурханы гэр бүл,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 129.
3. Жэффри Р.Холланд, “Залуу эмэгтэйчүүдэд,” *Liahona*, 2005 оны 11-сар, 28.
4. Кэррол М.Стэфэнс, “Бурханы гэр бүл,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 129.
5. topics.lds.org вэбсайт дээрх Сайн мэдээний сэдвүүдээс “First Vision Accounts” гэснийг үзээрэй.

Үүнийг эргэцүүлэн бод

Та Бурханы охин гэдгээ мэдэх нь шийдвэр гаргахад тань хэрхэн нөлөөлөх вэ?

Итгэл, гэр бүл,
халамж



Бидний түүхээс

Бошиглогч Иосеф Смит Анхны үзэгдлийн тухай цэдэгтээ Тэнгэрлэг Эцэг маань бидний нэрийг мэддэг зэрэг хэд хэдэн үнэнийг мэдэж авсан тухайгаа дурдсан байдаг.⁵

Залуу Иосеф аль сүмд нэгдэх ёстойгоо мэдэх гэж хичээж байсан бөгөөд Иаков 1:5-аас удирдамж авсан. Иосеф Бурханаас асуух болно гэж шийдсэн юм.

Түүнийг 1820 оны хаврын нэгэн өглөө ойд очин залбирахад ямар нэг харанхуйн хүч нэн даруй эзэмджээ. Тэрээр энэ тухай бичихдээ:

“Яг тэр мөчид, өөрийнхөө чанх орой дээр нарнаас илүү хурц гэрэлтэй гэрлэн багана над уруу алгуурхан доош бууж ирэхийг би харлаа.

“Намайг хүлсэн тэрхүү дайснаас миний бие чөлөөлөгдсөн нь удалгүй мэдэгдэв. Мөнөөх гэрэл над дээр тогтоход гялалзсан өнгө хийгээд алдар сууг нь дүрслэхийн аргагүй хоёр Хүн миний дээр агаарт зогсож байхыг би харав. Тэдний нэг нь надтай ярьж, намайг нэрээр минь дуудан мөн нөгөөх уруугаа зааж хэлэв—Энэ бол Миний Хайртай Хүү. Түүнийг сонс!” гэжээ (Иосеф Смит—Түүх 1:16–17).

ЗААВАРЧИЛГАА ОЙЛГОМЖТОЙ БАЙНА УУ?

Рут Силвэр

Унадаг дугуйн аялал маань Их Эзэний замын газрын зургийг байнга эргэн харж, хянаж байх ёстой гэдгийг ойлгоход тусалсан юм.

Хэдэн жилийн өмнө би өөрийн эгч, бэр эгч мөн түүний охинтой хамт Францад дугуйгаар аялж билээ. Өглөө бүр бидэнд яг дагах юм бол биднийг тэр өдрийн очих ёстой газарт хүргэх гурван хуудас нарийн зааварчилгаа өгдөг байв. Бид усан үзмийн талбайг өнгөрөн явж байтал, зааварчилгааны дагуу хойд зүг рүү 165 тохой (50 м) яваад, зүүн гар тал руу эргэж 330 тохой (100 м) явахыг зөвлөсөн байсан. Ихэнх тохиолдолд зааварчилгаа нь чухал замын тэмдэг ба дайран өнгөрөх гудамжнуудын нэрсийг зааж өгч байв.

Нэгэн өглөө бид сонирхол татсан гудамжаар орж явтал уг газар зааварчилгаанд тусгагдаагүй болохыг тэр даруй анзаарлаа. Бид тэрхэн зуур төөрөлдөж, хамгийн сүүлд зөв байсан гэж мэдэх газар руугаа буцаж, тэнд очоод хааш явахаа олохоор шийдсэн юм.

Яг л бодсоныхоо дагуу бид тэнд очоод, зааварчилгаанд заасан байсан ч анзааралгүй өнгөрсөн замын жижиг тэмдгийг олж харав. Удалгүй бид дахин зөв зам дээрээ гарч, зааврын дагуу аяллаа үргэлжлүүлж

болохуйц бүх зүйл ойлгомжтой болсон байлаа.

Энэ явдал оньсого мэт байсан дараах асуултад маань хариулт өгсөн юм. Хэн нэгэн хүн сайн мэдээний талаар гэрчлэлтэй байсан мөртлөө яагаад Сүмээ орхин явдаг юм бол? Хэрэв бид буруу зүг рүү (нүгэл рүү) эргэх юм уу Бурханы зарлигуудыг дагахдаа алдаа гаргавал, зааварчилгаа (Бурханы үг) ойлгогдохоо больдог юм байна гэдэг нь надад тодорхой болсон юм. Өгөгдсөн газрын зураг нь бидний байгаа газарт тохирохоо больдог гэсэн үг. Хэрэв бид хэт хадуурч холдоогүй л бол алдаа гаргасан нь буруу гэдгээ хүлээн зөвшөөрч, буцаж эргэх (наманчлах) эсвэл Бурханы зарлигласны дагуу зөв гэж мэдэж байсан тэр замаа дагах талаар дахин шийдвэр гаргаж болно.

Байгаа газарт маань зааварчилгаа тохирохоо больсон үед бид ихэнхдээ зааварчилгаа зөв эсэхэд эргэлздэг. Бид буцаж явахын оронд зааварчилгааг буруутгаж, түүнийг дагахаа бүр больдог. Эцэст нь хэлэхэд, бид очих ёстой газрынхаа

талаарх алсын хараагаа алдсанаар төөрөлдөж, түр зуурын сонирхол татахуйц сайхан газруудаар явдаг ч тэдгээр нь биднийг очих ёстой газарт маань хүргэдэггүй.

Бид өдөр бүр судраас суралцах боломжтой. Мөн бид зургаан сар тутамд Сүмийнхээ ерөнхий чуулганд оролцох боломжоор хангагдсан байдаг. Энэ л цаг үед бид замынхаа газрын зургийг сайтар харж, судалж, хаана хүрэх ёстойгоо баталгаатай мэдэж авах нь чухал биш гэж үү? Би нэгэн удаа Ерөнхий чуулганыг сонсож байхдаа хэдийгээр бид төгс бус ч гэлээ, хэрэв бид зааварчилгаануудаа бүрэн ойлгож байвал зөв зам дээр явж байгаагаа мэдэж болох юм гэдгийг мэдэрсэн юм.

Зөв чигийг дагах нь биднийг энэ амьдралын хүрэх ёстой газруудад хүргэх учир бид судраас суралцаж, амьд бошиглогчдын зөвлөгөөг дагаснаар явж буй замаа хянан, шаардлагатай үед зүг чигээ өөрчлөх боломжтой болж, эцэст нь селестиеал гэртээ хүрч очих болно. ■

Зохиогч нь АНУ-ын Колорагод амьдардаг байсан бөгөөд өнгөрсөн жил нас барсан.



ТАНЫ ҮЙЛЧЛЭЛД БАЯРЛАЛАА

Нэрийг нууцлав

Та бол Наувугийн өдрүүдээс өнөөг хүртэлх хугацаанд бие биенээ хайрлах сэтгэл, сүнслэг өдөөлтөөр дүүрэн байж, айлчлагч багшийн хувьд нэг нэгэндээ үйлчилдэг байсан тэр эмэгтэйчүүдийн үлгэр дуурайл юм.

Би таны нэрийг болон хэдэн настай болохыг чинь ч мэдэхгүй. Би таны талаар өөр ямар ч зүйлийг мэдэхгүй. Харин би таныг Жоанны айлчлагч багш гэдгийг мэддэг. Таныг бүх зүрх сэтгэлээрээ, чин сэтгэлээсээ үйлчилдэг учраас би танд талархаж явдаг юм.

Миний бэр Жоанн (нэрийг нь өөрчлөв) шиг идэвх султай эгчийнд айлчлагч багшаар очих нь тийм ч амархан зүйл биш гэдгийг би мэднэ. Ялангуяа тэр эгч тийм ч найрсаг биш бол. Эхэндээ тэр таныг ирээсэй гэж хүссэн гэдэгт би эргэлзэж байсан. Гэвч Жоанны хэлснээр та түүнд жинхэнэ найз шиг нь ханддаг байсан юм билээ. Та түүний ямаршуу байгааг харахаар эргэж очдог байсан бас түүнийг байгаагаар нь л хүлээж авсан.

Жоанн хүүтэй минь гэрлэснээс хойш 19 жил өнгөрөхөд анх удаа айлчлагч багштай болсноо дурдсан нь энэ л дээ. Тэр таныг хэр тогтмол ирдгийг, мөн хэчнээн ухаалаг, эелдэг зөөлөн ханддагийг саяхан надад ярьж өгсөн. Та түүнийг өвчтэй байхад олон ч удаа тусалж, тэр ч байтугай манай ач охиныг Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт хүргэж өгөхийг санал болгож байсан гэсэн.

Сүүлийн арван жилийн туршид хүү, бэр хоёр маань гэр бүлтэйгээ



манайхаас хэдэн зуун бээрийн хол амьдарч байсан. Би тэднийг хэрхэн хайрладаг шиг бусад олон хүн тэднийг хайрлаж, халамжлаасай хэмээн үргэлж залбирч байсан бөгөөд тэд надтай ойр амьдардаг байсан бол би хэрхэн туслах байсантай адил тэдэнд бусад хүн туслаасай гэж нүдэндээ нулимстайгаар Тэнгэрлэг Эцэгээс гуйж байсан билээ. Жоанны хэлснээр, та бол миний залбирлын хариу юм.

Жоанн, манай хүү хоёр мэргэн ухааны үгийг дагадаггүй, сүмд явдаггүй боловч сайн хүмүүс хэвээр байж, хүүхдүүдээ хайрладаг. Ямар ч байсан таны нүдийг Жоанны татдаг тамхины утаа бүрхчихээгүй л юм байна. Та түүнийг сүмд явдаг, явдаггүйгээр нь тодорхойлоогүй.

Та түүнтэй танилцсанаараа түүнийг охиноо сүмд явуулж, гэрчлэлтэй болгохыг хүсдэг тийм л хайр татам ээж болохыг мэдэж авсан. Жоанныг хагалгаанд орох үед та түүнийг эрүүл мэндээ өөрөө хохироосон эсэхийг лавлахын оронд түүнд оройн хоол авчирч өгсөн.

Та миний ач охинд сайн үлгэр жишээ үзүүлж байгаад би ямар их талархаж байна гээч. Тэр таныг хүн болгонд санаа тавьдаг, хайраа илэрхийлэхийн тулд чадах бүхнээ хийдэг нэгэн гэж харж, үлгэр жишээ авна. Та нэг өдөр машингүй байхдаа, түүнд жигнэмэг авчирч өгөхийн тулд бага хүүхдүүдийнхээ хамт бүтэн бээр алхаж ирсэн тухай тэр надад ярьсан.

“Би чиний тухай болон ээжийн чинь тухай бодож байгаад, та нарт нэг сайхан зүйл хийхийг хүссэн. Зүгээр л тэгмээр санагдсан” гэж та түүнд хэлсэн байсан.

Айлчлагч багшийнхаа дуудлагад хичээл зүтгэл гаргаж байгаад тань би хэчнээн их талархаж байгаагаар танд хэлмээр байна. Та бол Наувугийн өдрүүдээс өнөөг хүртэлх хугацаанд бие биенээ хайрлах сэтгэл, сүнслэг өдөөлтөөр дүүрэн байж, айлчлагч багшийн хувьд нэг нэгэндээ үйлчилдэг байсан тэр эмэгтэйчүүдийн үлгэр дуурайл юм. Та идэвх султай бэр дээр минь ирэхдээ үйлчлэл, хайрыг чин сэтгэлээсээ харуулж чадсан билээ.

Танд баярлалаа. ■



**Ахлагч
Л.Том Пэрри
(1922–2015)**

Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын ахлагч

САНВААР БОЛ НАЙДВАРТАЙ ЗАНГУУ

Ахлагч Л.Том Пэрри энэ өгүүллийг залуу санваартнуудтай хуваалцахаар 2015 оны 5-р сарын 28-нд буюу нас барахаасаа 2 хоногийн өмнө бэлдсэн байв.

Миний амьдралын хамгийн агуу хүч чадал нь Бурханы санваар юм. Санваар нь залуу эрэгтэйчүүд та нарын хувьд ч бас найдвартай зангуу байх болно гэдэгт би итгэдэг. Ийм хүчийг амьдралдаа байлгахын тулд та нар үүнийг ойлгож, ашиглах шаардлагатай.

Санваартай холбогдох эхэн үеийн туршлагууд

Миний бие Юта мужийн Логан хэмээх тав тухтай сайхан газар өссөн билээ. Би хүүхэд насандаа хоол хүнс, гэр орон эсвэл боловсролын талаар санаа зовох зүйлгүй байлаа. Гэвч амьдрал амар хялбар байсан учраас зангуу болж тогтоох ямар нэгэн зүйлээс зууран авах нь надад шаардлагатай байсан байх.

Миний хувьд тэрхүү зангуу нь Бурханы санваар болсон юм. Би онцгой нөхцөл байдалд өсөж торнисон. Миний эцэг намайг нэг настай байхад бишопоор дуудагдсан бөгөөд 19 жилийн туршид манай бишопоор үйлчилсэн юм. Түүний өгсөн эцгийн болон сүнслэг удирдамж надад маш их тус дэм болдог байсан.

Тийм ч учраас би 12 насныхаа төрсөн өдрөөр Аароны санваар хүлээн авахыг тэсэн ядан хүлээж

байж билээ. Аав минь миний толгой дээр гараа тавьж, Аароны санваарын эрх мэдлийг өгсөн тэр онцгой өдрийг би санаж байна. Дараа нь би Аароны санваарын бүх албанд ахисан бөгөөд дуудлага хүлээн авахдаа маш их баяртай байдаг байв.

Ариун ёслолыг түгээх нь миний хувьд маш онцгой байдаг байсан. Хүмүүс Их Эзэний бие, цусыг төлөөлсөн бэлгэ тэмдгээс хүртэхдээ Түүнд өөрсдийгөө дуулгавартай байлгаж, Түүний зарлигуудыг дагана гэдгээ амлаж байгааг та харах боломжтой байдаг.

Санваарын талаарх ойлголт өсөх нь

Цаг хугацаа өнгөрч, би дунд сургуулиа төгсөөд, дараа нь коллежид нэг жил суралцаж байхдаа номлолд үйлчлэхээр дуудагдав. Би номлолынхоо агшин бүрд аз жаргалтай байж, хамтрагчдадаа ч хайртай байсан. Ялангуяа нэг нь надад маш их хүч чадал өгсөн юм. Би түүнтэй хамт үүрэг хариуцлагаа гүйцэтгэж байхдаа түүнээс их зүйл сурч авсан.

Улс орон маань дэлхийн дайнд оролцож байсан тул би номлолоос буугаад Нэгдсэн Улсын Тэнгисийн явган цэрэгт үйлчлэхээр нэгдсэн юм. Дайн дууссаны дараа би коллежид эргэж орсон бөгөөд гэрлэж, гэр бүлтэй болсон. Би мэргэжлийнхээ дагуу Нэгдсэн Улс даяарх олон газарт очиж ажиллахдаа санваарын олон

дуудлагад үйлчилж, их ч зүйл олж мэдсэн. Эцэст нь би Массачусетс муж улсын Бостон хотод суурьшиж, тэнд гадасны ерөнхийлөгчөөр үйлчлэх болсон юм. Тэнд байхдаа би эхлээд Арванхоёрын туслахаар дуудагдаж, 17 сарын дараа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад дуудагдсан.

Төлөөлөгчийн хувьд суралцсан зүйлс

Би Арванхоёрын чуулгад гишүүн байхдаа юу мэдэж авсан бэ?

Санваарт хөтөч, зангуу мөн хамгаалалт байдаг гэдгийг би мэдэж авсан.

Санваар нь үргэлжид байсан. Адамыг газар дэлхий дээр ирэхээс өмнө түүнд санваарын эрх мэдэл байсан. Адамын үр удам санваарын эрх мэдэлтэйгээр тарцгаасан учраас санваарыг захирахын тулд зохион





байгуулах шаардлагатай болсон билээ. Их Эзэн Абрахамыг өөрийн санваартан бүхий гэр бүлийн дээр тэргүүн нь байхаар дуудсан. Энэхүү зохион байгуулалт Исаакийн болон Иаковын дор үргэлжилж, хожим нэр нь Израиль болж өөрчлөгдсөн юм.

Олон зууны дараа Израилийн хүүхдүүдийг боолчлолд ороход тэднийг чөлөөлөхөөр Их Эзэн Мосег илгээсэн боловч тухайн үед ард түмэн Мелкизедек санваарыг хүлээн авахад бэлэн биш байгаагаа харуулсан. Тиймээс тэд Аврагчийг ирэх хүртэл Аароны санваартайгаа үлдсэн.

Аврагч үйлчлэлээ эхлүүлэхдээ юуг түрүүлж хийсэн нь тун сонирхолтой байдаг. Тэр Мелкизедек санваарыг зохион байгуулсан. Тэрээр Арванхоёр төлөөлөгчийг дуудаж, санваарын хуулиуд, ариун жаягийн тухай заасан. Аврагч Петрийг гол

төлөөлөгчөөр дуудаж, Өөрийн Сүмийн эрх мэдлийн шугамыг байгуулсан юм. Тэр өдрүүдэд ч өнөө үед ч Есүс Христ Сүмийг тэргүүлж удирдах гол төлөөлөгчөө сонгодог бөгөөд түүнийг санваарын үүргүүдэд нь удирдан чиглүүлдэг.

Тиймээс санваар нь Их Эзэнээс гол төлөөлөгчөөр дамжин бусад төлөөлөгч, Сүмийн санваартнуудад хүрдэг шулуун шугам юм. Эрх мэдлийн түлхүүрүүд төлөөлөгчдөд өгөгдөж мөн тэдгээр түлхүүр газар дэлхий дээр байгаа цагт Их Эзэн Өөрөө биднийг удирдах болно. Энэхүү бурханлаг удирдлага нь биднийг хамгаалж байдаг бөгөөд Сүм үнэнээс хазайхгүй гэдгийг бидэнд баталж өгдөг. Сүмийг дэлхийн ямар нэгэн амьд бие удирддаггүй тул үргэлж тогтвортой хэвээр байдаг. Их Эзэн Сүмийг удирддаг.

Санваарын тухай сургаалуудаас суралцах

Залуу эрэгтэйчүүд та бүгдэд өгөх миний хамгийн том зөвлөгөө бол санваарын тухай сургаалуудаас суралцаж, санваарын эрх мэдлээ хэрэгжүүлэх үедээ авах хүч чадлыг ойлгосноор энэ нь та бүгдийн болон бусдын амьдралыг хэрхэн адисалдагт суралцах явдал юм.

Хэрэв та бүхэн санваарын тухай сургаалуудаас суралцаж, санваарын үүрэг хариуцлагаа биелүүлэх юм бол санваар та нарыг сүнслэгээр аюулгүй байлгаж мөн та нарт баяр хөөр авчрах найдвартай зангуу байх болно. Санваарын чуулгадаа үнэнч бай. Найз нөхдөдөө хүрч ажиллан, тэднийг чуулгадаа урьж авчир. Чуулгадаа та бүхний амьдралын байнгын үндэс болох ахан дүүсийн барилдлагыг бий болго. ■

Ахлагч Роналд А.Расбанд

АВЪЯАСЛАГ
УДИРДАГЧ,
ҮНЭНЧ ЭЦЭГ

Ахлагч М.Рассэлл Баллард

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Рон Расбанд бүрэн цагийн номлолд үйлчилнэ гэдэгтээ хэзээ ч эргэлзэж байгаагүй. 19 настай түүнийг номлолынхоо дуудлагын дугтуйг задлах үед оюун санаанд нь *хаана* үйлчлэх тухай ганц л асуулт байлаа.

“Аав маань Германд номлолд үйлчилсэн. Ах маань мөн Германд номлолд үйлчилсэн. Ирээдүйн хүргэн ах маань ч бас Германд үйлчилсэн” хэмээн тэр санав. “Би өөрийгөө Герман руу л явах байх гэж бодож байлаа.”

Гэвч Их Эзэнд өөр төлөвлөгөө байсан юм. Рон АНУ-ын Нью-Йорк хотын төвд байдаг Ийстэрн Стэйтс Номлолд дуудагдажээ. Сэтгэлээр унасан тэрээр дуудлагын хуудсаа унтлагын өрөөндөө авч орон, орныхоо дэргэд өвдөг сөгдөн залбираад, судраа таамгаар нээн уншиж эхэлжээ.

“Болгоогтун, мөн харагтун, энэ газарт мөн эргэн тойрны нутгуудад надад их хүмүүс буй; мөн *дорнын* энэ нутаг дахь эргэн тойрны нутгуудад үр дүнтэй хаалга нээгдэх болно.

Тиймийн тул, Их Эзэн бибээр энэ газарта нарыг очихыг зөвшөөрч байна; учир нь энэ нь бодгалиудын авралын тулд надад шаардлагатай байна” (С ба Г 100:3–4; тодотгол нэмэгдсэн).

Ариун Сүнс тэр даруй Ийстэрн Стэйтс Номлолд дуудагдсан дуудлага нь буруу зүйл байгаагүй гэдгийг Ронд баталсан байна.


“Их Эзэний намайг явуулахыг хүссэн тэр газар нь энэ байна гэгдэх олон судрын



илэрхийлэлтийн анхныхыг мэдэрснээр би сэтгэл гутралаас ангижирсан юм” хэмээн тэр дурсав. “Энэ нь миний хувьд амьдралыг маань өөрчилсөн сүнслэг туршлага болсон юм.”

Зүүн мужууд дахь номлол нь түүнийг очно гэж төсөөлж байгаагүй газруудад нь аваачих Сүмийн хэд хэдэн дуудлагын анхных байв. Ахлагч Роналд А.Расбанд багш, бишоп, дээд зөвлөх, номлолын ерөнхийлөгч, Далын гишүүн, Далын ахлах ерөнхийлөгч, Их Эзэн Есүс Христийн төлөөлөгч зэрэг дуудлага бүрээр Бурханы хүүхдүүдэд үйлчлэх үедээ Их Эзэний Сүнсэнд найдаж, Түүний хүслийг хүлээн зөвшөөрч байжээ.

Баруун дээд талд: Ахлагч Роналд А.Расбанд 1998 онд Нью-Йорк хотод номлолын ерөнхийлөгч байхдаа. Хамгийн баруун талын зурагт: Ахлагч Расбанд эгч Нэнси Шиндлэр, ээж, хоёр ах Рассэлл, Нийл нарын хамт. Баруун талд: Долоон настай Рон эцэг эхийнхээ хамт.



Рон ер нь сайн хүү байсан ч дэггүй гэдгээ өөрөө хүлээн зөвшөөрдөг байв.

Тэрээр: “[Хүүхдийн хэсгийн] багш маань тухайн үед гадасны Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгч байсан ээжид маань хэд хэдэн удаа ‘Ронни Расбанд тун дүрсгүй хүүхэд шүү’ гэж хэлж байсан” гэж дурсаж билээ. “Тэвч тэд хэзээ ч надад бууж өгөөгүй.

Тэд надад агуу хайрыг харуулж, намайг ангидаа үргэлж урьдаг байсан.”²

Роны хүүхэд нас Сүмд—тойргийн цуглаан, үдэшлэг, оройн зоог болон тойргийн спорт багуудад төвлөрсөн байдаг байв. Тэрээр Коттонвүүд нэгдүгээр тойргийн цуглааны байран дээр байхгүй байгаагүй үедээ янз бүрийн ажил хийж, скаутын үйл ажиллагаанд оролцож, найзуудтайгаа хамт байдаг байлаа. Гэртээ гэр бүлийн цагаа судар, тоглоом, гэрийн ажлуудад төвлөрүүлдэг байв.

Тэрээр “Аав маань надад ажил гэж юу болохыг үлгэр жишээгээрээ харуулсан. Ээж минь ажил гэж юу болохыг надад ажил хийх боломж өгснөөр заасан” гэж хэлжээ.

Роны аав талх түгээх тэрэг барьдаг байсан ба өглөө бүр 4 цагт босож, орой бүр гэртээ оройтож ирдэг байж. Ээж нь гэртээ хүүхдүүдээ харангаа шаазан хүүхэддэй хийж, зарж борлуулан, гэр бүлийнхээ орлогод нэмэрлэдэг байв.

Роны төрөлхийн удирдах, ажил хуваарилах, гүйцэтгэх чадвар ажилд нь төдийгүй Сүмийн үүрэг

Буянт сайн эцэг эхээс мэндэлсэн нь

Ахлагч Расбанд Есүс Христийн төлөөлөгчийн хувьд хэлсэн анхны үгэндээ өвөг дээдэстээ чин сэтгэлийн талархлаа илэрхийлсэн байдаг. “Би сайн мэдээн доторх буянт сайн эцэг эхээс мэндэлсэн, тэд ч мөн зургаан үеэрээ буянт сайн эцэг эхээс мэндэлсэн”¹ гэж тэр хэлжээ.

Түүний ээж Вэрда Андэрсон Расбанд хайраар дүүрэн удирдагч байсан ба Роныг сударт хайртай болгосон юм. Түүний аав Рулон Хавкинс Расбанд шаргуу хөдөлмөрийн үнэ цэнийг үлгэр жишээгээрээ харуулсан итгэлтэй санваартан байв.

Роналд Андэрсон Расбанд 1951 оны 2-р сарын 6-нд АНУ-ын Солт Лэйк хотод төрсөн бөгөөд эцэг эхийнхээ гэрлэсний дараа төрсөн цор ганц хүүхэд нь байв. Эцэг эх нь хоёулаа өмнөх гэрлэлтүүдээсээ хоёр хүү, нэг охинтой байсан ба Рон тэдний дүү болон өссөн юм.

“Тэр эцэг эхийн маань аль алиных нь зан чанарыг өвлөсөн учраас бид бүгд түүнд хайртай байлаа” гэж түүний эгч Нэнси Шиндлер хэлсэн байдаг. “Рон хэзээ ч аав, ээж хоёрыг зэрэгцэж зогсохыг эсвэл хамт суухыг зөвшөөрдөггүй байсан ба үргэлж дунд нь суудаг байсан.”





хариуцлагад нь сайнаар нөлөөлөөд зогсохгүй, амьдралд нь ч нөлөөлсөн юм.

“Рон зүлэг тэгшлэх үүрэгтэй байсан” хэмээн эгч нь хэлэв. Гэвч Рон найзуудаа ятган, туслуулчихдаг байлаа.

“Намайг гадагшаа харахад Роны сайн найзууд түүний оронд зүлэг тэгшилж байдаг байлаа” гэж Нэнси хэлэв. “Дараагийн долоо хоногт өөр найзууд нь зүлэг тэгшилж, Рон зүгээр суунгаа өөрийнх нь ажлыг хийж буй найзуудтайгаа ярилцан, инээлдэж байдагсан.”

Эцэг эх нь санхүүгийн бэрхшээлтэй байдаг байсан ч, гэр бүлд нь сайн мэдээ байсан юм. “Бидэнд хэзээ ч их мөнгө байгаагүй, гэхдээ энэ нь миний аз жаргалд ердөө ч нөлөөлөөгүй” хэмээн Рон дурсав.

Итгэмжит найзууд болон удирдагчид

Рон өсөж, том болох үедээ сайн найзуудаар болон итгэмжит санваарын удирдагчдаар адислагдсан юм. Тэдний нэг нь 14 жилийн туршид түүний гадасны ерөнхийлөгч байсан, хожим нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад болон Тэргүүн Зөвлөлд үйлчилсэн Жэймс Э.Фауст (1920–2007) байлаа. Роны гэр бүл ерөнхийлөгч Фаусттай болон түүний гэр бүлтэй ойр дотно байдаг байв. “Тэр намайг өсгөлдсөн учраас намайг үргэлж Коттонвүүд хөвгүүдийнхээ нэг хэмээн үзэж, дууддаг байж билээ” хэмээн тэр хэлсэн юм.

Рон ажил хийдэг байсан учраас ахлах сургуульд орсноосоо хойш сургууль дээр спортоор хичээллэх цаг гарахаа байсан



хэдий ч насан туршид үргэлжлэх үнэнч нөхөрлөлд цаг гаргадаг байлаа.

“Би Роныг хувь хүнийх нь хувьд биширдэг байсан ч тэр төгс хүн байгаагүй” гэж хүүхэд насных нь найз Крэйг Макклэри хэлэв. “Хэрэв чи тэнгэрт очих юм бол би ч бас тэнд очно, яагаад гэвэл өсөж торнихдоо бид адилхан зүйл хийсэн шүү дээ гэж би түүнд хэлж билээ” хэмээн тэр инээмсэглэн хэллээ.

Рон 1970 оны эхээр номлолдоо явахад Крэйг намрын ан агнуурын улирал өнгөртөл номлолоо хойшлуулах талаар бодож байв. Тэр үед номлолд байсан Рон түүн рүү утасдав.

“Тэр яаж утасдах зөвшөөрөл авсныг би мэдэхгүй ч намайг номлолдоо гарахдаа илүү баяртай байхгүй байгаагийн минь төлөө зэмлэсэн юм” гэж Макклэри ах хэллээ. “Мэдээж, би номлолоо хойшлуулаагүй.”

Рон номлолоо “гайхалтай” туршлага гэж нэрлэдэг. “Их Эзэн намайг олон гайхамшигтай, итгэл хөгжүүлсэн туршлагаар адисалсан.” “Номлол маань сүнслэг амьдралд минь онцгой нөлөө үзүүлсэн” хэмээн тэр хэлэв.

Рон номлолынхоо нэг хэсгийг Бермудын арлуудад өнгөрүүлсэн юм. Түүний номлолын ерөнхийлөгч Харолд Нифай Вилкинсон тийшээ хааяа л очдог байсан

Гэрлэсэн цагаасаа эхлэн ахлагч Расбанд, Расбанд эгч хоёр Их Эзэнийг нэгдүгээрт тавьж иржээ. 1973 оны 9-р сарын 4-нд гэрлэж (доод талд), хожим нь тэд дөрвөн охин, нэг хүүгээр адислагджээ (дээд талд). Эсрэг талын хуудсан дээр: Ахлагч Расбандын бизнесийн хамтрагч, зөвлөгч Бага Жон Хантсман түүнийг “туйлын үнэнч, авьяаслаг удирдагч” гэж нэрлэжээ.



учраас зөвхөн “төгс дуулгавартай номлогчдоо” тэр газар руу явуулдаг байжээ.

“Бид тусгаарлагдмал газарт байдаг байсан ч ерөнхийлөгч бидэнд санаа зовдоггүй байлаа.” “Бид номлолын ажлаа сайн хийдэг байсан” хэмээн Рон дурсав.

Дэлта Пи дэх “Мөрөөдлийн охин”

Рон 1972 онд номлолоо дуусгаад, намар нь ажилд орсон бөгөөд Ютагийн Их Сургуульд элсэн, коллежийн эргэж ирсэн номлогчдын клуб болох Дэлта Пи Каппад нэгджээ. Тэрээр клубын нийгмийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцож чаддаггүй байсан ч Милани Твичэл хэмээх царайлаг залуу эмэгтэйг анзаарч хардаг байв. Милани Дэлта Пи клубын үйл ажиллагааг зохион байгуулахад тусалдаг “мөрөөдлийн охид”-ын нэг байсан юм.

Ронтой адил, Милани идэвхтэй хожмын үеийн гэгээнтэн гэр бүлтэй байлаа. Аав нь цэргийн албан хаагч, харин түүний ээж гэр бүл нь байнга шилжин нүүдэг ч сүмээ тасалдаггүй тийм нэгэн байв.

Роны сайхан сэтгэл, эелдэг зан, сайн мэдээний мэдлэг зэрэг нь Миланигийн сэтгэлд хүрчээ. “Би түүнтэй хэзээ ч болзож чадахгүй байсан ч бай хамаагүй, тэр бол гайхалтай залуу. Би зүгээр л түүний хамгийн сайн найз болохыг хүсэж байна” гэж би өөртөө хэлсэн.”

Тэдний харилцаа дотносохын хэрээр Сүнс түүнд Роны талаарх болон түүний Их Эзэнд өгсөн амлалтын талаарх сэтгэгдлийг нь баталсан юм. Удалгүй тэдний нөхөрлөл гүнзгийрч, Миланигийн дурсан хэлснээр “үлгэрийн номд гардаг шиг хайр дурлалд” автжээ.

Милани төгс хамтрагч байлаа хэмээн ахлагч Расбанд хэлээд, “Сайн мэдээний өв, үйлчлэлд Милани надтай адил байлаа. Бид хамгийн сайн найзууд болсон бөгөөд тиймээс ч би түүнээс надтай гэрлэхийг гуйсан юм” гэж билээ.

Тэд 1973 оны 9-р сарын 4-нд Солт Лэйкийн ариун сүмд гэрлэжээ. Түүнээс хойш “аминч бус мөнхийн хамтрагч маань . . . намайг илүү сайн Есүс Христийн шавь болоход тусалсан. Түүний маань болон бидний 5 хүүхэд, тэдний эхнэр нөхөр, 24 ач зээгийн маань хайр, тусламж надад дэмжлэг болж байдаг”³ гэж тэр хэлэв.

“Явцгаая”

Рон гэрлэснийхээ дараа гэрлэсэн оюутнуудын тойргийн ахлагчдын чуулгын ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа тойргийнхоо дээд зөвлөлийн зөвлөх Бага Жон Хантсмантай танилцжээ. Хантсманд тэр даруй Роны чуулгаа удирдан авч яваа арга барил гайхалтай санагдсан байна.

1996–2011 онд Бүсийн далд үйлчилж байсан ахлагч Хантсман “Тэр гайхалтай удирдаж, зохион байгуулах чадвартай нэгэн байлаа” гэж дурсжээ. “Коллежийн оюутан залуу чуулгаа тэгж авч явна гэдэг энгийн зүйл биш гэж би бодсон.”

Жон хэдэн сарын турш Роныг санваарын үүргээ биелүүлэхийн зэрэгцээ санаагаа үйлдэл болгож байгааг ажигласан байна. Хожим Хантсманы химийн корпораци болох Жоны компанид ахлах борлуулагчийн орон тоо гарахад түүний хүссэн ур чадварууд Ронд байгааг мэддэг байсан тул түүнд ажиллах санал тавьжээ. Ажил нь долоо хоногийн дараа АНУ-ын Огайо мужид эхлэх байв.

“Би сургуулиа орхиод нүүхгүй гэдгээ Миланид хэлж билээ” хэмээн Рон дурсав. “Би коллежоо төгсөх гэж маш их хичээсэн, гэтэл одоо төгсөх тун дөхөөд байна.”

Гэтэл Милани түүний сурч байгаа шалтгаан бол сайн ажил олох явдал гэдгийг сануулжээ.

“Чи юунд санаа зовоод байгаа юм бэ?” гэж Милани асуугаад, “Би юмаа хэрхэн баглах мөн нүүхийг мэднэ. Би амьдралынхаа туршид нүүсээр ирсэн шүү дээ. Би чамайг орой бүр ээжтэй чинь утсаар яриулж байх болно. Явцгаая” гэсэн байна.

Жоны Ронд итгэсэн нь талаар болсонгүй. Жоны заавар дор Рон хөгжиж буй компанид хурдан дэвшиж, 1986 онд уг компаний ерөнхийлөгч, үйл ажиллагаа хариуцсан захирал болжээ.

Тэрээр ажлаараа улс дотроо болон улс хооронд маш их аялдаг байв. Рон завгүй хуваарьтай байсан ч амралтын өдрүүдэд гэртээ байхыг хичээдэг байлаа. Тэр аялах үедээ заримдаа гэр бүлийнхнээ авч явдаг байв.

“Тэр гэртээ байхдаа хүүхдүүдээ онцгой бөгөөд хайрын мэдрэмжийг жинхэнээсээ өгдөг байсан” хэмээн Милани хэллээ. Боломж гарах бүрийд тэрээр хүүхдүүдийнхээ оролцсон үйл ажиллагаа, спортын арга хэмжээнд оролцдог байв. Тэдний дөрвөн охины нэг Жэнэсса Макпэрсон, аав нь Сүмийн үүрэг хариуцлагынхаа үүднээс цуглааны үеэр гэр бүлээсээ тусдаа суудаг байсан тухай ярихдаа

“Түүнтэй хамт байх нь үнэхээр ховор зүйл байсан учраас бид аавынхаа дэргэд суух гэж хоорондоо





тэмцэлддэг байж билээ. Би түүний гарыг атгаад, хэрэв би түүнтэй хэрхэн адил болохыг сурч мэдэж чадвал зөв зам дээр байгаад зогсохгүй Аврагчтай адил болж чадна гэж бодож байлаа. Тэр үргэлж миний баатар байсан” гэж хэллээ.

Тэдний хүү Кристиан “эцэг, хүү хоёрын хамтын цаг хугацаа”-ны дурсамжаасаа ярив. Гэр бүл нь байнга нүүдэг байсан учраас бусадтай түр зуур л найзалдаг байсан гэж тэр хэлээд, “Гэхдээ аав маань үргэлж миний хамгийн сайн найз,” өрсөлдөх дуртай хүн байсныг ярьсан юм.

Рон Кристиантай сагсан бөмбөг тоглоходоо ч, охидтойгоо хөлөгт тоглоом тоглосон ч, гэр бүлийнхэн болоод найзуудтайгаа загасчилсан ч хожих дуртай байлаа.

“Биднийг өсөж том болох үед тэр хэнийг ч хожихыг хүлээн зөвшөөрдөггүй байж билээ” хэмээн Кристиан хэлэв. “Бид хожихын тулд хичээх хэрэгтэй байв, харин энэ нь биднийг илүү сайн болгодог байсан. Энэ уламжлал нь хайртай ач зээ нарт нь ч үргэлжилсээр байгаа билээ.”

Он жил өнгөрөх тусам Роны гэр бүлийнхэн түүний Сүмийг удирдах үйлчлэл хайр, өршөөлөө үзүүлэх, Сүнсний мэдрэмжүүдээ илэрхийлэх, бусдыг хамгийн сайнаараа хичээхэд урамшуулах зэрэг чадварыг нь хэрхэн хөгжүүлж байгааг тодхон харж байлаа. Рон, Милани хоёрын ач Пакстоныг төрсний дараа гэр бүлийнхэн нь Роны сүнслэг хүч, дэмжлэгт тун их найдаж байв.

Пакстон ховор тохиолддог генийн өөрчлөлттэй төрсөн юм. Тоймшгүй их эрүүл

мэндийн асуудал гэр бүлийнхнийх нь бие махбод, сэтгэл санаа, сүнслэг байдлыг сорьж байлаа. Пакстоныг төрснөөс хойших үеийг ахлагч Расбанд “мөнх байдалтай холбоотой онцгой сургамж өгсөн хүндхэн сорилт”⁴ гэж нэрлэжээ.

Пакстоныг хорвоод мэндлээд гуравхан жил амьдрах хугацаанд олон асуулт байсан ч хариулт нь цөөхөн байлаа. Ахлагч Расбанд сүнслэг багана болон зогсож, гэр бүлээ Есүс Христийн Цагаатгалын хүч рүү хөтөлсөн юм.

Түүний шинэ дуудлагыг зарлахад гэр бүлийн цөөн хэдэн гишүүн болон найзууд нь тийм ч их гайхаагүй билээ. Кристиан хэлэхдээ “Түүнийг төлөөлөгчөөр дэмжүүлэх үед бид түүнийг сайн мэдэх учраас гараа хамгийн өндөрт өргөж байлаа” гэжээ.

“Би явж мөн үйлчилнэ”

1996 онд 45 настай Роныг Нью-Йоркийн Нью-Йорк Хойд Номлолын ерөнхийлөгчөөр дуудах үед түүний бизнес ид амжилттай өрнөж байлаа. Эртний төлөөлөгчдийн адил тэрээр “тэр даруй тороо орхисон” (Матай 4:20) юм.

“Уг дуудлагыг секунд ч хүрэхгүй хугацаанд хүлээн зөвшөөрсөн”-өө ахлагч Расбанд хэлэв. Тэрээр Их Эзэнд “Та намайг явж, үйлчлээсэй гэж хүсэж байгаа бол би явж, үйлчлэх болно” гэж хэлжээ.



Зүүн дээд талд: Ахлагч Расбанд, Расбанд эгч хоёр Энэтхэгийн Шинэ Дели дэх Сүмийн гишүүдтэй хамт, 2015 оны 11-р сар. Дээд талд: Ахлагч Расбанд, Расбанд эгч хоёр; мөн ач хүү Пакстоны хамт болон 1996–1999 онуудад Нью-Йорк хотод номлолын ерөнхийлөгч байхдаа Сакраменто Калифорний ариун сүмийн шав тавих ёслолын үеэр. Пакстон нь гэр бүлдээ “мөнх байдалтай холбоотой онцгой сургамж” өгч, суралцахад тусалжээ.

Рон “Хүмүүс юу юунаас ч илүү чухал” хэмээх нэгэн агуу сургамжийг ажил мэргэжлээсээ сурсан байсан юм.⁵ Тийм л мэдлэг, удирдах чадвартай тэрээр Их Эзэний хаант улсад бүрэн цагийн үйлчлэлээ эхлэхэд бэлэн байв.

Рон, Милани хоёрын Нью-Йорк хот дахь номлогчийн ажил бэрхшээлтэй тулгарч байсан ч тэд урам зоригтой байлаа. Рон номлогчдооо үүрэг хариуцлагуудыг хурдан хуваарилж, үнэнч байдлыг нь урамшуулан мөн зааж, хүчирхэгжүүлэн, өсөж хөгжихөд нь өргөн дэмжиж байв.

2000 онд Рон, Милани хоёрыг номлолоо дуусгаснаас хойш найман сарын дараа Роныг Далд дуудсан бөгөөд түүний бэлтгэл, туршлага, олон авьяас нь Сүмийг адисалсан. Тэрээр Далын гишүүний хувьд Европын Төвийн бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчилж, 39 улс үндэстэнд өрнөж буй ажлыг хянахад тусалж байв. Тэр коллежоо орхиод 40 гаруй жил болсон ч мундаг суралцагч хэвээр байлаа. Тэрээр Хойд Америкийн Баруун, Баруун хойд болон Ютагийн гурван бүсэд үйлчлэхдээ ах нараас удирдамж авч хэрэгжүүлэн, Ариун сүмийн албаны гүйцэтгэх захирлаар үйлчилж, мөн Далын ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчлэхдээ Арванхоёртой ойр ажилладаг байжээ.

Саяхан ахлагч Расбанд “Арванхоёрын хамгийн залуу төлөөлөгчдийн нэг байж, тэднээс бүхий л талаар суралцах боломжтой байгаа маань нэр төрийн хэрэг”⁶ гэж хэлсэн юм.

“Тэдний юу мэдсэнийг би мэднэ”

Ахлагч Расбандын ажлын өрөөний хананд хоёр зураг байдаг. Нэг нь 1850-аад оны үед Дани дахь гэр бүлд зааж буй мормон номлогчдын зураг. Хоёр дахь нь худгийн өндөрлөг дээр зогсоод номлож буй анхны номлогчдын нэг болох Дан Жонсын зураг юм. Уг зургууд нь (баруун дээд талд байгаа) ахлагч Расбандад өвөг дээдсийнх нь тухай сануулж байлаа.

“Эхэн үеийн анхдагчид болох тэд Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрахын тулд бүхнээ зориулан, хойч үедээ дагаж амьдрах өвийг үлдээсэн билээ” хэмээн тэр гэрчилсэн.⁷ Ахлагч Расбандын өвөг дээдсийг саад бэрхшээл, хавчлага дунд урагш түрсэн зүйл болох Их Эзэний ба Түүний ажлын тухай мэдлэг болоод баттай гэрч нь түүнийг шинэ дуудлагад нь тохирохоор болгосон байна.

“Надад шинэ дуудлагат ажилдаа сурах зүйл маш их байна” гэж тэр хэлэв. “Би үүнээс дарууслыг үнэхээр их мэдэрч байна. Гэхдээ би дуудлагынхаа нэг л



зүйлийг маш сайн хийж чадна. Би ‘Бүх дэлхийд Христийн нэрийг’ (С ба Г 107:23) гэрчилж чадна. Тэр амьд!”⁸

Тэрээр анхдагчдын үр удмын хувьд “би тэдний юу мэдэрснийг мэдэрнэ. Би тэдний юу мэдсэнийг мэднэ”⁹ гэжээ.

Тэдний үр удмаасаа хүсэн хүлээж байсан зүйлс ахлагч Роналд А.Расбандын амьдрал, сургаал, үйлчлэлд биеллээ олсон юм. Тэрээр Их Эзэний онцгой гэрчүүдийн нэгний хувьд өвөг дээдсийнхээ үлгэр жишээг дагаж, тэдний өвийг хүндэтгэн, урагшилж яваа билээ. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Роналд А.Расбанд, “Би гайхширна,” 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 78.
2. Роналд А.Расбанд, “Friend to Friend: Golden Nuggets,” Friend, 2002 оны 10-р сар, 8.
3. Роналд А.Расбанд, “Би гайхширна,” 78.
4. Роналд А.Расбанд, “Онцгой хэрэгцээ ба онцгой сургамжууд,” 2012 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 86.
5. Ахлагч Роналд А.Расбанд, хэвлэлийн бага хурал, 2015 оны 10-р сарын 3.
6. Роналд А.Расбандын гэрчлэл, Санваар болон Гэр бүлийн албаны онцгой цугларалт, 2015 оны 12-р сарын 1.
7. Роналд А.Расбанд, “Би гайхширна,” 78.
8. Роналд А.Расбандын гэрчлэл.
9. Роналд А.Расбандын Анхдагчдын өдрөөр хэлсэн үг, Солт Лэйк хот, Табернекл, 2007 оны 7-р сарын 24.

ЗУУН ДЭЭД ТАЛД: ВИДИ КИЛЕРИЙН АВСАН ГЭЭЛ ЗУРАГ; БАРУУН ТАЛД: ДАНИ ДАХЬ ГЭР БҮЛД ЗААЖ БУЙ МОРМОН НОМЛОГЧДЫН ЗУРАГ; ХОЁР ДАХЬ НЬ ХУДГИЙН ӨНДӨРЛӨГ ДЭЭР ЗОГСООД НОМЛОЖ БУЙ АНХНЫ НОМЛОГЧДЫН НЭГ БОЛОХ ДАН ЖОНСЫН ЗУРАГ ЮМ. УГ ЗУРГУУД НЬ (БАРУУН ДЭЭД ТАЛД БАЙГАА) АХЛАГЧ РАСБАНДАД ӨВӨГ ДЭЭДСИЙНХ НЬ ТУХАЙ САЛУУЛЖ БАЙЛАА.

Олон жилийн өмнө би идэвх султай байсан болохоор тухайн үед таньдаг байсан нэг гишүүн намайг бишпоор дуудагдсанд итгээж чадахгүй байлаа.

Патрик Ж.Кронин III

Санваарын гүйцэтгэх хорооны хурлын үеэр бүрэн цагийн номлогчид манай тойрогт бүртгэл нь байдаггүй нэгэн гишүүнтэй уулзсанаа ярив. Би түүнийг тэр даруй таньсан ба тэр эмэгтэй бид хоёр олон жилийн өмнө нэг тойрогт байсныг хэлж билээ.

Номлогчдын нэг нь “Тийм ээ, бишоп оо, тэр бас тэгж хэлсэн. Бас таныг бишоп гэдэгт их гайхсан янзтай байсан” гэж хэллээ.

“Тэр юу гэж хэлсэн бэ?” гэж би тэднээс асуухад тэр эмэгтэй их гайхсан байдалтай байсан бас “Тэр бишоп гэж үү?” гэсэн гэж тэд хэлэв.

Би инээгээд, энэ эмэгтэй намайг 30 жилийн өмнө тэс өөр байснаар минь мэднэ гэдгийг тайлбарлалаа.

Дараа нь би энэ явдлын талаар бодож байхдаа гэр бүлийнхэнтэйгээ хамт гишүүн байсан энэ 30 гаруй жилийн хугацаанд амьдрал маань хэчнээн их өөрчлөгдсөн тухай тунгаан бодов. Би тойргийнхоо олон гишүүнийг 20 жилийн турш мэдэх бөгөөд салбарын ерөнхийлөгчөөр мөн бишпоор үйлчилсэн. Гэхдээ эдгээр гишүүний хэн нь ч намайг 30 жилийн өмнө ямар байсныг мэддэггүй юм. Би наманчлал, Есүс Христийн Цагаатгалын талаар заахдаа хааяа өнгөрсөн амьдралынхаа алдаа дутагдлаас хуваалцдаг байсан ч тойргийн ихэнх гишүүн Сүмд өнгөрүүлсэн миний амьдрал ямар гайхалтай аялал байсныг мэдэхгүй.

Би гэр бүлийнхээ хамт 1979 оны 5-р сард Сүмийн талаар мэдэж авсан бөгөөд энэ бол бидний байх ёстой

газар гэдгийг тэр даруй ойлгосон юм. Бид 6-р сард баптисм хүртээд, эхэндээ бүгд идэвхтэй байсан боловч би тун удалгүй Сүмд явахаа больж, хуучин зуршлууддаа автсан юм. Би сайн мэдээний болон Сэргээлтийн үнэн байдалд хэзээ ч эргэлзэж байгаагүй, харин өөрийгөө Сүмийн сайн гишүүн байхад тохирох хүн биш гэж боддог байлаа.


1982 онд итгэлээ огт алдаж байгаагүй эхнэр маань архинаас үүдэлтэй байнгын хүчирхийллээс залхаж, салах өргөдөл гаргав. Тухайн үед гэр бүл маань АНУ-ын Оклахомад амьдарч байсан ч би өсөж торнисон Иллиной муждаа эргэн очсон юм. Би хамгийн чухал зүйл болох гэр бүлээ алдахад хүрээд байлаа.

Байгаа эсэхийг нь ч мэдэхээ больсон эсвэл хэрэв байгаа бол намайг аль хэдийн мартсанд тооцож байсан Бурханд хандан би өглөө, оройдоо өвдөг сөгдөн залбирч эхлэв. Би гурван сарын турш итгэлтэй залбирлаа. Нэг өглөө эрт бо-соод, чин сэтгэлээсээ залбирч байх үед агуу тайвшралын мэдрэмж намайг нөмрөн авч, би Бурхан амьд, Тэр намайг мэддэг, надад хайртай болохыг мэдэрсэн юм. Би дахиад нэг ч дусал архи уухгүй гэдгээ бас мэдсэн.

Тэр орой эхнэр маань утасдаж, салах бичиг баримт дээр гарын үсэг зуруулахаар над руу илгээх гэж байгаага хэллээ. Ярьж байхдаа тэр гэнэт “Чи нэг л өөр болсон байна. Чамайг дахиад уучихвий гэж надад огт бодогдохгүй байна. Би энэ бичиг баримтыг урж хаялаа” гэж хэлж билээ. Бид эргэн нийлж, хоёр жилийн

Тэр

БИШОП ГЭЖ ҮҮ?



дараа эхнэр маань гурав дахь хүүгээ төрүүлэв.

Намайг Сүмдээ бүрэн идэвхтэй болсон байх гэж бодож байгаа байх. Гэтэл би их зөрүүд байсан юм билээ. Би хэсэг хугацаанд эргэн очиж, ахлагчдын чуулгын багшийн дуудлага хүлээн авлаа. Гэвч би өөрийгөө багш байхад хангалтгүй байна гэж үзээд, дахиад л идэвх маань судрав.

1991 онд бид нэг жижиг салбар руу нүүсэн юм. Бага хүү маань найман нас хүрэхээс хэдхэн сарын өмнө Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчөөр үйлчилж байсан эхнэр маань хүүгээсээ эхнээр баптисм хүртээхийг хүсэж байгааг нь асуужээ. Мэдээж тэр аавыгаа энэ ёслолыг хийгээсэй гэж хүсэж байв. Эхнэр маань хүүдээ тэр бараг бүтэхгүй байх даа гэж хэлсэн. Хүү маань тэр хариултыг хүлээн аваагүй бөгөөд аавыгаа идэвхтэй болгох зорилго тавьсан юм. Тэр зорилгоосоо няцаагүйгээр барахгүй тун удалгүй би скаутмастерээр үйлчилж, дараа нь хүүдээ баптисм хүртээн, Ариун Сүнсний бэлэг өгөв.

Намайг идэвхтэй болсноос хойших найман сар үйл явдлаар дүүрэн

байлаа. Бид гэр бүлээрээ Чикагогийн Иллинойн ариун сүмд лацдан холбогдож, би дахин ахлагчдын чуулгын багшаар дуудагдав. Гэхдээ энэ удаад би дуудлагаа орхиогүй. Дараа нь би салбарын ерөнхийлөгчийн зөвлөлд зөвлөхөөр дуудагдав. Таван сарын дараа би салбарын ерөнхийлөгч боллоо. Түүнээс хойш сарын дараа “Би салбарын ерөнхийлөгч гэж үү?” хэмээн бодож байснаа санаж байна.

Хэрэв би сайн мэдээнд өсч хөгжиж чадсан юм бол бусад хүн ч бас чадна гэж би олон жилийн туршид зовж шаналж буй олон гэгээнтэнд хэлсээр ирсэн. Энэ нь Аврагчийн болон Түүний Цагаатгалын жинхэнэ хүчийг ойлгож, Түүн рүү очих алхмуудыг хийснээс л зөвхөн шалтгаалдаг.

Би надад гайхалтай үлгэр жишээ үзүүлсэн эхнэр, хүүхдүүд мөн бүх итгэлтэй гэрийн багш, чуулгын удирдагч, бишопууд болон бусад итгэлтэй гэгээнтэнд мөнхөд талархаж явах болно. Сүүлийн 20 жил Их Эзэнд болон түүний гэгээнтнүүдэд үйлчлэх нь үнэхээр сайхан байна. Амьдрал маань миний төсөөлшгүй их зүйлээр адислагдсан. ■

Зохиогч нь АНУ-ын Иллинойд амьдардаг.

СУДРЫН ОРЧУУЛГА: Зүрх сэтгэлийнхээ

ХЭЛ РҮҮ ХӨРВҮҮЛЭХ НЬ

Энэхүү туршлагыг англи хэл-нээс бусад хэл рүү судруудыг орчуулахад оролцсон хүмүүс сайн мэднэ. Энэ нь ахин дахин тохиолддог.

Нэгэн армен залуу өөрийнх нь хэл дээр саяхан орчуулагдан гарсан Мормоны Номын нэг хувийг гартаа бариад, орчуулах ажилд оролцсон багийн гишүүнд хандан: “Баярлалаа” гээд, “Би Мормоны Номыг англи хэл дээр уншсан. Би Мормоны Номыг мөн орос хэл дээр уншсан. Украин хэл дээр ч уншиж байсан. Гэхдээ би армен хэл дээр унших хүртлээ бүрэн ойлгоогүй байжээ. Армен хэл дээрээ уншихад бүх зүйл ойлгомжтой болсон. Энэ нь яг л гэртээ ирж байгаатай адил санагдсан” гэж хэлэв.

Гэртээ ирсэн минь

Хэрэв Есүс Христийн сайн мэдээ бидний сүнслэг гэр юм бол энэ нь тохь тухтай, танил байх нь аргагүй юм. Бид гэртээ амардаг. Бид өөрсдийгөө хооллодог. Бид эхийнхээ өвөр дээр байхаасаа сурсан тэрхүү хэлээрээ хайртай хүмүүстэйгээ ярилцдаг. Энэ нь бидний зүрх сэтгэлийн хэл бөгөөд сайн мэдээ зүрх сэтгэлд хүрэх ёстой учраас судруудыг зүрх сэтгэлийнхээ хэл дээр унших нь үнэхээр амин чухал юм.

Сургаал ба Гэрээнд энэ талаар ийнхүү дурдсан байдаг. Их Эзэн Тэргүүн Зөвлөлд буй санваарын түлхүүрүүдээр дамжуулан үүнийг илчилсэн тухай бичихдээ “Үндэстнүүдийг . . . тэдний авралын сайн мэдээнд итгүүлэхийн тулд Их Эзэний гар сүр хүчээрээ дамжин илчлэгдэх тэрхүү өдөр ирэх болой.

**ИХ ЭЗЭНИЙ МУТАР ӨӨРИЙН СУДРУУДЫГ ОРЧУУЛАХ
АЖИЛД ОРОЛЦСОН ТОЙМГҮЙ ОЛОН ТОХИОЛДОЛ БИЙ.**

Р.Вал Жонсон
Сүмийн сэтгүүлүүд





*Судрууд бидний
төрөлх хэл
болох зүрх
сэтгэлийн хэл
дээр уншигдвал
зүрх сэтгэлд
илүү хүчтэй
нөлөөлнө.*



Мормоны Ном бүрнээрээ 89 хэл дээр хэвлэгдэн гарсан бөгөөд сонгогдсон хэсгүүдийг өөр 21 хэл рүү орчуулаад байна.

Учир нь мөнхүү улиран тохиох дор Есүс Христийн илчлэлтийн учир тэдэн дээр урагш юүлэгдэх Тайтгаруулагчийн чиглүүлээр энэ хүчинд томилогдсон тэднээр дамжуулан тэрхүү өдөр хүн болгон сайн мэдээний бүрэн байдлыг төрөлх хэл дээрээ, мөн өөрийн хэлээр сонсох болно” (С ба Г 90:10–11) гэжээ.

Сүмийн удирдах газарт судрын орчуулгын багт ажиллаж байсан Жим Жүвел судрууд нь зүрх сэтгэлийн хэлнээ хөрвүүлэгдсэнээр бид судрыг хэрхэн илүү сайн мэдэрч чадах тухай дараах түүхийг ярьсан юм.

“Африкийн улс болох Лесотогийн хүмүүсийн ярьдаг сесото хэлнээ Мормоны Номыг орчуулж байхад бид орчуулгын багийн ажлыг үнэлж дүгнэхэд туслах хэн нэгнийг олох хэрэгтэй болсон юм. Төслийн ахлагч Ларри Фоли Юта мужийн их сургуулийн төгсөх ангийн оюутан болох Лесотогийн Сүмийн гишүүнийг олсон юм. Лесотод хичээлүүд англи хэл дээр явагддаг тул энэ эмэгтэй бас түүний хүүхдүүд англи хэлийг нэгдүгээр ангиасаа эхлэн сурсан байсан бөгөөд харин гэртээ сесото хэлээрээ ярьдаг байв.

“Тэр эмэгтэй орчуулгуудыг шалгахад боллоо. Түүн рүү бүлгүүдийг илгээсэн бөгөөд түүний бүлгүүдэд өгсөн дүгнэлт үнэхээр их тус нэмэр болж байлаа. Бид үгсийн сан ба хэлний бүтцийн тухай бичсэн түүний дүгнэлтийн талаар тодорхой асуултуудыг тогтмол явуулж байв. Харин тэр эмэгтэй бидний асуултуудтай холбоогүй олон шүлгийг шар өнгөөр тодруулсан байхыг бид анзаарсан юм. Бид тодруулсан шүлгүүдийн талаар

асуухад, тэрээр: ‘Өө, тэр шүлгүүд бол миний зүрх сэтгэлд гүн гүнзгий нөлөөлсөн шүлгүүд юм. Би тэдгээрийг англи хэл дээр уншаад хэзээ ч бүрэн ойлгоогүй байсан. Би тэдгээрийг тодруулаад, хүүхдүүдтэйгээ хуваалцах гэсэн юм’ хэмээн хариулж билээ.”

Судрын орчуулгын загвар

Библийн орчуулга нь Хуучин Гэрээн дэх еврей хэлнээс грек хэл рүү хэсэгчлэн орчуулснаас үүдэлтэй

урт удаан хугацааг хамарсан гайхалтай түүхтэй. Дараа нь Библи грекээс латин руу, латин, еврей, грек хэлнээс бусад олон хэл рүү орчуулагдсан.¹ Иймээс Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтний Сүм Библийг бусад хэл рүү орчуулагдаггүй бөгөөд тэдгээр хэлээр ярьдаг Христийн шашинтнуудын хүлээн зөвшөөрсөн хувилбаруудыг авч хэрэглэдэг юм.²

Сүмийн судрын орчуулгын ихэнх ажил нь Мормоны Ном

**“УЧИР НЬ МӨНХҮҮ УЛИРАН ТОХИОХ ДОР ... ЭНЭ ХҮЧИНД
ТОМИЛОГДСОН ТЭДНЭЭР ДАМЖУУЛАН ... ХҮН БОЛГОН САЙН
МЭДЭЭНИЙ БҮРЭН БАЙДЛЫГ ТӨРӨЛХ ХЭЛ ДЭЭРЭЭ, МӨН ӨӨРИЙН
ХЭЛЭЭР СОНСОХ БОЛНО” (С БА Г 90:11).**



СУДРЫН ОРЧУУЛГЫН ЯВЦ

1

Орчуулах зөвшөөрөл

- Тухайн хэлээр ярьдаг Сүмийн гишүүдийн тоо нэмэгдэж, Сүмийн үндсэн материалууд уг хэлнээ орчуулагдсаны дараа Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөл судар орчуулах хүсэлтийг гаргадаг.
- Уг хүсэлтийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга болон Тэргүүн Зөвлөлийн гишүүдээс бүрдэх Сүмийн удирдах газрын хэд хэдэн хороо хянан авч үздэг.

Орчуулгын үе шатууд

Оршил үе шат:

- Сүм одоо ашиглагдаж байгаа Библийн орчуулгыг хэрэглэхээр сонгодог.
- Эхлээд үндсэн материалуудыг орчуулдаг. Үүнд: *Сайн мэдээний үндсүүд* (үндсэн сургаалууд, Сүмийн нэр, ариун ёслолын залбирлууд, баптисмын залбирал болон Итгэлийн Тунхаг зэрэг орно), *Бошиглогч Иосеф Смитийн гэрчлэл товхимол*, *LDS.org* сайтын вэб хуудас.
- Ерөнхий чуулганы үгсийг мөн тухайн хэлнээ орчуулж болно.

1-р үе шат:

- Мормоны Ном, Сургаал ба Гэрээ болон Агуу Үнэт Сувд (Ойролцоогоор 10 жилийн ажил)
- Үндсэн эх сурвалжууд болох “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл,” сонгогдсон Сүмийн дууллууд болон *Миний сайн мэдээг номло*



(хамгийн эхэнд орчуулагдсан), Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд судрууд дээр явагддаг. Эдгээр ном нь бошиглогч Иосеф Смитэд илчлэгдсэн, түүний зүрх сэтгэлийн хэл болох англи хэлнээс орчуулагддаг. Судруудыг англиас өөр хэл рүү хөрвүүлэх үйл явцыг Сүмийн түүхийн суралцагчид мэддэг байх хэрэгтэй. Энэ нь бошиглогч Мормоны Номыг англи хэлнээ хөрвүүлсэнтэй ижил үйл явц юм.

Иосеф Смит даруу төлөв, боловсрол нимгэн, тариачин хүү байв. Гэвч түүнд Их Эзэний ажлыг хийхэд шаардлагатай зан чанар, ур чадвар байсан юм. Чухамдаа, Иосеф болон түүний гэр бүл энэ чухал ажлыг хийхээр бэлтгэгдсэн байв.³

Иосефыг нифайчуудын цэдгийг орчуулахад тэнгэрлэг болон мөнх бус тусламж хоёулаа өгөгдсөн. Иосеф Смитийг цэдгийг авах хүртэл дөрвөн жилийн өмнөөс тэнгэр элч Моронай түүн дээр жил бүр айлчлан ирдэг байв. Бид Моронайн бошиглогчид заасан бүх зүйлийг мэдэхгүй ч түүний айлчлалууд Иосефыг ирээдүйн даалгаварт нь сүнсэлэг байдлын хувьд ч мөн оюун ухааны хувьд ч бэлтгэсэн гэдэг нь тодорхой.⁴

Их Эзэн мөн мартагдсан хэлнээс орчуулуулахын тулд “хөрвүүлэгчид”-ийг урьдаас бэлтгэсэн. Эдгээр хөрвүүлэгч нь металл хүрээнд суулагдагдсан тунгалаг хоёр чулуу байсан ба эдгээр чулуу болоод үзмэрч чулуу гэгддэг ижил төстэй хэрэгслийн тусламжтайгаар бошиглогч нифайчуудын цэдгийг англи хэлнээ хөрвүүлжээ. Бошиглогч бүх явцыг дэлгэрэнгүй бичээгүй бөгөөд тэрээр Мормоны Номыг “Бурханы бэлэг

болон хүчээр”⁵ орчуулснаа л гэрчилсэн байдаг юм.

Өгөгдсөн тэнгэрлэг тусламжаас гадна, мөнх бус туслахууд Иосефт бичээчээр ажиллаж, бусад олон хүн үсэг өрж, хэвлэж, худалдан авч, дэлхийд түгээж болох тэрхүү хэвлэмэл хувийг бий болгож байв.

Иосеф орчуулгын ажилдаа тэрхүү бэлтгэл ажил, тусламж хоёрыг хүлээн авсантай адил өнөөдөр судруудыг орчуулах үүрэг хүлээсэн хүмүүсийг Их Эзэн бэлтгэж, тэдний ажилд тэнгэрлэг ба мөнх бус хоёр тусламж үзүүлдэг.

Илчлэлтийн ажил

Орчуулгын үйл явцын хэцүү хэсэг нь “зөвлөлийн илчлэлт” гэж болох сүнсэлэг эрч хүч юм. Хоёр юм уу гурван хүн орчуулагчаар сонгогдон, бусад хүнтэй нэг баг болж, уг ажлыг хийдэг. Тэдэнд Сүмийн удирдах газрын ахлах ажилтанууд ба орон нутгийн редакторууд мөн тайлбар толь бичиг,⁶ орчуулгын гарын авлага, компьютерийн программууд болон Тэргүүн Зөвлөлөөс байнга үзүүлдэг шашны дэмжлэг бий. (Дагалдах хүснэгтийг үзнэ үү.) Тэргүүн Зөвлөлийг орчуулгын хамгийн сүүлийн зөвшөөрлийг өгөх үед уг бүтээлийн үсэг өрөгдөж, хэвлэгдэн, тараагддаг. Дижитал хэлбэрээр бэлтгэгдсэн бол *LDS.org* дээр болон Сайн мэдээний номын сан аппликэшн дээр тавигддаг.

Энэхүү хамтын хичээл зүтгэл асар их хүч шаарддаг бөгөөд сүнсэлгээр нөлөөлөгдсөн байдаг. Үүнд агуулгын болон бэлтгэгдэн хүргэгдэж буй бүтээгдэхүүний чанарт онцгой анхаарал хандуулах явдал



орно. Орчуулгыг олон түвшинд, нэн ялангуяа шашны түвшинд Их Эзэний зөвшөөрлийг эрэлхийлэн хянадаг. Зөвхөн зөвшөөрөгдсөн үед л орчуулгыг цааш үргэлжлүүлдэг. Бошиглогч Иосеф Смит Мормоны Номыг орчуулсантай адил тийм илчлэлт байхгүй ч энэхүү үйл явц нь Их Эзэнээр, Түүний бэлгүүдээр болон Түүний хүчээр удирдагддаг нь тодорхой.

Энэ нь орчуулга анх орчуулагдахдаа төгс байдаг гэсэн үг биш юм. Ихэнхдээ төдийгүй хэсэг хугацааны дараа, судар судалдаг хүмүүс дүрмийн болон үгсийн сангийн эсвэл үсэг өрөлтийн юм уу үсэглэлийн алдааг олох нь бий. Ховорхон тохиолдолд сургаалын тайлбарт өөрчлөлт ордог. Эдгээр өөрчлөлтийг Тэргүүн Зөвлөлийн удирдамжийн дагуу хийдэг.

Их Эзэн бэлтгэж өгдөг

Их Эзэн энэхүү орчуулгын ажлыг өөр арга замаар дэмждэг. Сүмийн удирдах газрын орчуулгын багийнхан хэрэгцээтэй үед Их Эзэн тусалдаг хэмээн олонтоо ярьдаг.

Олон жишээнээс нэгийг дурдвал, мам хэлнээ (“мам” гэж дуудагддаг, маяа хэлнээс гаралтай, Гватемал улсад хэрэглэгддэг) Сүмийн материалуудыг орчуулах, дуу оруулах орчуулагч хэрэгтэй байлаа. Гватемалд дуудагдсан анхны номлогчдын нэгнийх нь өвөө мам хэлээр ярьдаг байв. Тухайн номлогч хотод өссөн бөгөөд зөвхөн испаниар ярьдаг байлаа. Харин шөнө бүр түүний зүүдэнд өвөө нь ирж, түүнд мам хэлийг заадаг байжээ. Энэ залуу ахлагч Сүм дэх мам

хэлний анхны орчуулагч болсон.

Ихэнх тохиолдолд орчуулгын ажил нь хувийн агуу золиослолоор хийгддэг. Санхүүгийн нөхцөл байдалаас шалтгаалан, зарим орчуулагч өөрсдийн үйлчлэлийг хандивлаж, зарим нь орчуулгын ажилд цаг заваа зориулсны төлөө цалин хөлс авдаг.

Урду хэлний орчуулагч болсон нэгэн эрэгтэй Пакистанд багшаар ажилладаг байхдаа Сүмд хөрвүүлэгджээ. Сүмд хөрвөгдсөнөөсөө болж тэрээр ажилгүй болж, түүний багшилж байсан сургуулиас өгсөн орон гэрээ алдан, хүүхдүүдээ сургуульд сургах боломжгүй болсон байна. Сүмийн орчуулгын албаны ахлах ажилтан түүнийг орчуулагчаар үйлчлэх эсэхийг асуун, багахан төлбөр санал болгожээ. Орчуулагчаар хэдэн сар ажилласны дараа нөгөө эрэгтэй ахлах ажилтантайгаа уулзан, түүнээс шинэ бал авч өгөхийг зүрхшээнгүй гуйсан юм. Түүний хэрэглэж байсан балны бэх нь дууссан байжээ. Тэр үед л ахлах ажилтан бүртгэлийн алдаанаас болоод уг орчуулагч авах ёстой мөнгөнийхөө маш бага хувийг авч байгааг олж мэдэн, залруулсан байна.

Их Эзэн Иосеф Смитийг ажлаа дуусгах боломжуудаар адисалсан шиг Өөрийн орчуулагчдыг ч бас адисалдаг. Тухайлбал, латви судрын орчуулагч нь Орост хуулийн чиглэлээр суралцах үедээ сэргээгдсэн сайн мэдээнд хөрвүүлэгдсэн хуульч хүн байлаа. Тэр Латвид эргэн ирээд, бизнесээ эхэлжээ. Мөн тэрээр салбарын ерөнхийлөгчөөр үйлчилж байв. Тэр үнэхээр завгүй байсан ч Сүмд тэр өөрөө төдийгүй

2-р үе шат:

- *Лиахона* сэтгүүл, институт, семинарын болон Ням гаргийн ангийн гарын авлага, Сүмийн дуулал болон хүүхдийн дуунууд, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн материалууд, гадасны болон бүсийн шууд нэвтрүүлгийн дуу оруулалт зэрэг олон тооны бусад материалыг орчуулах хүсэлт гаргаж болно.

Чухал ажлын хэсгүүд

Орчуулгын баг:

- Ариун сүмд орохуйц зохистой, сайн мэдээний хангалттай мэдлэгтэй Сүмийн 2–3 гишүүнтэй байх;
- Шүлэг шүлгээр орчуулах удирдамж, толь бичгээс болон Сүмийн удирдах газрын орчуулгын ахлах ажилтнаас тусламж авах;

Сүмийн хянах хороо:

- Тухайн хэсэгтээ Сүмийн удирдагчаар үйлчилдэг 3–5 эрэгтэй, эмэгтэй хүнээс бүрдсэн байх;
- Орчуулга нь уншихад ойлгомжтой, сургаалын үнэн зөв байдлыг хангасан эсэхийг хянахаар дуудагдан, онцгойлон адислагдсан байх;
- Найруулгын өөрчлөлтийг хороо санал нэгтэй зөвшөөрч, орчуулгын удирдамжийн дагуу эв нэгдэлд хүрч шийдвэрлэхээс нааш өөрчлөлтүүдийг хийж болохгүй.

Гишүүн хянагчид:

- Орон нутгийн Сүмийн гишүүд мөн орчуулгыг хянадаг.
- Тэд найруулгын тодорхой байдал, зүй зохицлын талаар санал бодлоо хэлдэг.
- Орчуулгын тодорхой байдал нь Ариун Сүнс сургаалын үнэнийг гэрчлэх болно гэдгийг баталдаг.

Судар орчуулах үйл явц нь уураг тархи, зүрх сэтгэл, оюуны чадвар болон сүнслэг ойлголтуудыг багтаадаг.

түүний англи хэлний чадвар хэрэгтэй байлаа.

Тэрээр уг хүсэлтийн талаар залбирах хугацаа өгөхийг хүссэн бөгөөд хэрэв тэр үүнийг хүлээн авбал “хүүхдүүдийнхээ амнаас хоолыг нь булаасантай” адил болж магадгүйг Сүмийн төлөөлөгчид хэлжээ. Залбирсныхаа дараа тэрээр уг хүсэлтийг хүлээн авахаар шийдсэн бөгөөд хүнд хэцүү, сүнслэг байдал

болон цаг хугацаа их шаарддаг уг ажлыг хийх арга замуудаар түүнийг адислахыг Их Эзэнээс гуйсан байна.

Тэрээр өдөр бүр хуулийн байгууллага руугаа нэг цагийн өмнө очиж, тэр нэг цагаа Мормоны Номыг орчуулахад зориулж эхэлжээ. Тэрээр уг ажлыг хийхэд ихэнхдээ зарцуудаг таван жилээс нь өмнө орчуулж дуусгасан юм. Үнэндээ,

энэ нь бошиглогч Иосеф Смит Мормоны Номыг ойролцоогоор 60 өдрийн дотор орчуулснаас хойших хамгийн хурдан хийгдсэн орчуулгуудын нэг байлаа.

Их Эзэний мутар Өөрийн судруудыг орчуулах ажилд оролцсоныг харуулах өөр олон туршлага бий. Энэ бүхэн нь энэ бол Түүний ажил бөгөөд Тэр үүнд маш их санаа тавьдаг болохыг тод гэгч тунхагладаг. Тэрээр хүмүүсийг Өөрийнхөө ажлыг хийхэд бэлтгэдэг. Тэрээр ажлыг яаравчлуулахад хэрэгтэй байгаа хэрэгслүүдийг нь бэлтгэдэг. Тэгээд Их Эзэн энэ бүхнийг хийхэд тэдэнд сүнслэгээр нөлөөлж, адисалдаг юм.

Үүний үр дүнд Бурханы хүүхдүүдэд өгөгдсөн зүрх сэтгэлийн хэлэн дэх Түүний үгээр дэлхий баяждаг юм. ■

ИХ ЭЗЭНИЙ СУДРУУДЫГ ОРЧУУЛАХ АЖЛЫН ХУВЬД, ЭНЭ НЬ ТҮҮНИЙ АЖИЛ БОЛОХ НЬ ТОДОРХОЙ БАЙДАГ. ТЭРЭЭР АЖЛАА ЯАРАВЧЛУУЛАХЫН ТУЛД ШААРДЛАГАТАЙ ХЭРЭГСЛҮҮДИЙГ БЭЛТГЭДЭГ БӨГӨӨД ЭНЭ БҮХНИЙГ ХИЙХЭД ТЭДЭНД СҮНСЛЭГЭЭР НӨЛӨӨЛЖ, АДИСАЛДАГ ЮМ.

ЭШЛЭЛҮҮД

1. Ленет Х.Рийдийн бичсэн “How the Bible Came to Be” найман хэсэг цувралыг 1982 оны 1-ээс 9-р сарын хооронд гарсан *Ensign*, сэтгүүлээс үзнэ үү.
2. Жишээ болгон, “Church Edition of Spanish Bible Now Published”-ийг mormonnewsroom.org вэб сайтаас үзнэ үү.
3. Мэттью С.Холланд, “Памирад хүрэх зам,” *Лиакхона*, 2015 оны 6-р сар, 14–19.
4. Кент П.Жаксон, “Moroni’s Message to Joseph Smith,” *Ensign*, 1990 оны 8-р сар, 12–16.
5. Иосеф Смит, Мормоны Номын удиртгал. Иосеф Смит Мормоны Номыг орчуулсан талаар илүү дэлгэрэнгүйг Сайн мэдээний сэдвүүд дэх “Мормоны Номын орчуулга,” topics.lds.org-оос үзнэ үү.
6. Тайлбар толь бичигт англи судруудын бүх үгийг тодорхойлсон байдаг бөгөөд энэ нь орчуулагчдыг үгсийн утгыг илүү сайн ойлгоход тусалдаг. Ихэнхдээ үгс нь нэгээс илүү утгатай байдаг тул орчуулагчид зөв шийдлийг олохын тулд агуулга, сүнслэг өдөөлтөд болон багийн ажилдаа найдах хэрэгтэй. Тэргүүн Зөвлөл хааяа утга санаатай холбоотой асуудлыг шийдвэрлэдэг.





**Ерөнхийлөгч
Рассэлл М.Нэлсон**

Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
ерөнхийлөгч

АХМАД НОМЛОГЧИЙН

*Ахмад хосуудын хувьд
гайхамшигтай дурсамж бий
болгох хамгийн шилдэг арга
замуудын нэг бол номлолд
хамтдаа үйлчлэх явдал юм.*

ХОРОМ

60, 70 гарсан найзууд маань ямар нэг юмыг мартаж ихэвчлэн “ахмадын хором” гэж тоглоомоор хэлдэг шүү дээ. Харин би өөр төрлийн ахмадын хором буюу үүрд хоногшин үлдэх дурсамж бүхий гайхамшигтай хормын талаар яримаар байна. Энэ бол ахмад номлогчид Их Эзэний яг хүссэн зүйлийг хийж байгаагаа ухаарах тэрхүү хором юм. Тэд ийм дурсамжтай мөчүүддээ:

- Хуваалцах амьдралын туршлага, бусдыг адислахын тулд ашиглаж болох авьяас, чадвар, сургаалын мэдлэг өөрсдөд нь байгааг;
- Тэдний үлгэр жишээ хүүхдүүдэд нь төдийгүй хүүхдүүдийнх нь хүүхдүүдэд адислал болохыг;
- Үйлчлэх явцдаа өнө мөнхийн нөхөрлөл үүсгэж байгааг;
- Гэрлэлт нь өдөр ирэх тусам улам бүр хүчирхэгжиж байгааг;
- Их Эзэний нэрээр үйлчлэх нь хэчнээн сайхан болохыг ухаардаг.

Дурсамж бий болгох мөчүүд

Хайрт ахмад хосууд аа, та нарын ихэнх нь ийм мөчийг мэдрэхийн төлөө хичээх хэрэгтэй. Чилид үйлчилж байсан ахмад хосын хийсэн зүйлийн талаар Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холландын ярьсан түүхийг санаарай. Залуу ахлагчдын нэгнийх нь аав өөд болсон байна. Номлолын ерөнхийлөгч уг номлогчийн байгаа газарт тэр даруй очиж чадахааргүй хол байжээ.

Ахлагч Холланд “Тэр газарт нэгэн сайхан сэтгэлтэй [төлөв даруухан] номлогч хос үйлчилж байсан бөгөөд

тэд номлогч дээр ирж, номлолын ерөнхийлөгчийг холбоо барьтал дэргэд нь байж, түүнийг халамжилж, санаа тавьж байв. Манай номлолуудад гайхалтай сайн залуу номлогчид байдаг байсан. Гэхдээ тэр ахмад хосын энэхүү ахлагчийн төлөө хийсэн зүйлийг ямар ч залуу номлогч хийж чадахгүй билээ”¹ гэж хэлсэн.

Тэр мөчид тэдэнд байсан энэ чадвар бол ердөө л залуу ахлагчид яг хэрэгтэй үед нь нинжин сэтгэлээр хандсан явдал юм. Тэд Христийнхтэй адил хайрын хэлээр ярихаас илүү өөр зүйл хэлэх хэрэггүй байсан. Ач, зээгийнх нь төрсөн өдөр эсвэл нэрийн адислал чухал байж болох ч тэд эдгээрт санаа зовоогүй. Харин тэд, Их Эзэн аль нэг хүүхдийнхээ амьдралыг адислахдаа өөрсдийг нь хаана байгаасай гэж хүссэн, тэрхүү газарт нь байхыг л чухалчилсан. Тэд хүссэн учраас л Их Эзэн Өөрийг нь төлөөлөхийг тэдэнд зөвшөөрсөн юм.

Үйлчлэл хийхэд үргэлж таатай байдаггүй

Үнэнийг хэлэхэд, гэрээсээ явах нь ямар ч ахмад номлогчид тааламжтай санагддаггүй. Иосеф Смит, Бригам Янг, Жон Тэйлор, Вилфорд Вудрафф нарын хэнд нь ч гэрээсээ явах сайхан байгаагүй. Тэд ч бас хүүхдүүдтэй мөн ач, зээ нартай байсан бөгөөд тэдэндээ бидний адил хайртай байсан. Гэсэн ч тэд бас Их Эзэнд хайртай бөгөөд Түүнд үйлчлэхийг хүсэж байсан билээ. Бид хэзээ нэгэн өдөр энэ эрин үеийг байгуулахад тусалсан тэдгээр үнэнийг баримтлагчтай уулзах болно. Бид тэдэнтэй уулзах үедээ үйлчлэх боломжоос татгалзаагүйдээ баясах болно.

Зарим хүн гэртээ амьдрангаа үйлчлэхийг илүүд үздэг. Аазэ Шумахер Нэлсон (Нэлсон ахын хамаатан биш)

цус харвасны улмаас тэргэнцэр дээр суудаг болсныхоо дараа, нөхөр Донтойгоо хамт номлолд үйлчлэх удаан хугацааны хүсэл мөрөөдөл нь биелэхгүй болсонд санаа зовж байжээ. Тэгтэл хөрш нь тэдэнд бишопын агуулахад Сүмийн үйлчлэлийн номлогчоор үйлчилдэг тухайгаа ярьжээ. Тэд түүнээс урам авснаар агуулахын ахлах ажилтантай ярилцан, өргөдлийн маягт бөглөж, гэрийнхээ ойролцоо байдаг агуулахад долоо хоногийн хоёр өдөр үйлчлэхээр дуудагдсан юм.

“Зүгээр амарч, хэвтээд, ‘Өө, би одоо ямар ч хэрэггүй болсон хүн’ гэж бодох амархан. Гэхдээ одоо *би* хэрэгтэй хүн гэдгээ мэдэрдэг. Энэ нь миний хувьд гэрчлэл болж байна” хэмээн Аазэ Нэлсон хэлсэн юм.

Та нар үнэхээр хэрэгтэй хүмүүс

Хэрэв та нар өөрсдийгөө хэрэггүй гэж бодож байгаа бол хэрэгтэй хүмүүс гэдгийг тань би баталж байна. Ахмад хосуудыг номлолдоо хүлээн авч, үйлчлүүлэхийг хүсэхгүй нэг ч номлолын ерөнхийлөгч Сүмд байхгүй. Ахмад номлогчид залуу ахлагч ба эгч нарыг сүнслэг байдлаар нь хүчирхэгжүүлдэг. Тэд үүрэг хариуцлагадаа илүү сайнаараа үйлчлэхэд бусдад тусалж, дэмжлэг болж өгдөг. Сүмийн гишүүн болоод хэдхэн жил болж байгаа удирдагчийн хувьд олон жилийн туршлагатай гишүүнээс тусламж авах нь ямар чухал утга учиртай болохыг та нар төсөөлж байна уу? Ахмад номлогчид ихэнхдээ бишоп, салбарын ерөнхийлөгчдийн залбирлын жинхэнэ хариуцал болдог.

Бид номлолын ерөнхийлөгчдийг номлолынхоо хэрэгцээ шаардлагыг хангахын тулд ахмад хосуудыг хайж олоход урамшуулан дэмждэг. Бишопууд үйлчлэх боломжтой хосуудыг хайж олох хэрэгтэй. LDS.org дээр ахмад хосуудын үйлчилж болох боломжуудыг харуулсан уртаас урт жагсаалт бий. Гэхдээ хамгийн чухал нь хосууд өвдөг сөгдөн, Тэнгэрлэг Эцэгээсээ одоо энэ нь тэдний хамтдаа номлолд үйлчлэх цаг мөн эсэхийг асуух хэрэгтэй. Энэ



Өмнөд Солонгосын Сөүлд үйлчилж байгаа ахмад номлогчид хамтдаа үйлчлэх туршлага нь хэчнээн сайхан байгаад баяртай байна.

бүх хэрэгцээн дотроос үйлчлэх хүсэлтэй байна гэдэг нь хамгийн чухал юм (С ба Г 4:3-ыг үзнэ үү).

Би ахмад номлогчдын ажлыг магтан сайшаахын зэрэгцээ үйлчлэхийг хүсэж байгаа ч үйлчлэх боломжгүй олон хүн байгааг ойлгож байна. Насны болон эрүүл мэндийн асуудал, гэр бүлийн гишүүдийн чухал хэрэгцээ шаардлагыг хүндэтгэх шалтгаан гэж үзэж болно. Үйлчлэх хүсэл тань дүрэлзэн асаж байгаа ч иймэрхүү хүндрэл байгаа бол та бусдыг гар хөлөө болгон үйлчилж мөн шаардлагатай санхүүгийн тусламж үзүүлж болно.

Ахмад хосууд аа, та нар хаана байгаагаасаа мөн хэн гэдгээсээ үл шалтгаалан ахмад номлогчийн энэхүү гайхалтай хормыг хамтдаа бүтээх боломжийн төлөө залбираарай. Тэнгэрлэг Эцэг танд юу хийхээ мэдэхэд тань туслах болно. ■

ЭШЛЭЛ

1. Жозэф Вокэрын бичсэнээр, Жэффри Р.Холланд, “Elder Jeffrey Holland: LDS Church Desperately Needs More Senior Missionaries,” *Deseret News*, 2011 оны 9-р сарын 14, 3.



Хамгийн дээд талд: Малмрозынхон бусдад үйлчлэхдээ авьяас чадвараа хэрхэн ашиглах талаар ярилцахаар ерөнхийлөгч Робисонтой тогтмол уулздаг. Дээд талд: Гана улсын Аккра хотын номлогчийг бэлтгэх төвийн залуу номлогчид ахлагч Малмроз, Малмроз эгч хоёроос дэмжлэг туслалцаа авах нь хуурай ээж, аав нь тэдэнтэй хамт үйлчилж байгаа мэт байдаг хэмээн ярьцгаав.



ГЭРТЭЭ ЭСВЭЛ ГЭРЭЭСЭЭ ХОЛ
Ахмад номлогч хосууд гэртээ эсвэл гэрээсээ хол үйлчлэхдээ, тойрог, салбар, номлолын оффис, зочлох төв, ариун сүм, хот хоорондын номлол, эмнэлгийн үйлчлэл, ажил олгох төв, бие даах чадвар хөгжүүлэх төвийн болон донтолтоос ангижрах хөтөлбөр, гэр бүлийн түүх, баримт бичиг хадгалалт, Сүмийн Боловсролын систем, олон нийттэй харилцах алба, хүмүүнлэгийн үйлчлэл зэрэг олон газарт үйлчилж болно. Илүү олон номлогч хос хэрэгтэй байна.



АХМАД НОМЛОГЧИД:

ХЭРЭГТЭЙ
БӨГӨӨД
АДИСЛАГДАЖ,
ХАЙРЛАГДСАН
ХҮМҮҮС

*Хосоороо номлолд
үйлчлэх нь таны
бодож байгаагаас
илүү уян хатан,
өртөг багатай
мөн илүү их баяр
хөөртэй байж
болох юм.*

Ричард М.Ромни
Сүмийн сэтгүүлүүд

“ТА ИРЖ, ТУСАЛЖ ЧАДАХ УУ?”

АНУ-ын Вашингтон мужийн Жэралд ба Лорна Малмроз нар урьд нь энэ асуултад хариулж байсан. Хуучин бишоп нь байсан номлолын ерөнхийлөгч нь тэднийг өөртэй нь хамт Вэст Индийн арлуудад үйлчлэхийг хүсэхэд тэд зөвшөөрсөн ажээ. Гадасны ерөнхийлөгч нь тэднийг АНУ-ын Юта мужийн Солт Лэйк хотод байрлах Сүмийн удирдах газарт компьютерийн болон хүний нөөцийн үйлчлэлийн номлолд дуудахад тэд мөн л зөвшөөрчээ.

Хуучин бишоп, номлолын ерөнхийлөгч асан Рийд Робисон энэ удаад Гана улсын Аккра дахь номлогчийг бэлтгэх төвийн ерөнхийлөгчийн хувьд Малмрозынхныг дахин нэг удаа туслаач хэмээн дуудсан байна.

Ахлагч Малмроз “Бид Их Эзэнд итгэж чадна гэдгээ мэдсэн” гэсэнээ, “Тэгээд бид Түүнд дахин итгэхээр шийдсэн юм” гэж хэллээ. Тэд зөвшөөрч, өргөдлийн маягтуудаа бөглөн, дуудлагаа хүлээн авч, Ганад удалгүй очсон ажээ.

Хосоороо үйлчлэх нь

Малмрозынхны туршлага номлолд үйлчилж буй ахмад номлогчдын талаарх нийтэд сайн ойлгогдоогүй зарим зарчмыг харуулдаг.

- *Хоёр төрлийн номлол байдаг. Тухайлбал:*
(1) Сүмийн ерөнхийлөгч ахмад хосуудыг гэртээ юм уу гэрээсээ хол үйлчлэхэд дууддаг. (2) Гадасны ерөнхийлөгч орон нутгийн болон бүсийн хэрэгцээг

хангахаар долоо хоногт 8-аас 32 цаг үйлчлэх Сүмийн үйлчлэлийн хос номлогчдыг дууддаг. Тэд ихэнхдээ орон нутагтаа амьдарч, үйлчилдэг боловч заримдаа гэрээсээ хол үйлчилдэг.

- *Номлолын ерөнхийлөгчдийг номлолынхоо хэрэгцээнд тохирох хосуудыг олоход урамшуулан дэмждэг бөгөөд хосууд хүсэлтээ ирүүлж болдог.* “Бид хосуудыг номлолоо өөрсдөө шилж сонгож болно гэж байгаа юм биш” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд тайлбарлалаа. “Дуудлага л бол дуудлага. . . [Гэвч] бид ахмад хосуудтай үйлчлэлийнх нь сонголтын тухай ярилцаж, тэдний хаана, хэрхэн үйлчлэх талаарх бүхий л зүйлийг анхааралтай авч үздэг.”¹
- *Номлолын ерөнхийлөгчид хосуудын ур чадварыг хэрхэн хамгийн сайн ашиглаж болох талаар тэдэнтэй зөвлөлддөг.* “Ахмад номлогчийн хувьд хамгийн утга учиртай туршлага олж авахын тулд” “өөрийн ажиллахыг хүсэж байгаа болон ямар нэгэн зүйл санал болгохуйц ур чадвараа ашиглах боломжтой салбарт ажиллах хэрэгтэй” хэмээн ерөнхийлөгч Робисон хэлсэн юм.

Тухайлбал, ихэнх африк хүн францаар ярьдаг тул ахлагч Малмрозын франц хэлээр ярьдаг нь тус болно гэдгийг ерөнхийлөгч Робисон мэдсэн ажээ. Ерөнхийлөгч Робисон “Би түүнийг аялалд оролцож, визний асуудлыг



БҮРЭН ЦАГИЙН НОМЛОЛД ҮЙЛЧЛЭХ БОЛОМЖ ГАРГААРАЙ.

“Номлолд ахмад хосууд хэрэгтэй байна. . . . Бүрэн цагийн номлолд үйлчлэх боломж гаргаарай. Эзэний ажилд хамтдаа бүрэн цагаар үйлчилснээр ирэх хангалуун, сүнслэг байдлыг эдлэх цаг амьдралд тань цөөхөн тохионо шүү.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Бид дахин уулзлаа,” 2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 4.



хариуцна байх гэж төсөөлсөн” хэмээн ярив. “Гэвч түүнийг энд ирэхэд, жинхэнэ сонирхдог зүйл нь биш болохыг би мэдэрсэн. Тиймээс би түүнийг компьютерийн ур чадвараа ашиглахад урив. Тэр манай системийг хялбарчилж, хэрэгтэй тайлангуудыг боловсруулан, өчнөөн олон цагийг хэмнэхэд тусалсан юм.” Ахлагч Малмроз номлогчдод, ялангуяа францаар ярьдаг номлогчдод гэр бүлийнхээ нэрсийг бэлтгэж, ариун сүмийн ажлыг хийхэд нь тусалдаг. Малмроз эгч эмнэлгийн мэргэшсэн туслах байсан тул номлолын эмч, сувилагч нартай хамт ажиллахаар томилогдсон байна.

Тэрээр замыг бэлтгэдэг

Малмрозынхантай адил, бусад хос ч бас Их Эзэнд итгэх үед Тэр замыг нь бэлтгэдэг гэдгийг мэдэж авчээ. Яг л тийм зүйл Филиппиний Кабитэ мужийн Кавит хотын Алвин болон Коразон Риета нарт тохиолджээ.

“Бид үйлчлэхээр шийдэхээсээ хоёр жилийн өмнөөс гэр бүлийнхээ бизнесийн талаар баттай төлөвлөж эхэлсэн” гэж ахлагч Риета тайлбарлалаа. “Манай хүү, охин хоёр коллежээ төгссөн болохоор бизнесээ хариуцаж болох байсан ч бизнесийн асуудлуудаа хэн шийдэж байх, үйлчлүүлэгчид маань бидний төлөвлөгөөнд хэрхэн хандах бол зэрэгт бид эргэлзэж байв.”

Риета эгч мөн өндөр настай ээжийгээ орхин явахдаа санаа нь зовж байжээ. “Биднийг хол байхад ээж минь нүд анчих вий гэхээс би айж байсан” гэж тэр ярив. “Би бас сайн мэдээг заахад бэлэн биш байгаагаа мэдэрсэн.”

Тэд бишоптойгоо болон Давао номлолд саяхан үйлчлээд ирсэн хостой зөвлөлдөжээ. “Тэд Их Эзэн хос бүрийн ар гэрийн асуудал, гэр орон, номлолын хөрөнгийн эх үүсвэрийн талаар шийдвэр гаргахад нь туслан удирддаг гэсэн хүчтэй гэрчлэлээ хуваалцсан” хэмээн Риета эгч хэлэв.

“Бид удирдамж эрэлхийлснээр” “айдас маань шийдвэрлэгдэж, бидний бизнес асуудалтай байсан ч амжилттай явагдаж,

үйлчлүүлэгчид маань бас баяртай байгаагаар илэрхийлэн, тус дэм үзүүлж, өвчтэй ээжийг маань асрахдаа гэрийнхэн маань хоорондоо илүү ойр дотно болсон. Их Эзэн үнэхээр бидэнд тусалдгийг бид ойлгож эхэлсэн” гэж Риета ах ярив.

Риетагийнхан одоо Филиппиний Кагааян дэ Оро Номлолд гишүүд, удирдагчдыг дэмжин үйлчилж байна.

Таны хийж чадах олон зүйл бий

Зарим хос бие махбодын хязгаарлагдмал байдалдаа эргэлздэг бол АНУ-ын Юта мужийн Кийт, Жэннилин Мауермэн нарт тэр нь асуудал биш байлаа. Кийт олон жилийн өмнө Калифорнийн Лос Анжелес ариун сүмд гэрлэснээсээ хойш дөрвөн сарын дараа цэрэгт татагдаж, дайнд явжээ. Нисэх хүчний багийн ахлагч тэрээр газрын мина дэлбэрэхэд бусад цэрэгтэй хамт урд эгнээнд явж байсан аж. Тэр хоёр хөлгүй болсон байна. Түүнийг гэртээ эргэн ирэхэд Женнилин түүн рүү гүйн очжээ.

Кийт “бид мөнхөд гэрлэсэн учраас би санаа зовох хэрэггүй гэдгээ мэдэж байсан” гэж хэлсэн юм. Мөн тэрээр “Эхнэр маань намайг үргэлж дэмжсээр ирсэн. Тэр одоо ч гэсэн намайг өдөр бүр дэмждэг” гэж хэлэв.

Тэд Мауермэн эгчийг тэтгэвэртээ гарахаар номлолд үйлчлэхээр шийджээ. Гэвч ахлагч Мауермэн хоёр хөлгүй байгаа нь асуудал учруулах болов уу? “Надад хийж чадахгүй зүйлс үргэлж байсан,” “гэхдээ бас миний хийж чадах олон зүйл бий. Бидэнд тохирох газар байгаа гэдгийг ч бид мэдэж байсан” хэмээн тэр ярьсан юм.

Тэд өргөдлийн маягтаа бөглөж байхдаа цэргийн алба хаасан гэж тэмдэглэжээ. Тэд удалгүй Сүмийн Цэргийн харилцах алба наас дуудлага хүлээн авсан байна. “Надад цэргийн баазуудад нэвтрэх эрх бүхий үнэмлэх байсан тул тэд биднийг цэргийн харилцаа хариуцсан номлолд санал болгохыг зөвшөөрөхийг хүссэн юм.”

Мауермэнийхэн АНУ-ын Хойд Каролина мужийн цэргийн баазад

үйлчлэхээр дуудагдсан билээ. Ахлагч Мауремэн дурсан ярихдаа: “Гадна хаалган дээрх хаяг нь ‘Форт Брагг, Нисэх хүчний анги’ гэсэн байсан. Харуул бидэнтэй ‘Эцсээ хүртэл!’ гэсэн нисэх хүчний уриаг хэлж мэндэлсэн нь энэхүү үгсийг олон жилийн дараа анх удаа сонссон минь байлаа. Би Форт Браггт өмнө нь хэзээ ч ирж байгаагүй ч гэртээ байгаа юм шиг санагдаж билээ. Номлолын дуудлага маань бидэнд яг тохирсон болохыг мөн Их Эзэн надад санаа тавьдгийг би мэдсэн юм.”

“Бид бие даах чадвартай, сэтгэлийн хаттай болох мөн гэрлэлтээ хүчирхэгжүүлэх талаар хичээлүүд заадаг

Бүх нийтийн хэл

Ютагийн Рэнди, Лоу Элэн Ромрелл нар Бразилын Кюаба Номлолд дуудагдахдаа санаа зовж байжээ. Хэдийгээр ахлагч Ромрелл залуу байхдаа Бразилд номлолд үйлчилсэн ч тэрээр португаль хэлээ мартсан аж. Ромрелл эгч португаль хэл мэддэггүй. Хэлээ судалж, хичээн чармайсны ачаар ахлагч Ромреллийн португаль хэл сэргэж, Ромрелл эгч ч бас хэл сурч эхлэв. Тэдний укулэлэ тоглох чадвар ч мөн адил сайжирчээ.

“Би укулэлэг авчрахаар төлөвлөөгүй,” “харин ахлагч Ромрелл авчрахаар шийдсэн бөгөөд үр нөлөөг нь харахад гайхалтай байна хэмээн Ромрелл эгч хэлсэн юм. Бид



Санхүүгийн байдлаасаа болоод, ахлагч Риета, Риета эгч нар өөрсдийн эх орон болох Филиппиндээ үйлчилж байгаа юм.



Мауремэнийхний хувьд цэргийн харилцаа хариуцсан номлолд үйлчлэх нь яг тохирч байлаа. “Энэ нь гэртээ байгаа юм шиг л санагддаг” гэж тэд хэлсэн.



Ромреллийнхэн укулэлэгээ авч яван, айлуудаар зочлохдоо бүх нийтийн хэл болох хөгжмийг хуваалцан, дуулал дуулдаг.

байсан” гэж Мауремэн эгч ярив. “Эхэндээ бид өөрсдийн түүхийг ярих дургүй байсан ч хуваалцах нь ямар их өөрчлөлтийг бий болгож байгааг ойлгосон юм. Цэргүүд болон тэдний эхнэр, нөхрүүд биднийг хараад, ‘Та нар хийж чадсан юм бол бид ч бас хийж чадна’ хэмээн хэлдэг байв.”

Мауремэнийхэн Хойд Каролинад үнэхээр гайхалтай туршлага хуримтлуулсан тул дахин номлолд үйлчлэхийг хүсчээ. Өнөөдөр тэд Сүмийн цэргийн харилцаа хариуцсан газарт үйлчлэхээр долоо хоногт хоёр удаа Орем хот дахь гэрээсээ Солт Лэйк хот руу 40 бээр (64 км) зам туулан очдог. Тэд мөн Прово хот дахь номлогчийг бэлтгэх төвд ахмад номлогчдод заадаг. Тэндээс тэд үйлчлэхийн тулд саад бэрхшээлийг даван туулсан хэн нэгэн хүн бүлэг бүрд байгааг олж мэджээ.

сонирхогчдод заахдаа болон гишүүдийг идэвхжүүлж, тэдэнтэй нөхөрлөхдөө мөн хүмүүсээр дуулал дуулуулахдаа үүнийг ашиглах нь сайхан байдаг. Бид хэлээ сурч байгаа бөгөөд дуулал ч бас хүмүүст сүнснийг хүчтэй мэдрүүлдэг” хэмээн ярьсан билээ.

Түүний португаль хэл сайжирсаар байгаа бол тэр харин хөгжмийг аль хэдийн гарамгай сайн тоглодог болсон. “Хөгжим хүмүүсийг нэгтгэдэг” гэж тэр хэлдэг. “Би айлчлах үедээ тэдний хэлсэн бүх зүйлийг ойлгодоггүй ч бид дуулах үедээ тэдэнтэй холбогддог юм.” Ромреллийнхэн сургуулиудад Америкийн Талархлын баярын тухай ярихаар уригдахдаа талархлын тухай дууллыг укулэлэ тоглон дуулжээ. Ромрелл эгч арай энгийн зэмсэг болох төгөлдөр хуурыг сүмд дуулал дуулахад тоглодог.

Харин португаль хэлний хувьд? “Хэдий сайн мэдэхгүй ч сурсан цөөн үг маань хэрэг болдог” гэж тэр хэлэв.



“ХИЙ ГЭСНИЙГ ТАНЬ ХИЙХ БОЛНО БИ”

“Би ахмад номлогчид ямар их хэрэгтэйг бодохдоо, ‘Хаа дуудсан ч би үйлчлэх болно’ хэмээх сайхан дууг (Дуулал, дугаар 270) болон ‘Хий гэснийг тань хийх болно би’ гэсэн захиасыг санадаг билээ.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс



ХОСУУД ХЭРЭГТЭЙ БАЙНА

“Бүх хосод хандан та бидэнд хэрэгтэй гэсэн захиасыг бид хэлмээр байна. Бид таныг номлолд явах боломжтой болгохын төлөө чадах бүхнээ хийж байгаа. . . . Энэ цаг үед л та хэрэгтэй байна. Та нар хүмүүст хэрэгтэй. Номлолд яваарай.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, *Deseret News*, 2011 оны 9-р сарын 14.

“Зүгээр л сайн уу хэмээн хүмүүстэй мэндлэх нь их чухал. Та сурч байгаагаа тэдэнд харуулах хэрэгтэй. Энгийн байж, Сүнсэнд найд.” Сүнс хүн бүрийн ойлголцдог хэл гэдэг нь мэдээж шүү дээ.

Гэртээ үйлчлэх нь

Ютагийн Паул, Мар Жийн Льюис нар хамтдаа гурван номлолд (Нью-Йоркийн Палмирагийн ариун сүм; Хятадын Хонконгийн ариун сүм; Хорват, Серб, Словений институт, семинар зэрэгт) үйлчилжээ. Тэднийг дахин нэг номлолд үйлчлэхээр

хүмүүс байсан. Тэднийг эргэн ирж, ёслолуудыг хүлээн авч, ариун сүм рүү явахыг харах нь гайхамшигтай адислал юм” гэж Льюис эгч хэлэв.

Ахлагч Льюис “Олон хос номлолд үйлчлэх тухай бодохдоо гэр орон, машинаа яах билээ, эсвэл гэр бүлийнхээ чухал зүйлд оролцохгүй өнгөрөх вий хэмээн санаа зовдог” гэж хэлэв. “Бид гэртээ амьдарч, машинаа ч барих боломжтой байгаа. Номлогчийн үүрэгтэй маань зөрчилдөхгүй бол бид гэр бүлийнхээ үйл ажиллагаанд оролцож болно. Бид ачийгаа төрөхөд ч бас энд байсан.”



Гэрээсээ үйлчилж буй Льюисийнхэн гадасныхаа бүрэн цагийн номлогч, гишүүдтэй танилцахдаа дуртай байдаг.



Сорэнсэнийнхэн Күкийн арлуудын сургуулийн хүүхдүүдэд жижиг чулуунууд өгч, тэднийг “Христ дээрх бат бөх хад” болохыг сануулдаг.

бэлтгэж байх үед гадасны ерөнхийлөгч нь “Та нар энд өөрсдийнхөө гадсанд үйлчилж, амьдарч буй газрынхаа номлолд туслах боломжтой юу?” хэмээн асуужээ.

“Бид энд шинээр ирсэн тул энэ нь гайхамшигтай боломж байлаа” хэмээн Льюис эгч яриу. “Бид залуу ахлагч, эгч нартай хамт үйлчилж, номлолын ерөнхийлөгчтэй ойр байж, дүүргийн болон бүсийн хурлуудад суун, тойргийн номлолын удирдагчидтай хамт ажилладаг.” Тэд мөн сонирхогчид ба идэвх султай гишүүдийн гэрт зочлон очдог.

“Бид хэзээ ч уулзах боломжгүй байх байсан гайхалтай хүмүүстэй уулзсан,” “тэдний зарим нь явах замаасаа татгалзсан

Гэр бүлийн адислалууд

Харин Льюисийнхэнтэй нэг гадсанд харьяалагддаг Жилл, Кент Сорэнсэн нар гэр бүлээ хүчирхэгжүүлэх хамгийн шилдэг арга бол гэрээсээ хол үйлчлэх явдал хэмээн үздэг. Сорэнсэн эгч хэлэхдээ “Хосууд номлолд явахгүй байгаагаа ач зээ нар, асуудалтай байгаа гэрлэсэн хүүхдүүд, хүүхэдтэй болох гэж буй охид, өндөр настай эцэг эх гээд олон зүйлээр шалтагладаг. Гэр бүл хамгийн чухал бөгөөд та тэднийгээ өдөр бүр санадаг. Гэхдээ номлолд явах нь номлогчийн ажил ч бас чухал юм гэсэн хүчирхэг захиасыг өгдөг юм” гэжээ.

Үүнээс гадна ахлагч Сорэнсэн “Одоо цагт байнга холбоо барих маш олон арга

зам бий болсон” гэдгийг онцлон тэмдэглэсэн.

Сорэнсэнийнхэн гурван жилийн өмнө бишоп нь тэднийг номлогчийн үйлчлэлийн тухай бодож буй хосуудад зориулан сар бүр галын дэргэдэх цугларалт хийхийг хүссэнээр номлогчийн аяллаа эхлүүлжээ. “Энэ талаар байнга ярьсаар байгаад, сүүлдээ бид өөрсдөө явахаар шийдсэн!” гэж Сорэнсэн эгч ярих. Тэд Жиллийн өвөө, эмээгийн 50 жилийн өмнө үйлчилсэн Күкийн арлуудад үйлчлэхээр дуудагдажээ.

Өнөөдөр тэд бусад үүргийнхээ хажуугаар сургуулиудад Библийн хичээл заахаар уригдсан.

“Бид Христийг хад хэмээн ярьдаг” гэж ахлагч Сорэнсэн хэлэв. “Бид сурагчдад жижиг чулуу өгөөд,



Дэлхий даяарх хосууд бусдад үйлчлэхээс гадна, хамтдаа үйлчлэх нь гэрлэлтийг хүчирхэгжүүлж, тэднийг Тэнгэрлэг Эцэгтэй илүү ойртуулдаг гэж ярьцгаадаг.

тэднийг Христ дээр хад мэт бат бөх үлдэхэд зоригжуулдаг. Одоо биднийг хаашаа ч явсан, хүмүүс биднийг харахаараа ‘Бат бөх хад!’ гэж хэлдэг болсон.”

Ирж, тусал

Хэрэв та бүрэн цагийн номлолд эсвэл Сүмийн үйлчлэлийн номлолд явахаар төлөвлөж байгаа бол эдгээр хос танаас ерөнхийлөгч Робисоны Жэралд, Лорна Малмроз хоёроос асуусан шиг “Та ирж, тусалж чадах уу?” л гэж асуух болно. Таны хэрхэн үйлчлэхээс үл хамааран, та хэрэгтэй, та хувь нэмрээ оруулж чадна, та адислагдан, хайрлагдах болно гэсэн амлалтыг тэд танд өгөх болно. ■

ЭШЛЭЛ

1. Ахлагч Жэффри Р.Холланд; LDS Church Desperately Needs More Senior Missionaries,” *Deseret News*, 2011 оны 9-р сарын 14, deseretnews.com.

ҮЙЛЧЛЭХ ОЛОН АРГА ЗАМ

Үйлчлэх боломжуудын талаар болон одоо үйлчилж буй хүмүүсээс туршлага сонсож, асуултууддаа хариулт авахыг хүсвэл, lds.org/callings/missionary хаягаар орно уу.

УРЬД ӨМНӨ ХЭЗЭЭ Ч БАЙГААГҮЙ ТИЙМ ХЯЛБАР БОЛСОН

Уян хатан бодлогууд нь хосуудыг үйлчлэхэд илүү амар хялбар болгож өгсөн.

- Сүмийн үйлчлэлийн хосууд гэртээ амьдарч, орон нутагтаа үйлчилж болно.
- Номлогч хосууд 6, 12, 18 эсвэл 23 сараар үйлчилж болох ба хэрэв тэд аяллын зардлаа өөрсдөө төлсөн бол өөр улс оронд 18 хүртэлх сарын хугацаанд үйлчилж болно.
- Хосууд номлолд үйлчилж байх хугацаандаа ар гэрийн чухал шаардлагаар богино (7-10 хоногос илүүгүй) хугацаагаар гэр рүүгээ өөрсдийн зардлаар буцаж очиж болно.
- Орон байрны зардлыг тогтоосон байдаг. Хосууд орон байрны зардалдаа түрээс, хэрэглээний зардал, тавилга зэргийг оролцуулан тогтоосон хэмжээнээс илүүг төлдөггүй.
- Орон байр нь аюулгүй бөгөөд тухтай байх болно. Номлолууд болон бүсийн удирдах газрууд цэвэр, боломжийн тавилгатай, хэмнэлттэй байр сууцыг бэлддэг.
- Ажлын хуваарь нь ачаалал багатай. Хосууд ганц бие залуу номлогчдын нэгэн адил ажлын цаг ба үйл ажиллагааны хуваарийг дагах шаардлагагүй.
- Гэр бүлтэйгээ байнга холбоотой байдаг. Хосууд ганц бие залуу номлогчдоос илүү олон удаа гэр бүлийнхэнтэйгээ холбоо барьж болдог.



Порнограф
гэр бүлд
НӨЛӨӨЛСӨН ҮЕД
ЭХНЭР, НӨХӨР ХОЁР
ХОЁУЛАА ЭДГЭРЧ
ИЛААРШИХ ХЭРЭГТЭЙ

Нөхрүүд нь порнографын асуудалд орооцолдоход тэдэнд төдийгүй эхнэрүүдэд нь Аврагчийн эдгээх хүч ирдгийг би өөрийн биеэр харсан.



Нэрийг нууцлав

Бишопоор үйлчилж байсан эхний зургаан сарын дотор тойргийн маань нэлээн хэдэн хос надад итгэж, нөхрүүдээ порнографын асуудалтай байгааг хэлсэн юм. Зарим тохиолдолд эхнэр нь энэхүү итгэхийн аргагүй нууцын талаар олж мэдэнгүүтээ цочролд орсон байхад, зарим нь олон сар, жилийн турш энэ тухай мэддэг байв.

Надад эдгээр хосын хүн нэг бүрийг өрөвдөх сэтгэл төрсөн бөгөөд би “[тэднийг] бөх гэгч нь хүлэх хүсэлтэй

. . . түүний гинжийг сэгсрэн хаяхад” (2 Нифай 9:45) нь ах бүрд туслан, тогтмол, болгоомжтой зөвлөснөөр Аврагчийн гэтэлгэлийн хүчийг мэдэрсэн юм.

Хэдий тийм ч би тэдний эхнэрүүдтэй уулзаж байхдаа Сүнсний хамгийн их мэдэрсэн. Зарим хүний шарх шинэхэн, заримынх нь олон жилийн зовлонгийн үр дүнд сорвижсон хэдий ч эдгээр эгч бүгдээрээ “Би чухам яачихсан учраас тэр надад татагдахаа больсон юм бол?” эсвэл “Яагаад тэр өөрийгөө надаас өөр хүнтэй хамт байгаагаар төсөөлдөг юм бол?” гэх зэрэг асуултуудаас үүдэлтэй сүнсний гүн шархаа эдгээхийг хичээж байгааг би олж мэдсэн юм.

Нөхөр нь нүгэл үйлдсэн тул нөхөрт нь л Аврагчийн анагаах хүчийг нээх түлхүүрүүд хамгийн их хэрэгтэй гэж бишоп бодож болох юм. Гэвч эхнэрийнх нь шарх, зовлон шаналлаа эдгээх хэрэгцээ нь нөхрийнх нь нүглээсээ болон тэсэхийн аргагүй хүслээсээ эдгэрэх хэрэгцээтэй адил чухал гэдгийг би ойлгосон билээ.

Бошиглогч Иаков нифайчуудад хандан ярихдаа “Мөн түүнчлэн Бурханд таалагдах зүйл болох Бурханы өмнө олон нь үлэмж энхрий болоод ариун мөн эмзэг мэдрэмж бүхий тэдгээр” (Иаков 2:7) хэмээн эхнэрүүдээ үнэнч бус байгаа эрчүүдийг буруушаажээ. Тэрээр цааш нь: “Та нар цэвэр эмзэг эхнэрүүдийнхээ зүрхийг эмтэлж, мөн тэдний өмнө өөрсдийн муу жишээнүүдийн учир, . . . мөн тэдний зүрхний мэгшилгүүд та нарын эсрэг Бурхан өөд дээш ирж байна” гэжээ (Иаков 2:35). Би тэрхүү мэгшилтийг өөрийн биеэр гэрчилсэн юм. Тэдгээр мэгшилт нь нөхрийнхөө порнографын хэрэглээнээс болж хууртагдсанаа мэдрэх хүчтэй мэдрэмжээс нь гарч буй төдийгүй нөхрийнх нь дотоод тэмцлээ илэрхийлэх доромжлолын үгс, ууртай ширүүн зан авираас болдог. Муу зуршил нь ил болоход, нөхөр нь эхнэрээ янз бүрийн зүйл хийсэн эсвэл хийгээгүйгээс өөрийг нь ийм байдалд хүргэсэн хэмээн буруутгах нь хэвийн үзэгдэл юм. Хамгийн эмгэнэлтэй нь, эхнэр нь тэдгээр гүтгэлгийг өөртөө шууд тусган авч, итгэх нь түгээмэл байдаг.

Нөхөр нь бага залуугаасаа порнографт донтсоноо илчилснээс хойш хэдхэн хоногийн дараа миний өрөөнд яг тийм байдалтай хос сууж байлаа. Эхнэр

нь Халамжийн нийгэмлэгийн ангидаа сууж, 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр Линда С.Рийвс эгчийн “Христэд төвлөрсөн гэр орон—порнографын эсрэг хамгаалалт” хэлсэн үг дээр үндэслэсэн хичээлийг сонсож байхдаа өөрт нь ханддаг нөхрийнх нь зан авир багшийн дүрсэлсэн хандлагуудтай адил байгааг анзаарчээ. Хичээлийн дараа тэр эмэгтэй нөхрөөсөө энэ тухай асуултал нөхөр нь урт удаан хугацаанд хадгалсан нууцаа илчилсэн байна. Тэр эмэгтэйн аль хэдийн үгүй болсон өөрийгөө хүндлэх үзэл одоо тэсэхийн аргагүй их гомдлыг бий болгожээ. Тэд надтай эхний удаа уулзаж байхдаа гэрлэлт нь цаашид хэрхэн үргэлжлэхийг ч мэдэхгүй байсан. Би тэдэнд найдвар байгааг батлан хэлээд, эхний зөвлөгөөгөө өгч, дараа нь ганц ганцаараа тусдаа уулзахыг урьсан юм.



САНВААРЫН УДИРДАГЧИД ХЭРХЭН ТУСАЛЖ ЧАДАХ ВЭ

Удирдагчид порнографас болж зовж буй гишүүдийн хань ижилтэй ажиллаж байхдаа ярих, өөрсдийгөө ойлгуулах боломжийг тэдэнд олгох нь тэдний хувьд ямар ч зөвлөгөөнөөс ялгаагүй чухал юм. Ministering Resources (ministering.lds.org) дээрх дараах зөвлөгөөг анхаарч үзээрэй. Үүнд:

- Тогтмол уулзаж, дэмжлэг үзүүл.
- Порнограф хэрэглэгчийн хань ижлийн өөрийг нь эдгээх Аврагчийн чадварыг онцол (Алма 7:11 ба Матай 11:28–30-ийг үзнэ үү).
- Боломжтой бол уг хүнийг донтолтоос ангижрах цуглаанд юм уу үүнтэй төстэй дэмжих бүлэгт хамрагдахад урь.

- Хоорондоо харилцахдаа болон гэр орондоо хэрхэн тодорхой хил зааг тогтоох талаар өөрийн гэсэн сүнс-лэг удирдамжийг хүлээн авч чадна гэдгийг ойлгоход хань ижилд нь тусал.
- Байнгын чухал дэмжлэг үзүүлж чадах итгэлтэй найз эсвэл гэр бүлийн гишүүнийг олоход хань ижилд нь тусал.
- Порнограф ашиглаж буй хүнд өөрийн хийсэн үйлдэлд хариуцлага хүлээдэг мөн ханиа дэмждэг байхад тусалж дэмж.
- Порнограф ашигладаг хүний хань ижилд мэргэжлийн тусламж эсвэл зөвлөгөө авахыг санал болго. Сайн мэдээний зарчмуудтай нийцэх үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн эх үүсвэрүүдийг олж мэд.



Доод талд: Керри нөхрөө порнографын асуудалтайг мэдээд, сэтгэлээр унасан боловч Есүс Христээр болон Түүний Цагаатгалаар дамжуулан итгэл найдвар, эдгэрийг олж авчээ.

Би тэдгээр уулзалтад бэлтгэн байнга залбирахын зэрэгцээ, LDS.org дээр байгаа Ministering Resources вэб сайтаас порнограф хэрэглэгчдийн хань ижилд дэмжлэг үзүүлэх тухай зөвлөгөөнүүдийг судалсан бөгөөд тэндээс дараах зүйлсийг уншсан юм: “Эхнэр, нөхөр хоёрт тэднийг хайрлаж, тэдэнд санаа зовж байгаага тус тусад нь илэрхийл. Тэрээр ханийнхаа порнографын хэрэглээнд эсвэл муухай ааш авирт нь хариуцлага хүлээхгүй бөгөөд хүчирхийлэгч зан байдлыг нь тэвчих шаардлагагүй гэдгийг тодруулж хэл.”

Би энэ эгчтэй уулзахдаа яг ингэж зөвлөсөн бөгөөд дээр нь нэмж, нөхрийнх нь үйлдлүүд түүнтэй огт холбоогүй, түүний хийсэн эсвэл хийгээгүй зүйлсээс шалтгаалаагүй, харин ч нөхрийнх нь өөрийн дотоод зөрчлөөс болсон гэдгийг батлан хэлсэн юм. Энэ үгсийг сонсоод тэр эмэгтэйн тайвшрахыг би харсан бөгөөд тэдгээр үг үнэн болохыг нотлох Сүнсний баталгааг мэдэрсэн. Ярилцлагын төгсгөлд тэрээр санваарын адислал өгөхийг надаас хүсэв. Тэр өөрийн нөхцөл байдлыг гэр бүл, найз нөхдөөсөө нууцалсан тул ганцхан надаас л адислал хүсэж болохыг би ойлгосон юм.

Би эдгэрэх үйл явцад нь туслахын тулд нөхрийг нь тухайн газарт байх хожмын үеийн гэгээнтний донтолоос ангилжрах цуглаанд урьж, эхнэрийг нь хань ижил, гэр бүлийн гишүүдэд зориулсан цуглаанд явахад урамшуулан дэмжив. Тэрээр зовлонг нь ойлгох бусад эгчтэй уулзаж, тайтгаран, адилхан

зовлонг туулж, дахин нийлсэн хосуудыг хараад, итгэл найдвар төрснөө надад хэлсэн.

Энэ хостой анх уулзсанаас хойш хэд хэдэн сар өнгөрч, тэдэнтэй олон удаа харилцах тусам тэднийг улам бүр хайрлаж, сэтгэл зовних болсон байв. Тэдний цаашдын аян зам саад бартаагүй байхгүй ч, сараас сард нөхөр нь хүсэл тачаал, порнографас хол байж мөн түүний эхнэр өөрийн үнэ цэнэ, өөртөө итгэх итгэлээ улам нэмэгдүүлсэн байхыг харах нь миний хувьд баяр хөөр юм.

Тэдэнтэй саяхан ярилцах үед, урьд нь уулзахад байдаг байсан зовлон шаналал, нулимс нь байнгын инээмсэглэл, бүр инээд хөөрөөр солигдсон байлаа. Гэхдээ магадгүй хамгийн гол үр дүн нь тэдний гэрлэлт үргэлжлэхээр барахгүй, гайхалтай сайхан байж, өргөмжлөгдөх боломжтой гэх итгэл найдвар төрсөн явдал юм.

Харамсалтай нь, бүх хос ийм үр дүнд хүрэхгүй гэдгийг би хүлээн зөвшөөрдөг билээ. Порнограф ашигладаг хүн ахиц гаргахаас татгалзвал зарим гэрлэлт бүтэлгүйтдэг. Нөхөр нь ямар замыг сонгосноос үл хамааран эхнэрт нь тусалж, зөвлөх нь сүнслэгээр нөлөөлөгддөг гэдгийг би мэднэ. Би ийм нөхцөлд буй ямар ч эгчийг бишоп нь үл тоомсорлож, дутуу үнэлэн, буруугаар ойлгохгүй байгаасай хэмээн найдаж байна. Бишопын үйлчлэл бол Аврагч зүрх сэтгэл нэг бүрийг, тэр бүү хэл “гүнзгий шархнуудаас цоорч” (Иаков 2:35) үлдсэн тэдгээр зүрхийг бүрэн эдгээх хүчээ харуулдаг гол эх булаг юм. ■



ЭХНЭР, НӨХРҮҮДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ, ТАЙТГАРУУЛ

“Бид удирдагчдын хувьд, түүнчлэн порнографын донтолод автсан хүмүүсийн хань ижил, гэр бүлийнхэнд маш их санаа зовж байдаг. Ахлагч Ричард Г. Скотт: ‘Хэрэв та өөрөө ноцтой гэм нүгэл үйлдээгүй л бол өөр хэн нэгний нүглийн үр дагавраас болж дэмий бүү зовоорой. . . . Та хайр энэрлээр хандаж болно. . . . Гэхдээ та тэдний үйлдлийн үүрэг хариуцлагыг өөр дээрээ авах ёсгүй.’ Та нар ганцаараа биш гэдгээ мэдэж аваарай. Авч болох тусламж байгаа. Донтолоос ангилжрах цуглаануудад эхнэр, нөхөр хоёр гэрээсээ утсаар ярьж оролцох боломжтой болсон.”

Линда С.Ривес, Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, “Христэд төвлөрсөн гэр орон—порнографын эсрэг хамгаалалт,” 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 29.

ЦАМХАГ ДЭЭРХ ХАРУУЛУУД

“Иерусалим аа, Би чиний хэрмэн дээр манаач нарыг тавив. Тэд бүх л өдөржин, бүх л шөнөжин хэзээ ч дуугаа хураахгүй. Эзэнийг дурсагч аа, бүү амрагтун.”

Исаиа 62:6

Харуулууд


Харуулууд нь холоос ойртон ирж буй аюулаас сэрэмжлүүлж, анхааруулахын тулд хана хэрэм юм уу цамхаг дээр байрладаг харуулын цэргүүд байдаг байв. Тэд хот суурин, усан үзмийн талбай, тариаланг эсвэл бэлчээрийг хамгаалахаар ажилладаг байсан.

Цамхгийн төрлүүд

Хотын хэрмэн дэх цамхгууд нь ихэвчлэн хаалган дээр юм уу булангуудад баригддаг байжээ (Шастирын дэд 26:9-ийг үзнэ үү). Хаалган дээр болон буланд байрлах цамхгууд нь ирж буй аюулыг харж чадах, дайсны довтлолтоос хамгаалахуйц өндөрт байрладаг байв (Шастирын дэд 26:15-ыг үзнэ үү).

Цайз хэрэм нь голдуу өндөрлөг газарт юм уу бусад чухал газарт баригдсан, тусдаа орших барилга байгууламж байжээ. Дайралтад өртсөн үед зарим цамхаг нь хотын бүх хүн ам хоргодохуйц том хэмжээтэй байсан байна (Шүүгчид 9:46–52-ыг үзнэ үү).

Усан үзмийн талбай, тариалан, бэлчээрт байрлах цамхаг нь ургац, мал сүргийг хулгайчдаас болон амьтдаас хамгаалахад туслах зорилгоор баригдсан багахан хэмжээний байгууламж байв (Шастирын дэд 26:10; Исаиа 5:2; 27:3-ыг үзнэ үү). Ихэнхдээ доод хэсэгтээ багаж хэрэгслээ хадгалдаг өрөөтэй байдаг байжээ.





ХАРЖ ХАНДАХ ҮҮРЭГ

“Зуун зууны туршид бошиглогчид хүмүүсийн өмнө байгаа аюул зана-

лын талаар сэрэмжлүүлэх үүргээ биелүүлсээр ирсэн. Их Эзэний төлөөлөгчид амьдралын асуудлын хариултыг эрэлхийлж байгаа хүмүүст туслахын тулд тэднийг харж хамгаалах, сэрэмжлүүлэх, хүрч ажиллах үүрэг хүлээсэн байдаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард, “Бурхан залуур дээр байна,” 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 7.

БИБЛИЙН ТҮҮХЭН БАРИМТУУД



Хуучин Гэрээнд Их Эзэнийг заримдаа хоргодох цамхаг юм уу цайз хэрэмтэй зүйрлэсэн байдаг (Дуулал 18:2; 61:3; Сургаалт үгс 18:10; 2 Самуел

22:3-ыг үзнэ үү) мөн бошиглогчдыг заримдаа харуулуудтай зүйрлэсэн байдаг (Исаиа 62:6; Иеремиа 6:17; Езекиел 3:17; 33:7; Хосеа 9:8; Мика 7:4-ийг үзнэ үү).

“Би чамайг Израилийн гэрийн харуулаар томиллоо. Чи Миний амнаас үг сонсох бүрд, Миний өмнөөс тэдэнд сануулгыг өг” (Езекиел 3:17; мөн Езекиел 33:1–7-г үзнэ үү).

Цамхаг дээрх харуулууд:

Өндрөөс хардаг. Бурханаар дуудагдсан, эрх мэдэл бүхий үйлчлэгчдийн хувьд бошиглогчид нь дэлхийгээс тусгаарлагдан, Бурхантай ойр байж, аливааг илүү их тэнгэрлэг өнцгөөс харах боломжтой байдаг.

Бусдын харж чадахгүйг хардаг. “Харин үзмэрч өнгөрсөн зүйлийг, мөн түүнчлэн ирэх зүйлийг мэдэж чадна, мөн тэдгээр бүх зүйл илчлэгдэх болно, эсвээс, чухамдаа, нууц зүйлүүд үзүүлэгдэх болно, мөн далдлагдсан зүйлүүд гэрэлд гарч ирэх болно, мөн мэдэгдээгүй зүйлүүд тэднээр мэдэгдэх болно, мөн түүнчлэн өөр нөхцөлд мэдэгдэж болох зүйлүүд тэднээр мэдэгдэх буюу” (Мозая 8:17).

Тэд сонор сэрэмжтэй. Бошиглогчид ирж буй аюулыг бидэнд сэрэмжлүүлэх агуу үүрэг хариуцлагатай бөгөөд энэ үүргээ олон нийтийн санал бодол, нийгмийн хандлага ямар байгаагаас хамаарахгүйгээр үргэлжлүүлэн гүйцэтгэх болно.

Хаа хол байгаа зүйлээс ч сэрэмжлэн хамгаалдаг. “Бошиглогч нүглийг буруушаан зэмлэж, үр дагавруудыг нь угтан хэлдэг. Бошиглогч бол зөв шударга ёсыг номлогч мөн. Зарим тохиолдолд бошиглогчид хүн төрөлхтний ашиг тусын тулд ирээдүйг угтан хэлэхэд сүнслэгээр нөлөөлөгддөг байна” (Судруудын удирдамж, “Бошиглогч,” [lds.org/scriptures/gs](https://www.lds.org/scriptures/gs)).

Аюулгүй байдал ба хамгаалалтыг санал болгодог. Бид бошиглогчдын сэрэмжлүүдэгт анхааралтай байснаараа дуулгаваргүй байсны улмаас хувь хүмүүст эсвэл олон нийтэд тохиолдож болох гай зовлонгоос зайлсхийн, аюулгүй байж чадна. ■



ХОЁР ДАХЬ БОЛОМЖ

Би анх түүнтэй уулзахдаа хийлээ бариад явж байв.

Намайг хийлийн цүнхээ хөл хавьдаа савчуулсаар хоолны өрөө рүү явах хооронд тэрээр хөлөө чирсээр над руу ойртон ирлээ.

Тэрээр дөхөж ирснээ “Хийл” гэв. “Тийм ээ” гэж би хэлэв.

Би өмнө нь хэзээ ч хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ярилцаж байгаагүй болохоор юу хэлэхээ мэдэхгүй байлаа. Тэр намайг дагаж ширээн дээр минь ирээд, миний хажууд суун, хийлийн цүнх рүү заагаад,

“Хийл” гэж дахин хэлэв.

Намайг цүнхээ нээтэл түүний нүд гэрэлтлээ. Тэр хийлийн утсуудыг хамаа намаагүй татаж гарав. Хийлийнхээ утсыг тасрах вий гэж бодохоос зүрх минь хүчтэй цохилж, би бушуухан цүнхээ хаалаа. Тэр явахаасаа өмнө намайг тэвэрсэн.

Үүнээс хойш би түүнийг олон удаа харж билээ.

Виллиам дөхөж ирснээ “Хийл” гэв.



Тэр намайг харах бүрдээ мөрөөр минь тэвэрч, зулай дээр минь үнсдэг байв.

Би ахлах сургуулиа төгстлөө түүний ирж байгааг харах л юм бол зугтаадаг боллоо. Тэр намайг олж тэврээд, үнсэхэд нь би хэдэн хором хүчээр инээмсэглэх аядаад, үг дуугүй бушуухан холдон явдаг болсон юм.

Би түүнийг ахлах сургуулийн найрал хөгжмийн сүүлчийн тоглолтон дээрээ хараад, “Өө, үгүй ээ” гэж бувтнав. Тэр намайг тоглолтын дараа танхимын гадна найзуудтайгаа зогсож байхыг хараад дөхөн ирэв.

Түүнийг инээмсэглээд, тэврэх гэж гараа дэлгэхэд найзууд маань ухран зогслоо.

“Виллиам!”

Би эргэж хараад, бидэн рүү гүйн ирж байгаа нэг эмэгтэйг харав.

“Уучлаарай” гэж тэр эмэгтэй хэлээд, түүнийг гараас нь хөтлөв. “Виллиам хийлд дуртай юм. Тэр өнөө оройн тоглолтод өөрийг нь авчрахыг надаас гуйсан юм. Хонгор минь, явцгаая.”

Тэр мөчийг хүртэл би түүний нэрийг нь ч мэддэггүй байснаа анзаараагүй байжээ. Би Виллиамтай хоёр

жилийн өмнө танилцсан ч түүнээс зугтаах гэж олон цаг зарцуулснаас биш түүнийг таньж мэдэх гэж хичээгээгүй байв. Виллиамыг ээжтэйгээ хамт явахыг хараад, би ичих шиг болж билээ.

Олон жилийн дараа би гэрлэж, Дауны синдромтой хөөрхөн хүү төрүүлсэн бөгөөд түүнийг Спэнсэр

гэж нэрлэсэн юм. Би хүүгээ харахдаа Виллиамын тухай бодож, Спэнсэрт маань түүнтэй адил зүйлс тохиолдох болов уу хэмээн өөрөөсөө асуудаг байлаа. Түүний их үнсдэг, хэт чанга тэвэрдэг зэргээс нь болоод хүмүүс түүнээс зугтаах болов уу? Түүний хязгаарлагдмал байдал найз нөхдөд нь эвгүй байх болов уу?

Спэнсэрийг дөрвөн сартай байхад би түүнийг орон нутгийнхаа эмнэлэгт үзүүлэхээр авч очлоо. Би машинаас хүүгээ авахдаа эмнэлгээс гарч яваа хоёр хүнийг харав. Итгэхийн аргагүй байсан ч энэ хүмүүс Виллиам, түүний ээж хоёр байсныг би таньсан юм.

Намайг дөхөж очоод, “Виллиам!” гэж дуудахад зүрх минь хүчтэй цохилж байлаа.

“Сайн уу?” Тэр нүүр дүүрэн инээмсэглэж, машины зогсоол дундуур аажуухан алхсаар ирлээ. Тэр гараа өгч, миний гарыг урам зоригтой атгав.

“Чи сайн уу?” гэж би түүнээс асуув.

Түүнийг “хийл” гэж хэлэхэд, нүдэнд нь баяр баясгалан гэрэлтэж байлаа.

Хийл. Тэр намайг ч бас санаж байлаа. “Тийм ээ” гэж би нүдэндээ нулимстай инээгээд, “Би хийл тоглодог байсан шүү дээ” гэв.

Би түүнтэй ярилцахдаа, намайг Виллиамтай дахин уулзахыг ямар их хүсэж байсныг мэдэж байсан хайрт Тэнгэр дэх Эцэгийнхээ нигүүлсэлд зүрх сэтгэлдээ талархан залбирч байлаа. Хүүгийнхээ эрүүл мэндийн асуудалд дарагдан, ирээдүйд нь санаа зовнин байгаа залуу эх намайг олж харан, биднийг мэддэг гэдгээ надад сануулсан нэгэн туршлагыг өгсөнд би Бурханд талархалтай байна. ■ Кэйли Болдвин, АНУ, Аризона



Тэр эмэгтэй
төлбөрөө төлөхөөр
олон ширхэг бутархай
зоос лангуун дээр
тавихыг би сонсов.

ТҮҮНД ТУСАЛ

Би шатахуун түгээх газрын дараалалд дугаарлан зогсож байлаа. Миний өмнө хоёр жаахан хүүхэдтэй эх 3 долларын шатахуун, хоёр зайрмаг авахаар зогсож байв.

Анх хараад л би тэднийг тааруухан амьдралтайг мэдсэн юм. Хүүхдүүд нь хөл нүцгэн, ноорхой хувцастай байв.

Тэр эмэгтэй төлбөрөө төлөхөөр олон ширхэг бутархай зоос лангуун дээр тавихыг би сонсов.

Би шатахууныхаа үнийг төлчхөөд гарч явахдаа тэр эхийн машиныг харлаа. Түүний машин шатахуун их хэрэглэдэг байх гэмээр хуучны загвартай байв.

Надад хоёр хүүхэдтэй тэр эхийг өрөвдөх сэтгэл төрсөн ч би мотоциклоо асаагаад яваад өгсөн юм.

Хурдны зам дээр гараад нэг минут ч өнгөрөөгүй байтал “Түүнд тусал” гэсэн дуу хоолой надад сонсогдов. Тэр мэдрэмж хоёр ч удаа төрөв.

Би толгой сэгсрээд, тэр эмэгтэй аль хэдийн явчихсан байлгүй дээ гэж бодлоо. Тэгээд ч би түүнд юу хэлэх билээ дээ?

Гурав дахь удаагаа дуу хоолой тод гэгч сонсогдон, “Түүнд тусал!” гэх шиг болов.

Би шатахуун түгээх газар руу буцаж, тэр эмэгтэйд байвал юу гэж хэлэхээ бодлоо.

Намайг очиход эмэгтэйн машины хаалганууд онгорхой байв. Тэр эмэгтэй жолоочийн суудалд суугаад, хоёр бага насны хүүхэд нь арын суудалд зайрмаг идэж байлаа.

Би юу гэж хэлэх хэрэгтэйгээ Тэнгэрлэг Эцэгээс хурдхан залбирч

асуув. “Өөрийгөө танилцуулаад, түүнд тусламж хэрэгтэй эсэхийг асуу” гэх намуухан дуу сонсогдлоо. Би түүний машинд ойртон очиж, өөрийгөө танилцуулав. Түүнд тусламж хэрэгтэй эсэхийг асуумаар санагдсан гэдгээ би түүнд хэллээ.

Тэр эмэгтэй уйлж гарав. Тэгээд “Би дөнгөж сая Есүст хандан залбирч, надад туслах хэн нэгнийг илгээгээч гэж гуйсан юм” гэлээ.

Тэнгэрлэг Эцэг түүний залбиралд хариулсан байлаа. Би түүний машиныг шатахуунаар дүүргэж өгөөд, тухайн үед ажилд хүн авч байсан ахлагчдын чуулгын нэг ахын утсыг өгсөн юм. Дараа нь энэ залуу эхэд юу тохиолдсоныг би мэдэхгүй ч түүнд туслах сүнслэг өдөөлтийг дагасандаа талархалтай байдаг. ■

Томас Роббинс, АНУ, Калифорни

БИТГИЙ БУУД!

Боб бид хоёр гудамжны хөдөлгөөнийг ажиглан, цагдаагийн машиндаа сууж байлаа. Бид цагдаагийн радио станцаар хэлсэн машиныг олж харангуутаа л хоёр цагийн өмнөөс харуудаж эхэлсэн юм.

Радио станцаар “Зэвсэгт дээрэм болсон байна” гэсэн байлаа. “Хоёр эрэгтэй хоёулаа зэвсэглэсэн. Тэд

саяхан улбар шар өнгийн машинтай явж харагдсан. Эрчүүд зэрлэг балмад бөгөөд буудахаас ч сийхгүй гэж гэрчүүд мэдэгдсэн” гэлээ.


Энэ дүүрэгт ойрын хугацаанд олон зэвсэгт халдлага болсон бөгөөд бид хэчнээн хичээсэн ч дээрэмчдийг барьж чадахгүй байлаа. Эдгээр бодол намайг харанхуй гудамжинд байрлах уг гэрээс хоёр

хүн гарч, улбар шар машинд суухыг хармагц замхран алга болсон юм. Тэд бидний урд явж байв.

“Нэмэлт хүч хэрэгтэй,” “Сэжигтнүүд хойд зүг рүү явж байна” гэж би хэллээ.

Хүч нэмэгдүүлж ирсэн энгийн хувцастай, тэмдэггүй машинтай хоёр мөрдөгч Боб бид хоёрын хөөж байсан машиныг түрүүлж,

Яг эгзэгтэй мөчид би нэгэн дуу хоолой сонсов. Тайван бөгөөд захирангүй, хүчтэйгээр: “Битгий бууд!” гэсэн дуу хоолой байлаа.



урд нь гарав. Бидний гурван машин гүүр рүү орох үед нэмэлт хүчээр ирсэн машин гэнэт улбар шар машины өмнө хөндөлсөн зогсож, бид сэжигтнүүдийг шахан, машиных нь ард машинаа тавив. Тэр даруйд улбар шар машин зогсож, машин доторх хоёр хүн доош тонгойн нуугдлаа.

Би машинаасаа гараад, “Толгой дээрээ гараа өргөөд, машинаас гар!” гэж тушаав. Хэн ч хариулсангүй.

Би буудахад бэлдээд, “Толгой дээрээ гараа өргөөд машинаасаа гар. Яг одоо гараад ир!” хэмээн дахин тушаалаа.

Тэгтэл гэнэт жолооч нь дээшээ болж, над руу эргэв. Би түүний гарт никелиэр өнгөлсөн нэгэн зүйл гялалзахыг харлаа.

Цагдаагийн сургалтад зааснаар бол амь насаа хамгаалахын тулд би буудах ёстой нь ойлгомжтой байлаа. Яг тэр эгзэгтэй мөчид би нэгэн дуу хоолой сонссон юм. Тайван бөгөөд захирангуй мөн хүчтэйгээр: “Битгий бууд!” гэсэн дуу хоолой байлаа.

Би шууд буудах ёстой байсан ч машин дахь хэн нэгнийг түрүүлж гал нээхийг хүлээн зогслоо. Харин жолоочийг гараа толгой дээрээ өргөхөд гарт нь буутай адилхан зүйл харагдсан бөгөөд тэр гараа өвөр дээрээ тавив.

Би “Зогс!” гэж хэлэнгүүтээ машин руу гүйлээ. “Бүү хөдөл!”

Машин доторх нөгөө айхтар гэмт хэрэгтнүүд үнэндээ айж дагжсан хоёр залуухан эмэгтэй байхыг мэдэх хүртэл энэ бүхэн яг л телевизийн шоу мэт байв. Миний буу гэж бодсон зүйл бол суудлын бүсний түгжээ байлаа.

Энэ охид машинаа найз залуус-таа түр өгснийг бид удалгүй мэдэж авсан юм. Тэр залуусыг ямар хүн болохыг тэд мэдээгүй байв.

“Кал, Би чамайг үхчихсэн юм болов уу гэж бодож байлаа!” гэж Боб хэлэв. “Би золтой л гал нээчихсэнгүй. Яагаад гал нээгээгүй гэдгээ мэдэхгүй юм.”

Энгийн машинтай хоёр мөрдөгч ч бас тэгж хэлсэн бөгөөд тэрхүү дуу хоолойг зөвхөн би л сонссон байж таарав. Би зөвхөн тэнгэрийн хүч л тэр хоёр охины амийг аварч, дөрвөн цагдааг аймшигт алдаа хийхээс хамгаалсан гэдгийг мэднэ. Энэ явдал надад Тэнгэрлэг Эцэг маань бидний тусын тулд хөндлөнгөөс оролцож чадах бөгөөд оролцох ч болно гэдгийг баттай ойлгуулсан юм. ■

Нэрийг нууцлав

МОРМОНЫ НОМ УНШИХЫГ ТЭДЭНД ЗАА

Би Швейцарийн Женев номлолд үйлчилж байхдаа салбарын ерөнхийлөгчөөр дуудагдаж, онцгойлон адислагдан, эхнэр маань Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчөөр дуудагдсан юм. Бид хоёр хүнд байдалд орсон энэ салбарыг сэргээхийн төлөө бүх чадлаараа ажиллаж билээ. Хэдийгээр энэ салбар 1960-аад онд байгуулагдсан ч энэ салбарт олон жилийн турш баптисм болоогүй бөгөөд 15 жилийн турш ямар ч номлогчийг номлолын талбарт илгээгүй байв.

Энэ салбарт тулгараад байсан олон хүндрэлтэй асуудлыг шийдэхэд Их Эзэний тусламж бидэнд хэрэгтэй байсан нь тодорхой байлаа. Намайг салбарын асуудлуудын талаар залбирсны дараа Их Эзэний Сүнс надад “Мормоны Ном уншихыг гишүүдэд заа, тэгвэл амжилтад хүрэх болно” хэмээн хэлсэн юм.

Бид тэр даруй Мормоны Номоо уншиж эхлэхийг гишүүдэд уриалахаар төлөвлөгөө гаргав.

Гайхамшигтай үр дүнд ч хүрлээ. Амар амгалан болон Сүнс салбарт маань эргэн ирэв. Шинэ гэр бүлүүд Сүмд нэгдлээ. Нэг залуу эрэгтэй үйлчлэх хүсэлдээ хөтлөгдөн, номлолд явав. Асуудалтай байсан гэр бүлүүд хүчирхэгжиж, гэр бүлүүд илүү дотно болцгоов. Энэ салбар одоо ч гэсэн үргэлжлүүлэн өсөж хөгжсөөр байгаа.

Бид салбарын гишүүдтэйгээ Мормоны Номын гайхамшигт хүчийг өөрсдийн биеэр гэрчилсэн. Мормоны Ном нь үнэхээр манай шашны болон сайн мэдээний мөн Есүс Христийн талаарх бидний гэрчлэлийн тулгуур чулуу юм. Бид үүнийг бүх зүрх сэтгэлээр хайрладаг. Энэ нь төгсөшгүй бөгөөд хувиршгүй мэдлэгийн эх булаг билээ.

Энэ явдал бидэнд Мормоны Ном бол ах эгч нарт маань энэ дэлхийг бүрхэгч сүнслэг харанхуйн сүүдрээс гарахад туслах хамгийн баттай арга зам гэдгийг ойлгуулсан юм. Энэ ном амар амгалан, баяр хөөр, аз жаргал, Аврагч Есүс Христийг дагах хүчтэй хүсэл эрмэлзлийг бий болгодог. ■
Эмилиан Риу, Канадын Кьюбек муж

Сатаны худал хуурмагийг ТАНИХ НЬ

Дэннис С.Гаунт

Намайг хүнсний дэлгүүрт Нэгдсэн Улсын долларын хоёр дэвсгэртийг түрүүвчиндээ хийж байтал нэг дэвсгэрт миний нүдэнд өртөв. Ногоон өнгө нь бусад дэвсгэртээс арай цайвар байсан тул би ойртуулан ажиглалаа. Тэгээд би ерөнхийлөгч Жорж Вашингтоны дүрс тод харагдахгүй байгааг анзаарав. Бүр цаас нь хүртэл биш санагдав. Энэ нь хуурамч дэвсгэрт байлаа! Худалдагч уг дэвсгэртийг жинхэнэ долларын дэвсгэртээр сольж өгөөд, хуурамч дэвсгэртийг дэлгүүрийн менежертээ өгөв.

Түүнээс хойш би хуурамч долларын дэвсгэртийн талаар ихийг бодсон юм. Уг дэвсгэрт хэр олон удаа эргэлтэд орж, хэчнээн олон хүнийг олон жилийн турш хуурсан бол гэдгийг би мэдэхийг хүсэв. Үнэндээ, хэрэв би анзаарч хараагүй бол бас л хууртан мэхлэгдэх байсан. Гэвч би түүнийг жинхэнэтэй нь харьцуулан, ижил төстэй зүйлүүд дээр нь биш, харин ялгаатай зүйлс дээр нь төвлөрснөөр хуурамч байсныг мэдсэн билээ.

Мормоны Номд Сатаны өөрийн эрх ашгийн төлөө худал хэлдэг,

бусдыг хууран мэхэлдэг аргуудыг сурсан сүнслэг худал хуурмагийн жишээ олон бий. Бид тэдний арга, заль мэхийг судалснаараа тэдний алдаа эндэгдлийг жинхэнэ болон хуурамч мөнгөний ялгааг харж чаддаг болсон гярхай нүдээр харах мэт анзаарч эхэлдэг. Бид ялгааг олж харахад нүдээ илүү их дасган сургаснаараа өнөөдрийн хуурамч зүйлсийг ил гаргаж, тэдний худал хуурмагийг сөрөн зогсоход илүү их бэлтгэгдэх болно.

Сатаны худал хуурмагийн талаар мэдээлэл цуглуулах нь

Сатан сүнслэг хуурамч байдалаараа биднийг төөрөлдүүлэхээр эрэлхийлдэг бөгөөд хэрэв бид болгоомжтой байхгүй бол хууран мэхлэгдэнэ. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит (1838–1918) анхааруулахдаа: “Сатан бол чадварлаг даган дуурайгч бөгөөд сайн мэдээний жинхэнэ үнэн дэлхий дээр урьд өмнө байгаагүй тийм ихээр өгөгдөхөд тэр худал сургаалын хуурамч зоосыг тараасаар байгаа билээ. Түүний хуурамч мөнгөнөөс болгоомжил, түүгээр та харамсал, зовлон зүдгүүр, сүнслэг үхлээс өөр юу ч авч чадахгүй”¹ хэмээн хэлсэн.

Биднийг сүнслэг хуурамч зүйлстэй тулгарахад Мормоны Ном юу үнэн, юу худал болохыг мэдэхэд бидэнд тусалж чадна.

Сатаны хуурамч байдалд хууртахгүйн тулд хийх хамгийн сайн хамгаалалт нь сайн мэдээний үнэн нүүдэд аль болох сайн суралцах явдал юм. Бид үнэнийг илүү гүн гүнзгий мэдэх тусам Сатан өөрийн хуурамч зүйлсийг үзүүлэх үед ялгааг нь танин мэдэхэд илүү хялбар болно. Түүнийг тийн үзүүлэхэд, би долларын дэвсгэртээ хэрхэн шалгасан шиг бид ижил төстэй биш харин ялгаатай зүйлсийг олж харах хэрэгтэй. Ялгаатай зүйлсээс л худал хуурмагийг олох болно.



Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) заахдаа: “Мормоны Ном нь Христийн дайснуудыг илчилдэг. . . . Бид алдааг нь харж, өнөө үеийн боловсрол, улс төр, шашин, гүн ухааны худал ойлголтуудыг хэрхэн үгүйсгэхийг мэдэж болохын тулд Бурхан хэмжээлшгүй зөн билгээрээ Мормоны Номыг бүтээсэн юм”² гэжээ.

Өнөөдөр бид Сатантай хийж буй дайнд оролцож байна. Бид ямар нэгэн армитай адил дайснуудаа юу хийх гэж байгааг мэдэх хэрэгтэй.

Тухайлбал, дайсан хэзээ, хаашаа довтолхыг мэдэх нь үнэлж баршгүй мэдээлэл юм. Тиймээс үүнийг “мэдээлэл цуглуулах” гэж нэрлэдэг. Дайснаа мэдэх нь дайснаасаа илүү ухаантай болно гэсэн үг. Мормоны Ном биднийг Сатаны хуурамч аргуудын талаар “мэдээлэл цуглуулахад” тусалж чадна.

Зусар бялдууч яриа хуурамч байдаг

Мормоны Номд буй хуурамч хүмүүсийн тэн хагасаас илүү нь

зорилгодоо хүрэхийн тулд зусар бялдууч яриа, сэтгэл татам зан чанарыг ашигладаг. Тухайлбал, Шерим “эрдэмт нэгэн учир хүмүүний хэл ярианы төгс мэдлэгийг эзэмшсэн байв; иймийн тул, чөтгөрийн хүчний дагуу тэр ихээхэн зусардалтыг, мөн ярих ихээхэн хүчийг хэрэглэж чадсан ажгуу” (Иаков 7:4). Ноа хааны ёс бус санваартнууд “хоосон мөн зусар үгсээр” (Мозая 11:7) ярьцгаасан тул хүмүүс хиймлийг шүтэгчид болж, бусад ёс бусыг хийх болжээ. Корихор “олны зүрх

сэтгэлийг дагуулан удирдаж” (Алма 30:18), өөрийн өдрүүдэд ийм амжилтад хүрсэн. Амаликая, Гадиянтон хоёр ёс бус дагагчдын армийг бий болгохдоо өөрсдийн зусар үг, башир аргуудыг ашигласан (Алма 46:10; Хиламан 2:4-ийг үзнэ үү).

Энэ бол тохиолдлын зүйл биш юм. Зусар бялдууч зан бол өнгөц, хуурмаг, хоосон хөндий, хэтрүүлэгтэй байдаг. Нифай тэдгээр нь “ийм маягаар, хуурамч мөн хоосон мөн мунхаг сургаалуудыг заах бөлгөө, мөн зүрх сэтгэлдээ ихэмсэглэдэг, мөн бодол санаагаа Их Эзэнээс нуухаар гүнзгийг эрэлхийлэх тэд олон байх болно; мөн тэдний ажлууд харанхуйд байх болно” (2 Нифай 28:9) хэмээн анхааруулсан.

Зусар бялдууч зан нь хуурахад байнга хэрэглэгддэг бөгөөд үүний цаана далд зорилго юм уу нууц хөтөлбөр агуулагдаж байдаг. Зусар бялдууч зан нь мөн чанараас илүү хэв маяг хөөдөг ба эгэл хүний биеэ тоосон, бардам занд нийцсэн байдаг. Харин Их Эзэний бошиглогчид бидний сонсох ёстой энгийн хэрнээ чухал үнэнүүдийг бидэнд хэлдэг.

Зусар бялдууч зан бол Сатаны ярьдаг хэл мөн. Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Жэймс Э.Фауст (1920–2007): “[Сатаны] дуу хоолой ихэнхдээ тун ухаалаг сонсогддог бөгөөд түүний захиасыг зөвтгөхөд амархан байдаг. Энэ нь сэтгэл татам, сонирхол төрүүлэхүйц, энхрий зөөлөн дуу авиа байдаг. Хатуу ширүүн эсвэл зөрчилдсөн байдаггүй юм. Хэрэв Сатаны дуу хоолой хатуу чанга юм уу хахир байсан бол хэн ч түүнийг



“[Сатаны дуу хоолой] сэтгэл татам, сонирхолтой дуу хоолой байдаг. . . . Хэрэв Сатаны дуу хоолой хатуу чанга юм уу хахир байсан бол хэн ч түүнийг сонсохгүй байх байсан.”

сонсохгүй байх байсан”³ гэж тайлбарласан байдаг.

Дэлхий бидний биеэ тоосон байдалд юм уу бардамналд тохирсон эсвэл зүгээр л үнэн гэхэд итгэхийн аргагүй сайхан сонсогдох тийм нэгэн санаа, гүн ухаан, үзэл бодлыг танилцуулбал нэн даруй анхааруулга болгон авах хэрэгтэй. Тэдгээр санааг худал хуурмаг гэж үз. Тэдгээрийг Их Эзэний бошиглогчдын заадаг үнэнүүдтэй харьцуул. Адил төстэй биш, ялгаатай өөр зүйлсийг хайвал худал хуурмаг санаа нь илэрхий болно.

Нихор бол алдарт хууран мэхлэгч

Нихор Сатаны зусар бялдууч аргыг чөлөөтэй хэрэглэсэн. Түүнийг сүнслэг хууран мэхлэгчийн

судалгааны нөхцөл болгон авч үзэцгээе. Нихор гэтэлгэгчийн санаанд үндэслэсэн сургаалыг зааж байгаа мэт заадаг байсан ба нифайчуудын дунд алдартай, хүмүүсийг бишрүүлсэн санваартан байв. Нихор “эцсийн өдөр бүх хүн төрөлхтөн аврагдах болно” мөн “мөнх амьдралтай байна” (Алма 1:4) хэмээн зааж, олон дагалдагчтай болсон.

Нихорын захиас яагаад тийм сайхан санагдаж байгааг бид олж харж чадаж байна уу? Тэр нийцтэй, амар тайван Бурханы талаар зааж байсан ба Бурхан хүн бүрд хайртай учраас юу хийснээс нь үл хамааран хүн бүрийг аварна хэмээн зааж байсан. Тиймээс хийх дуртай зүйлсээ хий, яагаад гэвэл бүх зүйл сайн байна. Энэ бол Нихорын үед төдийгүй өнөө үеийн хүмүүсийн дагадаг,

сэтгэл татам гүн ухаан юм (Алма 1:5-ыг үзнэ үү). Тэнгэрт хүргэх үнэгүй тасалбар бол хүмүүсийн авахыг хүссэн зүйл билээ.

Нихорын захиасын гол асуудал нь юу байсан бэ? Түүний үзэл санааны гол асуудлыг авч үзэцгээе:

- Бурхан бүх хүнийг бүтээсэн—үнэн.
- Бурхан бүх хүнд хайртай—үнэн.
- Бид Бурханаас айх хэрэггүй—үнэн.
- Бид авралын үзэл санаанд баярлах ёстой—үнэн.

Одоогоор Нихорын заасан зүйл болон сайн мэдээний үнэнүүдийн хооронд ижил төстэй олон зүйл байна. Гэвч хуурамч мөнгөтэй адил, бид адилхан зүйлсийг биш, харин ялгаатай зүйлсийг нь хайж олох хэрэгтэй. Тиймээс Нихорын сүүлийн хэлсэн зүйлийг дахин харцгаая:

- Бурхан хүн бүрд мөнх амьдрал өгнө—худал!

Энэ нь Нихор бол сүнслэг хууран мэхлэгч болохыг бидэнд хэлэх чухал ялгаа юм. Бие махбодын үхлийн аврал нь хүн бүрд өгөгдөнө, харин сүнслэг үхлийн аврал нь бидний чин сэтгэлийн наманчлалаас шалтгаалдаг. Хэрэв бид наманчилбал мөнх амьдралыг хүлээн авах болно (Иаков 6:11-ийг үзнэ үү). Гэхдээ үнэ төлбөргүй зүйл гэж үгүй.

Гидеон, Алма хоёр хууран мэхлэгчийг таньсан нь

Нихорын хилэнц түүнийг нэгэн өдөр Бурханы Сүмийн зөв шударга

багш болох Гидеонтой учруулснаар олонд ил болсон юм. Гидеон олон жилийн өмнө Ноа хааны эсрэг боссон тул сүнслэг худал хуурмагийг мэддэг байв (Мозая 19:4–8-ыг үзнэ үү). Нихор “сүмийн хүмүүсийг тэрбээр зайцуулан удирдаж болохын тулд [Гидеонтой] хурцаар маргалдаж эхлэв; гэвч тэр [Гидеон] Бурханы үгсээр түүнийг зэмлэн түүнийг эсэргүүцэв” (Алма 1:7). Гидеон Нихорыг хууран мэхлэгч болохыг таньсан. Нэгэнт ил болсон тул Нихор Сатаны аргуудын нэг болох аллагыг сонгожээ. Гэвч Гидеоны үхэл талаар өнгөрөөгүй юм. Хүмүүс хууран мэхлэгч Нихорыг шүүлгэхээр Алмагийн өмнө авчирчээ.

Алма Нихорыг санваараар мэргэшиж, аллагад буруутай гэдгийг төдийгүй мөн санваараар мэргэших явдал энэ хүмүүсийн дунд үлдэх аваас “энэ нь тэдний бүрэн устгалын шалтгаан болохсон” (Алма 1:12) гэдгийг мэдэж байжээ. Тиймээс Нихор үхэх ял авсан бөгөөд тэрээр “ичгүүрт үхлийг үзэв” (Алма 1:15).

Гидеон, Алма хоёр бидэнд үлгэр жишээ үзүүлсэн юм. Бид Сүнстэй хамт байхдаа “үнэхээр тэдгээр зүйлүүдийг байгаагаар нь” харж, сонсох болно (Иаков 4:13). Бид Сатаны худал хуурмаг санаа, төлөвлөгөөг “өдрийн гэрэл, шөнийн харанхуйн ялгаа нь илэрхий байдаг лугаа адил тодорхой” (Моронай 7:15) таньж мэдэх болно.

“Хуурамч” дайсан маань ухаантай, гэхдээ бид Гидеон, Алма нар шиг илүү ухаантай байж чадна.



САТАН ХУДАЛ ХУУРМАГИЙГ ТАРААДАГ

“Бидний дайсан Сатан биднийг ялгадаасай гэж хүсдэг. Тэрээр бидний итгэлийг устгахын тулд худал хуурмагийг тараадаг. Тэрээр аливаа зүйлд итгэдэггүй, эргэлздэг, зайгаа барьдаг хүмүүсийг боловсорсон, ухаалаг хэмээн харагдуулахыг хичээж, харин Бурханд болон Түүний гайхамшгуудад итгэдэг хүмүүсийг гэнэн, харалган эсвэл тархиа угаалгасан хүмүүс гэж харагдуулан, залилахыг хичээдэг. Сүнслэг бэлгүүдэд болон үнэн бошиглогчдын заавруудад эргэлзэх нь сайн гэж Сатан зааварладаг.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, “Бүү ай, зөвхөн итгэ,” 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 61.

Би долларын дэвсгэртүүдийн ялгааг аажим анзаарч мэдсэн шиг бид үнэн, худал хоёрын хоорондын ялгааг олж харахад нүдээ төдийгүй оюун ухаанаа аажмаар бэлтгэж болно. Ингэснээрээ бид хуурамч зүйлсийг танин мэдэж, тэдний худал хуурмагийг сөрөн зогсоно. ■
Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Жозеф Ф.Смит, *Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл. (1939), 376.
2. *Teachings of Presidents of the Church: Ezra Taft Benson* [2014], 132).
3. Жэймс Э.Фауст, “Биднийг аврах хүчнүүд,” *Лиахона*, 2007 оны нэгдүгээр сар, 3.

Мадагаскарын адислалыг хэмжих нь

Минди Энн Сэлү

Сүмийн сэтгүүлүүд

Эхнэр нь анхны жирэмслэлтийнхээ үед харамсалтайгаар үр зулбасны дараа тэдний залбирлууд жилийн дараа хоёр дахь жирэмслэлтээр хариулагдсан гэж Солофо Равеложаона боддог. Солофо ба түүний эхнэр Хари Мартинь хоёрын хувьд тэдний охин төрсөн нь тэдний хүлээн авсан хамгийн агуу адислалуудын нэг билээ. Солофо тайлбарлахдаа “Бид Бурханаас гуйж, Тэр түүнийг бидэнд өгсөн тул бид охиндоо малагаси хэлээр ‘Бурханы хариулт’ гэсэн утгатай нэр өгсөн” гэж хэлэв.

Мадагаскарын залуу насанд хүрэгч Солофо нь Бурхан залбиралд хариулдаг бөгөөд итгэлт нэгнийг аяндаа адисалдаг гэдгийг мэддэг. “Амьдрал хэцүү л дээ,” “хүмүүс хүссэнээ авч чадахгүй болохоороо л ‘Яагаад надад ийм зүйл тохиолдож байна вэ?’ хэмээн асууж эхэлдэг. Тэд Сүмээ орхиж эсвэл Бурханд итгэх итгэлдээ эргэлзэж болох юм. Гэвч бид сайн мэдээний дагуу амьдарч, судраа уншвал амьдрал илүү амар байдаг. Та үнэхээр сайн мэдээний дагуу амьдарвал адислалуудыг харах болно” гэж Солофо яриу.


Туйлдаа хүрсэн ядуурал, засгийн газрын тогтворгүй байдал, сул хөгжсөн дэд бүтэц, байгалийн гамшиг гээд олон хүндрэл бэрхшээлтэй оронд амьдарч буй Солофо амьдрал хэцүү гэж яагаад хэлсэн нь ойлгомжтой юм. Гэвч түүний хувьд сайн мэдээний дагуу амьдарснаар ирэх адислалууд нь ямар ч зовлонгоос илүү ажээ. “Сайн мэдээний дагуу амьдарснаараа хүлээж авсан адислалууд маань тоолохын аргагүй” гэж тэр хэлэв.

Мадагаскарт Сүм харьцангуй шинэ (1990 онд анхны салбар байгуулагдсан) тул Сүмийн гишүүн байхад хамгийн хэцүү зүйл нь Сүмийн тухай цуурхал, ташаа ойлголтууд юм гэж Солофо ярилаа. Тэрээр цааш нь үргэлжлүүлэн, амьдралын модны тухай Лихайн үзэгдэлд гардгийн адилаар “хүмүүс найз нөхдөөсөө санаа зовох, гэр бүлийнхэн нь өөрсдөөс нь татгалзахаас айснаасаа болж сайн мэдээг бүрэн дүүрэн хүлээн авахгүй байх явдал бий” гэв. Солофог бусдаас юугаараа өөр болохыг асуухад тэр “Би хэзээ ч ичдэггүй. Би сайн мэдээний дагуу амьдарч, хамт ажиллагсдын маань зарим нь сонирхохгүй байсан ч үргэлж тэдэнтэй сайн мэдээг хуваалцахыг хүсдэг” гэж хэлсэн юм. Тэрээр

Солофо улс орныхоо улс төрийн эргэлт, эдийн засгийн хүнд байдал зэргээс үл хамааран сайн мэдээний дагуу амьдарснаар ирэх адислалуудад найддаг.

байнга өөрийн энгийн гэрчлэлийг хуваалцагч тул түүнийг хамтран ажиллагсад нь “пастор” гэж хочилдог ажээ.

Эдийн засаг, улс төрийн үймээн самуун дунд Солофо, Хари Мартинь нар ариун сүмийн гэрээнүүдийн адислалдаа (Солофо Уганда улсад, Хари Мартинь Мадагаскарт номлолд үйлчилсэн бөгөөд тэд номлолоосоо буугаад нэг жилийн дараа Өмнөд Африкийн Иоханнесбургийн ариун сүмд гэрлэжээ) болон Их Эзэнд итгэх итгэлдээ найддаг юм. “Надад сайн мэдээ бий, би зүгээр л амьдралаа Бурханы мутарт тавьсан” гэж Солофо хэлэв. Тэр “Бурханы хариултууд”-д аль хэдийн итгэдэг болсон учраас өөрийн баттай гэрчлэлд найддаг. ■



СОЛОФОГИЙН ТУХАЙ ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭХ НЬ

Та нар юу идэх дуртай вэ?

Бид маш их будаа иддэг. Миний дуртай хоолны нэг бол *рав-тото*. Энэ хоолонд кассавагийн навчийг тусгай хэрэгслээр жижиг болгон нунтаглаад, будаа болон гахайн махтай хамт иддэг юм.

Та чөлөөт цагаараа юу хийх дуртай вэ?

Би даралтат хөгжим тоглож, дуу дуулж, ном унших дуртай. Салбарын ерөнхийлөгч миний дуулах дуртайг бас даралтат хөгжим тоглодгийг мэдсэн учраас нэг удаа намайг салбартаа ирэхэд “Ашгүй, бид найрал дуу удирдах хүнтэй боллоо” гэж хэлсэн. Би ч тэр дуудлагыг хүлээн авсан. Манай салбарт өмнө нь найрал дуучид байгаагүй бөгөөд би тэдэнд зааж эхэлсэн. Тэд одоо найрал дуундаа дуртай.

МАДАГАСКАРЫН ТУХАЙ БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Хэл: франц, малагаси

Нийслэл: Антананариво

ТООГООР

22 005 222 хүнтэй (2012 оны 7-р сарын байдлаар)

Мадагаскар дахь амьтдын 80 хувь нь дэлхийн өөр хаана ч байдаггүй

Дэлхийн дөрөв дэх том арал
Дэлхийн ванилийн 60 хувийг
Мадагаскараас экспортод гаргадаг

МАДАГАСКАР ДАХЬ СҮМ

9190 хожмын үеийн гэгээнтэн
37 тойрог ба салбар

2 гадас

1 номлол







**Ахлагч Дэйл
Г.Рэнланд**
Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын ахлагч

СҮНСЛЭГ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: ЖИВДЭГГҮЙ УСАН ОНГОЦ БАРИХ НЬ

*Бид мөнх бус амьдралдаа амжилттай аялж, тэнгэрлэг
гэртээ аюулгүй харихын тулд сүнслэг байдлын хувьд
хангалттай тогтвортой байх хэрэгтэй.*

17-р зууны эхэн үед Шведийн хаан II Густав Адольф *Ваза* хэмээх нэртэй байлдааны хөлөг онгоц барихыг тушаажээ. Уг онгоцыг царс модоор барих зэргээр асар их хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулжээ. Густав Адольф *Ваза* усан онгоцыг яг өөрийн хүссэнээр бариулахын тулд барилга баригда-хыг ойрхноос ажиглаж байв.

Барилгын ажил эхэлсний дараа Густав Адольф *Ваза*-г арай урт болгохыг тушаасан юм. Онгоцны өргөнийг хэмжээнийх нь дагуу үнэт царс модоор аль хэдийн барьчихсан байсан тул хаан барилгачдад онгоцны өргөнийг өөрчлөлгүй, уртыг нь сунгахыг зааварлажээ. Тийнхүү өөрчлөх нь *Ваза*-гийн далайд хөвөх чадварт нөлөөлнө гэдгийг усан онгоцны дархад мэдэж байсан ч сонсохыг хүсэхгүй зүйлийг нь хаандаа хэлэхээсээ тээнэгэлзсэн байна. Тэд тушаалыг гүйцэтгэжээ. Мөн Густав Адольф уг онгоцон дээр бууны энгийн нэг тавцан биш, их буунууд бүхий гурван тавцан байрлуулан, хамгийн дээд тавцанд хамгийн хүнд их буунуудыг байрлуулахыг шаардсан байна. Дархад дахиад л үнэнийг хэлэхийн оронд тушаалыг ёсоор болгожээ.

1628 оны 8-р сарын 10-нд *Ваза* хамгийн анхны аялалдаа гарав. *Ваза* эргээс хөдлөхөд хүчтэй салхи далбааг ороож, онгоц хазайж эхэлжээ. Тун удалгүй “усан онгоц хазайн унаж, бууны нүхнүүдээр нь ус орсны улмаас туг далбаа гээд бүхий л зүйлсийн хамт аажмаар далайн гүнд живсэн байна”¹ *Ваза*-гийн хамгийн эхний аялал ердөө л 4200 тохой (1280 м) үргэлжилжээ.

Ийнхүү Густав Адольф хэмжээ хязгааргүй нэр хүнд олж авах гэж хөөцөлдсөнөөс болоод тухайн үедээ хамгийн агуу байлдааны хөлөг онгоц болох байсан энэхүү сүр жавхлантай дарвуулт онгоцны загвар сүйрсэн юм. Усан онгоцны дархад хаанаа дургүйцэх вий гэж айсандаа түүнд үнэнийг хэлээгүйгээс болж хаанд

тэдний мэдлэг, төсөөлөн бодох гүн ухаан дутагдсан аж. Хөлөг онгоцыг барих болсон гол зорилго болох Швед орныг хамгаалж, улсынхаа бүрэн эрхийг гадаад ертөнцөд дэмжүүлэх ажил энэ хүмүүсийн энэхүү үйлдлээр үгүй болсон юм. Физикийн хуульд үл захирагдахыг оролдогч усан онгоц бол зүгээр л хөвдөггүй завь гэсэн үг.

Бид мөнх бус амьдралдаа амжилттай аялахын тулд салхи, урсгалыг сөрөн, шаардлагатай эргэлтүүдийг хийж мөн тэнгэрлэг гэртээ аюулгүй харихын тулд сүнслэг байдлын хувьд хангалттай тогтвортой байх хэрэгтэй. Бидэнд өөрсдийнхөө сүнслэг тогтвортой байдлыг нэмэгдүүлэхийн тулд хийж чадах зүйлс бий. Тэдгээрээс би дөрвийг дурдъя.

Бурханы зарлигуудыг дуулгавартай дагах

Нэг дэх зүйл нь Бурханы зарлигуудыг дуулгавартай дагах явдал юм. *Ваза* физикийн хуульд захирагдах ёстой байсантай адил бид бүгд сүнслэг хуульд захирагддаг. Хэн ч үүнээс ангид байдаггүй. Бид Бурханы зарлигууд болох тэдгээр сүнслэг хуулийг дагах ёстой.

Онгоцоо физикийн хуулийн дагуу барих нь Густав Адольфын хувьд хязгаарлагдмал байсан байж болох ч, эдгээр хуулийг дагасан бол *Ваза* зорилгоо эхлүүлж ч чадалгүйгээр живэхгүй байх байсан юм. Харин ч уг усан онгоц хийх ёстой зүйлээ хийх эрх чөлөөтэй бас уян хатан байх байлаа.

Үүний нэгэн адил Бурханы хуулиудыг дуулгавартай дагах нь бидний эрх чөлөө, уян хатан байдал ба зорьсондоо хүрэх чадварыг хадгалан хамгаалдаг юм. Зарлиг тушаалууд биднийг хорьж хязгаарлахын тулд өгөгдөөгүй. Яг үнэндээ дуулгавартай байдал нь өсөн нэмэгдсэн сүнслэг тогтвортой байдал ба урт хугацааны аз жаргалд хүргэдэг.

Дуулгавартай байдал нь бидний сонголт юм. Есүс “Болгоогтун, би та нарт зарлигууд өгсөн билээ; тиймийн тул зарлигуудыг минь дага” хэмээн зааж чиглүүлсэн байдаг (3 Нифай 15:10). Тэгээд л боллоо. Үүнийг сонго. Яг

дуулгавартай байх эсэхээ одоо л шийд. Үүнээс өөр юу ч сүнслэг тогтвортой байдлыг илүү их нэмэгдүүлэхгүй. Үүнээс өөр ямар ч зүйл бидэнд амьдралынхаа зорилгыг биелүүлэх илүү их эрх чөлөөг өгөхгүй.

Зөвлөгөөг анхааран үзэж, насан туршдаа суралцагч болох нь

Хоёр дахь зүйл нь, бид найдвартай эх сурвалжаас ирэх зөвлөгөөнд анхаарал хандуулж, насан туршдаа суралцагч болохоо амлах явдал юм.

Мэдлэгтэй болохын нэг аюул нь бид их зүйлийг мэддэг тул өөр сурах зүйл байхгүй хэмээн бодсоноос үүсэх бардам зан юм. Бид үүнийг өөрсдийн чадварлаг байдалд бүрэн итгэлтэй байдаг хүмүүсээс харж байсан билээ. Бүхнийг мэдэгчид заахад үнэхээр хэцүү байдаг.

Үүнийг анхаардаг мөн насан туршдаа суралцагч байх хүсэлтэй Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх ерөнхийлөгч Хэнри Б.Айринг “Би ихийг сурах хэрэгтэй хүүхэд хэвээр байгаа. Ихэнх нь надад ямар нэгэн зүйл заадаг”² хэмээн хэлсэн. Ерөнхийлөгч Айринг намайг ерөнхий эрх мэдэлтнээр дуудахдаа надад нэгэн чухал хичээл заасан юм. Тэрээр хэн нэгэн нь түүний урьд сонссон түүхийг ярих юм уу түүний сайн мэддэг судрыг хэрэглэх юм бол “Яагаад Их Эзэн надад үүнийг онцолж байгаа юм бол?” мөн “Энэ түүх эсвэл судраас би юу сурах ёстой вэ?” хэмээн өөрөөсөө асуудаг гэж хэлсэн юм. Хэрэв бид сүнслэг тогтвортой байдлаа нэмэгдүүлэхийг хүсвэл, сурах хүсэлтэй байж мөн өөрсдийн нас, туршлагаас үл хамааран заавар удирдамж хүлээн авахдаа хангалттай даруухан байх хэрэгтэй.

Энэ нь үнэхээр бидний сонголт юм. Бид Сүмийн удирдагчдын, ялангуяа бидний бошиглогч, үзмэрч, илчлэгчид хэмээн дэмждэг тэр хүмүүсийн зөвлөгөөг мөн эцэг эх, итгэлтэй найзуудынхаа зөвлөгөөг сонсож, анхаарал хандуулж болно эсвэл анхаарахгүй байж ч болно. Бид насан туршдаа суралцагч байхыг эрэлхийлж эсвэл эрэлхийлэхгүй ч байж болно. Бид сүнслэг тогтвортой байдлаа нэмэгдүүлэх юм уу нэмэгдүүлэхгүй ч байж болно. Хэрэв





бид сүнслэг тогтвортой байдлаа нэмэгдүүлэхгүй бол *Ваза* шиг хөвдөггүй завь болох болно.

✦ **Бусдад үйлчлэх нь**

Гурав дахь зүйл нь гадагш чиглэсэн байх ба бусдыг халамжлан, бусдад үйлчилснээр сүнслэг тогтвортой байдлыг нэмэгдүүлдэг.

Бид Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдэд туслахыг эрэлхийлж, бусдад анхаарал хандуулах юм бол мөнх амьдрал бидний зорилго хэвээр үлддэг. Би зөвхөн өөрийнхөө төлөө залбирахаасаа илүүтэй, бусдад хэрхэн тусалж чадахаа мэдэхийг хүсэн залбирвал илчлэлт авахад илүү хялбар байдгийг анзаарсан.

Бид хэзээ нэгэн цагт бусдад туслах илүү боломжтой байх болно гэдэгт итгэдэг байж болох юм. Тэгвэл үнэндээ, туслах цаг нь одоо юм. Бид илүү их цаг завтай, илүү их мөнгөтэй эсвэл илүү их ямар нэгэн зүйлтэй болсон үедээ бусдад үйлчлэхэд илүү амар байх болно гэж бодож байвал бид эндүүрч байна. Нөхцөл байдлаас үл хамааран, бусдад туслах уу, үгүй юу? гэсэн сонголт бидэнд байдаг. Бид тусламж хэрэгтэй хүмүүст туслахыг

сонгохгүй бол мөнх бус амьдралынхаа чухал шалгалтад унана. Хэрэв бид туслах юм бол сүнслэг тогтвортой байдлаа нэмэгдүүлж чадна.

✦ **Есүс Христийг сууриа болгох**

Сүүлийн, хамгийн чухал дөрөв дэх зүйл бол сүнслэг тогтвортой байдал маань бидний Есүс Христийг сууриа болгосон тэр хэмжээгээр өсөн нэмэгддэг.

Бид Христгүйгээр давалгаан дунд шидэгдсэн усан онгоц мэт явах болно. Бидэнд дарвуул байхгүй тул хүч ч байхгүй. Зангуу байхгүй тул ялангуяа шуургатай үед бид тогтвортой байж чадахгүй. Залуурдан удирдах жолоогүй тул бидэнд зорилго, чиглэл байхгүй. Бид Есүс Христийг сууриа болгох ёстой.

Бид амьдралын салхи ба урсгалыг сөрж, даван туулж, тэдгээрт бэлтгэлтэй байхын тулд Бурханы зарлигуудыг даган, насан туршдаа суралцагч байхаар даруу, хичээнгүй байж, бусдад үйлчлэн, Есүс Христийг амьдралын сууриа болгох ёстой. Хэрэв бид үүнийг хийвэл, сүнслэг тогтвортой байдлаа өсгөн нэмэгдүүлж чадна. *Ваза*-тай адилгүй нь бид хувь заяаныхаа эзэн нь болж, боомт дээр аюулгүй эргэн очих боломжтой юм. ■

2014 оны 9-р сарын 16-нд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цуглалалт дээр хэлсэн үгнээс. Англи хэл дээрх бүрэн эхийг <http://speeches.byu.edu> хаягаар орж үзнэ үү.

ЭШЛЭЛҮҮД

1. Шведийн хаант улсын зөвлөлөөс II Густав Адольф хаанд ирүүлсэн захиа; эшлэлийг орчуулсан Ричард О.Мэйсон, "Ваза хөмөрсөн нь," virtualschool.edu/mon/CaseStudies/Vasa/vasa.html. *Ваза*-гийн тухай олон түүх байдаг ба тухайлбал vasamuseet.se/en хаягаар эсвэл өөр хаягуудаар орж түүхийг үзнэ үү.
2. Хэнри Б.Айрингийн тухай Роберт И.Ийтон, Хэнри Ж.Айринг нар, *Би чамийг урагш удирдах болно: Хэнри Б.Айрингийн амьдрал* (2013), 409.

10 минутад ДУУЛАЛ ТОГЛОЖ СУР!

Бэлтгэсэн Даниэл Картэр

Сүмийн хөгжим, соёл урлагийн хэлтэс

Хэрэв та өмнө нь хэзээ ч төгөлдөр хуур тоглож байгаагүй боловч сурахыг үргэлж хүсдэг бол танд боломж байна. Танд хэрэгтэй зүйл бол даралтат хөгжим. Танай гэрт даралтат хөгжим байхгүй бол энэхүү өгүүллийг төгөлдөр хуур эсвэл даралтат хөгжимтэй газар авч очоод, сурч эхэлж болно.

Энэ хичээл тун энгийн бөгөөд хялбархан тул та хичээлийн төгсгөлд дуулал тоглож чаддаг болсон байна.

Үнэндээ та энэ хичээл дээр байгаа дууллын аяыг 10 орчим минутад тоглож сурах боломжтой!

Бэлэн үү? Эхэлцгээе!

Төгөлдөр хуур тоглоход бэлтгэх нь

1. Та төгөлдөр хуурынхаа урд суугаад, хуруунуудаа товчлуур дээр байрлуулан, тохойгоо бага зэрэг нугалсан байхаар тааруулж суудлаа хойшлуу.
2. Суудлынхаа голд, товчлуурынхаа төвийн чанх урд суу.
3. Суудлынхаа урд ирмэгт нуруугаа цэхлэн, жингээ урагш төвлөрүүлэн суу.
4. Хөлөө газар тавь.
5. Тухтай, цэх суу.
6. Хөгжмийн нот ба товчлуураа сайн харахуйц гэрэл сайтай байхад анхаар.





7. Бос. Хоёр гараа сул унжуулж, гараа амраа. Таны гар бөмбөг барьж буй мэт төрөлхийн хагас нугаларсан байдалтай байгааг анзаар. Буцаж суухдаа гараа тиймэрхүү хагас нугаларсан байдлаар товчлуур дээр тавь.
8. Гараа товчлуур дээр байрлуулан, хуруунуудаа цагаан товчлуурын том талбарын гол хавьд байхаар

байрлуул. Алгаа товчлуурын дээхэн тал руу харуул. Гэхдээ яг товчлуурууд дээр болон товчлууруудын доод талын модон дээр алгаа тавьж болохгүй.

9. Хурууны өндөгний үзүүр хэсгээр товчлуурт хүрнэ. Хуруунуудаа нугаларсан байдалтай байлгах бөгөөд хурууны доод үеэ л хөдөлгөнө. Товчлуураа дарахдаа хурууны үеүдээ нугаларсан байдалтай байлгана.




Хуруунуудаа дугаарлан тоглох нь

Товчлуур бүр дээр зөв хуруугаа байрлуулахын тулд энд харуулсны дагуу хуруунуудаа дугаарла. Энэ хуудсан дээрх

нотны харалдаа хурууны дугааруудыг бичсэн байгаа.

Хуруу бүр нэг товчлуурын дээр байхаар аль нэгэн таван бүлэг товчлуурын дээр гараа байрлуул. Энд үзүүлсний дагуу

товчлууруудыг зөв хуруугаараа даран, хурууны дугааруудаа давт. Иш нь дээшээ нотнуудыг баруун гараараа тоглоно. Иш нь доошоо нотнуудыг зүүн гараараа тоглоно.



“Тэр хотын хэрэмнээс гадна” дууллыг тоглох нь

Хуруунуудаа доор харуулсны дагуу товчлуур дээр байрлуул.

Хоёр ба гурваараа байх хар товчлууруудыг ашиглан зөв байрлуул.

Харуулсны дагуу дугаарласан хуруунуудаараа энэ дууллыг тогло. Иш нь дээшээ нотнуудыг баруун гараараа, иш нь доошоо нотнуудыг зүүн гараараа тоглоно. Сайн тоглодог болтлоо дууллыг давт. Дээрх есөн алхамд дурдсан, хуруугаа сайн техниктэй болгох зарчмуудыг дага.

Ингээд та төгөлдөр хуур болон энгийн дууллын ая тоглож


сурлаа. Та бусад дууллыг тоглохын тулд өргөлт, хэмнэл, нотны талаар зарим үндсэн зарчмыг сурах шаардлагатай.

Хамгийн сайхан зүйл нь юу вэ гэвэл, таны сая сурсан хичээл бол Сүмийн даралтат хөгжмийн сургалт номын нэгдүгээр хичээл юм. Уг номыг Сүмийн хангамжийн төвөөс зургаан хэл дээр авах боломжтой.¹ Дагаж хийхэд хялбар хичээлийн заавар нь таныг өөрөө бие даан эсвэл хэсэг бүлгээрээ сурахад тусална. Та гэр бүлийн үдшийн үйл ажиллагаан дээрээ гэр бүлээрээ хамтдаа төгөлдөр хуур сурч болох юм. Энэхүү

сургалтыг зургаахан долоо хоногт дуусгаж болно.

Хувиараа хөгжим тоглож сурах нь суралцагчдын анхаарал төвлөрөлт, хичээл сургуульдаа гаргах амжилт, сэтгэн бодох чадвар зэргийг сайжруулахад тусалдаг болохыг олон судалгаа харуулдаг.²

Бид хөгжмийн чадвараа хөгжүүлэхэд суралцсанаар Их Эзэний бидэнд өгсөн авьяасыг хөгжүүлж, мэдлэгээ дээшлүүлэн, Түүний хаант улсыг байгуулахад авьяас, мэдлэг чадвараа ашиглах олон өөр арга замыг мэдэж авдаг. ■



ЭШЛЭЛҮҮД

1. Даралтат хөгжмийн сургалтын хэрэгслийг захиалахын тулд store.lds.org хаягаар орно уу.
2. Лаура Льюс Браун, “Хөгжмийн боловсролын ач холбогдол,” ([“The Benefits of Music Education,”](http://The Benefits of Music Education)) pbs.org; Жэссика Вэлазко, “Суралцагчдыг амжилт гаргахад урлаг хэрхэн тусалдаг вэ,” ([“How the Arts Can Help Students Excel,”](http://How the Arts Can Help Students Excel)) Шинжлэх ухааны суралцахуйн блог, 2012 оны 12-р сарын 11, scilearn.com/blog/how-arts-help-students-excel; “Хөгжим хүүхдүүдэд тоо сурахад нь тусалдаг” ([“Music Helps Children Learn Maths,”](http://Music Helps Children Learn Maths)) *The Telegraph*, 2012 оны 3-р сарын 22, telegraph.co.uk.

Болихоор шийдсэн нь

Олон жил давтсан ч төгөлдөр хуур тоглох чадвар маань сайжирсангүй.

Эцэг эх маань намайг нэг нөхцөлтэйгөөр тоглохоо больж болно гэсэн юм. Би 50 дуулал тоглож сурах ёстой байв.

Грэтчин Блэкбурн

Нэгэн удаа би төгөлдөр хуурынхаа сэтгэлээр унагам хичээлээс нүдэндээ дүүрэн нулимстай гэртээ ирсэн юм. Би дөрөв дэх жилдээ төгөлдөр хуурын хичээл авч байсан бөгөөд арайхийж “Twinkle, Twinkle, Little Star” дууг тоглож сураад байлаа. Багш маань миний аймшигтай тоглолтын талаар аль болох эерэг зүйл хэлэхийг хичээсэн ч би сэтгэлээр унав. Эцэг эх маань миний хүсэггүй мөн ямар ч ирээдүйгүй төгөлдөр хуурын хичээлд мөнгө төлж байв.

Би эцэг эх маань намайг тоглохоо болихыг зөвшөөрөөсэй гэж хүсэж байлаа. “Зөвшөөрчих л дөө” гэж би гуйв. “Би хэрэгтэй бүхнийг хийх болно. Юу хийх вэ?”

Тэд хоорондоо ярилцаад, “Хэрэв чи 50 дуулал тоглож сурвал бид чамайг тоглохоо болихыг зөвшөөрнө” гэж хэлэв.

Би тэр даруй давтаж эхэллээ. Би болихыг үнэхээр их хүсэж байсан тул төгөлдөр хуур дээр илүү их цаг зарцуулах нь надад асуудал биш байв. Эхний дуулал болох “Бурхан минь, Бошиглогч илгээсэнд бид талархъя” (*Сүмийн дуулал болон хүүхдийн дууны ном, 36*) дууллыг тоглож сурахад бараг сар болов. Би тоглохоо болимоор байсан тул үргэлжлүүлэн давтлаа.

Сонирхолтой зүйл тохиолдсон нь дууллыг тоглож сурахад амархан болж байсан юм. Би долоо хоногийн турш илүү их аз жаргал мэдэрч байв. Би өдрийн туршид дууллыг амандаа аялж, ариун ёслол дээр илүү чанга дуулдаг боллоо.

Яваандаа би хэчнээн дуулал сурснаа ч тоолохоо болив. Миний төгөлдөр хуур тоглох чадвар сайжирсаар, би шинэ дууллыг 30

минутаас бага хугацаанд төгс тоглож чаддаг болсноо анзаарсан юм.

Эцэст нь би сурсан бүх дуулаа нэмээд үзтэл 50-аас хол давсан байлаа. Ингэж миний төгөлдөр хуур тоглохоо болино гэдэг бодол замхран алга болсон юм. Би тоглох чадвартаа илүү их итгэлтэй болж, амьдралдаа дууллын хүчийг мэдэрсэн.

Дуулал нь судрын нэгэн адил үнэнийг өгүүддэг. Би дуулал тоглохдоо судруудад умбаж байгаа мэт мэдрэмж надад төрдөг. Дууллыг тоглож сурах нь гэрчлэлээ хөгжүүлж, үнэнийг мэдэх эхний алхам байсан юм. Би өдрийн туршид надад туслах өөр өөр дууллын үгсийг боддог. Төгөлдөр хуур тоглох нь миний гэрчлэлийг хүчирхэгжүүлж, хаана ч байсан надад тусалдаг юм. ■

Зохиогч нь АНУ-ын Нью-Йоркод амьдардаг.



ЦОЧРОЛ, ХАРУУСАЛ, БУРХАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Амьдралын минь хамгийн аймшигтай үйл явдлын туршиг
Тэнгэрлэг Эцэг надтай хамт байсныг би мэдэрсэн юм.*

Паола Кажупи

2008 онд нэгэн өглөө эрт ээж маань намайг сургуульд явуулахаар сэрээв. Би тэр өглөө их баяртай байсан ч энэ өдөр миний амьдралын хамгийн муу өдөр болон хувирахыг мөн ээжтэйгээ хамгийн сүүлийн удаа хамт байгаагаа мэдээгүй юм. Би тэр өдөр хичээлүүддээ бүрэн сууж чадаагүй бөгөөд манай гэр бүлийнхний найз ирж, намайг сургуулиас авч яван, ээжийг амиа хорлосон болохыг надад хэлсэн юм. Би дөнгөж 12 настай байлаа.

Би “ээжгүйгээр яаж амьдрах юм бэ?” гэж бодов. Тэр миний хамгийн сайн найз байсан шүү дээ.

Би олон сар уйлсан. Хүүхдүүд надтай өөрөөр харьцаж, намайг өрөвдөж байсан тул би сургуульд явах дургүй болов. Би юу хийхээ мэдэхгүй байсан бөгөөд зөвхөн өөрөө өөрийнхөө төлөө хүчтэй байх ёстойгоо л мэдэж байлаа.

Би ээжийгээ нас барснаас хойш тав, зургаан сарын дараа нэгэн өдөр өрөөнийхөө цонхны хажууд суугаад, энд юуны төлөө амьдарч байгаагаа ойлгохыг хичээн үйлж суулаа. Тэгтэл би гэнэт “Чи бол миний охин, би чамайг зовж шаналгахгүй” гэх дуу хоолойг зүрх сэтгэлдээ сонслоо. Энэ бол Бурхан байсан гэдгийг би мэдэж байсан. Гэхдээ би Бурханд итгэхээ больсон байсан учраас ялангуяа Тэр надаас ээжийг минь авсан гэж бодож байсан тул энэ явдалд гайхав. Тэр яг ямар утгатай үгс хэлснийг би мэдэхгүй байсан ч аюулгүй байдлыг мэдэрсэн.

Би гурван жилийн дараа Италийн Ром хотод авга ах дээрээ зочилж очсон юм. Тэр надад өөрийнхөө явдаг

энэ сүмийн талаар олон удаа ярьж өгөв. Нэгэн ням гарагт тэр намайг дагуулан явлаа. Би анх удаа сүмийн хаалгыг чиглэн явж байгаад, хаалгаар оронгуут Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдэрснээ үргэлж санах болно. Надад яг л гэртээ байгаа мэт санагдсан.

Би ням гараг бүр сүмд очиж, долоо хоногт болдог үйл ажиллагаануудад оролцож эхлэв. Би Сүмийн өсвөр үеийнхэнтэй хамт байхдаа дуртай байлаа. Тэд намайг илүү аз жаргалтай болгож байв. Тэд надтай адил бодож, ижил зүйлд итгэдэг байлаа. Тэгээд гурван сарын дараа миний зуны амралт дуусаж, би Албани руу буцах болов.

Би гэртээ хариад, аавдаа энэ бүх хугацаанд мэдэрсэн мэдрэмжүүдээ болон хэрхэн аз жаргалтай байсан тухайгаа яриу. Түүнд энэ бүхэн огт таалагдсангүй. Тэр намайг сүмд явахыг эсвэл сүмийн талаар илүү ихийг сурахыг зөвшөөрөхгүй гэдгээ хэлсэн юм. Тиймээс би 18 нас хүртлээ гурван жил тэвчээртэй байх ёстой болов. Тэр үед би өөрөө шийдвэр гаргаж, баптисм хүртэж болох байлаа.

Энэ цаг хугацаанд би ням гараг бүр сүмд сурсан зүйлсээ надтай хуваалцдаг байсан олон хүнээр адислагдсан юм. Тэдний нэг бол Стефани байв. Стефани манай авга ахыг Сүмд нэгдэх үед Италид амьдарч байгаад, Нэгдсэн Улс руу гэртээ буцсан байв. Авга ах маань бид хоёрыг хоорондоо юм бичиж харилцвал сайн гэсэн тул би түүнийг Фэйсбүк дээр найзаа болгосон.


Бид бие биетэйгээ уулзаж байгаагүй ч би түүнд намайг итгэлээ хөгжүүлж, Есүс Христийн сайн мэдээний

талаар илүү ихийг мэдэхэд тусалсанд нь үргэлж талархах болно. Тэр бараг ням гараг болгонд над руу ямар нэгэн юм бичиж, сүмд сурсан зүйлсээ ярьж, асуултуудад маань хариулдаг байв. Тэр миний хувьд гайхалтай сайн найз байсан юм.

Би олон жил тэвчээртэй байсны эцэст, 18 нас хүрээд хоёр өдрийн дараа баптисм хүртэв. Би тэр өдөр мэдэрсэн аз жаргалаа ээжтэйгээ удахгүй хуваалцах болно. Учир нь би түүний төлөө баптисм хүртэх болно. Миний сонгосон амьдралаар ээж минь бахархана гэдгийг би мэднэ.

Тэнгэрлэг Эцэг намайг маш олон зүйлээр адисалж, аяллын минь туршид олон арга замаар надтай хамт байсан. Надад зориулсан төлөвлөгөө Түүнд байсан учир би зүгээр л хүлээх, тэвчээртэй байх хэрэгтэй байсан юм. Тэр тулгарсан бүхий л сорилтуудыг даван туулах хүч тэнхээг надад өгсөн. Тэр намайг илүү их аз жаргалтай болгохын тулд надад тусалж байсан билээ. ■

Зохиогч нь Албанид амьдардаг.





Хосе А.Тэхэйра
Далын ахлагч

ТА ИЧИМХИЙ

БАЙСАН Ч

*Их Эзэнд найд. Сайн мэдээг хуваалцах
хичээл зүтгэл бүрд тань Тэрээр та
нарыг адислах болно.*

Би Бразилд номлолын шинэ ерөнхийлөгч байхдаа хэдэн ахлагчтай ярилцлага хийсэн юм. Би нэгнээс нь өөрийнхөө талаар ярихыг хүсэв.

“Би их ичимхий” гэж тэр хэлсэн юм. Бүрэг ичимхий зан нь үйлчлэлд нь саад болж магадгүй хэмээн түүний санаа зовж байв.

“Би түүнээс Их Эзэн чамайг сайн номлогч байхад тусалж чадна гэж чи бодож байна уу? гэж асуув.

“Би Их Эзэн бүхнийг хийж чадна гэдэгт итгэдэг.”

“Өөртөө туслах боломжийг Түүнд олго. Чи үүнийг хийж чадах уу?” гэж би асуув.

“Чадна” гэж тэр хэлэв.

Түүнийг гарч явах үед “за даа, бүтнэ гэж л найдъя даа” хэмээн бодсоноо нуух юун.

Хэдэн долоо хоног өнгөрсний дараа удалгүй нөгөө номлогчид дахин ярилцлагад орохоор ирэв. Энэ удаа нөгөө ичимхий ахлагчийн хамтрагч “Ерөнхийлөгч өө, би таныг түүнд юу гэж хэлснийг мэдэхгүй ч энэ нь түүнд үнэхээр тусалсан шүү. Тэр хүмүүстэй ярихдаа их сайн болсон” гэж хэлэв. Би үүнийг сонсоод, түүнтэй дахин уулзахыг тэсэн ядан хүлээж байлаа.



Тэр миний өрөөнд орж ирээд доош харан зогссоноо, “Надад сайхан мэдээ байгаа” гэж хэлэв. Тэрээр “Би ичимхий хэвээр байгаа ч надад туслахыг Их Эзэнээс гуйсан. Тэгээд би амаа нээж, ярьж эхэлсэн. Тэгээд яасныг та мэднэ шүү дээ? Би одоо цаг үргэлж ярьж байгаа. Би бүр юу хэлэхээ ч санадаггүй. Гайхалтай нь хүмүүст тэр нь их таалагддаг. Тэд Сүнснийг мэдэрдэг. Тэд намайг болон миний тэдэнд хэлэх гэж байгаа зүйлсийг ойлгодог” гэж билээ.

Энэ номлогч Их Эзэнд итгэж найдсанаар хэрхэн өөрчлөгдсөнийг нь хараад би гайхаж билээ. Тэр олон хүнд аз жаргал авчрах агуу зэмсэг болсон байв.

“Би ичимхий хэвээр байгаа ч Их Эзэнээс туслахыг гуйсан.”

Айдсаа ялан дийлэх нь

Бид сайн мэдээг хуваалцахдаа заримдаа их сандардаг. Гэвч энэ ичимхий номлогчийн жишээгээр, хэрэв бид Түүнд итгэвэл Их Эзэн биднийг удирдах болно. Ариун Сүнс бидэнд юу хэлэхээ мэдэхэд маань туслах болно (2 Нифай 32:2–3-ыг үзнэ үү), хүмүүс Сүнснийг мэдэрсэн үедээ илүү эерэг ханддаг. Олон хүн бидний итгэдэг зүйлсийг сонирхдог бөгөөд илүү ихийг мэдэхийг хүсдэг.

Агуу баяр хөөр

Тэнгэрлэг Эцэг сайн мэдээг хуваалцах хичээл зүтгэлд маань биднийг удирдаж, бид үүнээс агуу баяр хөөрийг мэдрэх болно гэдгийг би гэрчилж байна. Чухамдаа тэрхүү баяр хөөр нь энэ амьдралд төдийгүй ирэх дэлхийд бидэнд байх болно. (С ба Г 18:16-г үзнэ үү.) Энэ нь та ичимхий байсан ч өөрийн дасаж сурсан орчноос гарч, өөр зүйл хийх сайн учир шалтгаан юм. ■

ТАНЫ ЯЛАН ДИЙЛЖ ЧАДАХ ГУРВАН ТӨРЛИЙН АЙДАС

Бүрэг ичимхий зангаас гадна, “би сайн мэдээний талаар яривал найзуудаа алдана гэдгээс айж байна” гэж та нарыг хэлэхэд хүргэдэг өөр гурван айдсыг би мэднэ. Аз болоход бид тэдгээр айдсыг итгэлтэйгээр ялан дийлж чадна.

1. БИ ХАНГАЛТАЙ САЙН МЭДЭХГҮЙ.

Хэрэв та сайн мэдээний тухай мэдлэг муутай бол бүрэн цагийн номлогчид танд тусалж чадна. Тэд Сэргээлтийн тухай захиасыг заахад болон Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээ хүчирхэгжүүлэхэд тусалж мөн наманчлалыг ойлгоход болон үүнийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх ёстойг мөн баптисм ба Ариун Сүнсний бэлэг нь яагаад чухал болохыг ойлгоход бидэнд тусалж чадна. Мэдлэгийн өөр нэг агуу эх үүсвэр нь *Миний сайн мэдээг номло* удирдамж юм. Би залуу эрэгтэй, эмэгтэй бүрийг энэ номыг олж авч, үүнийг өдөр тутам судрынхаа хамт судлахыг зөвлөж байна.

2. БИ ӨМНӨ НЬ ХЭЗЭЭ Ч ИЙМ ЗҮЙЛ ХИЙЖ БАЙГААГҮЙ.

Хэрвээ танд туршлага дутаж байвал номлогчидтой дадлага хийгээд үз! Тэд тодорхой нөхцөлд юу хэлэх эсвэл хэлэхгүй байгаа мэдэхэд тань тусалж чадна. Та номлогчидтой хамт цагийг өнгөрүүлэхдээ, тэднийг сайн мэдээнд болон бусдад хайртай болохыг мэдрэх болно. Тэд сайн мэдээг хуваалцах зоригийг олсон тул таныг ч бас зоригтой болоход тусална.

3. БИ ХУВААЛЦАХААС АЙЖ БАЙНА.

Бид гэрчлэлээ хуваалцахдаа найз нөхдөө илүү өндөрт байгаа зүйлсийг олж харахад тусалдаг бөгөөд тэд биднийг арай өөрөөр хүндэтгэн хайрлаж эхэлдэг. Ийм зүйл байнга тохиолддог юм. Олон залуу хүн “Би айж байсан ч чин сэтгэлээсээ ярихад найз маань надад итгэж, илүү их зүйл асууж эхэлдэг” гэж хэлдэг. Бид байгаа зүйлсээ хуваалцахаас айх ёсгүй. Энэ нь Бурханаас ирдэг тул эрхэм нандин юм. Бид найз нөхдөдөө хайраа үзүүлэхдээ үнэн гэдгийг нь мэддэг зүйлээ хуваалцахаас өөр сайн арга зам байдаг гэж үү?

БИДНИЙ ОРОН ЗАЙ

БҮХ ЗҮЙЛД ШУДАРГА ХАНДАХ НЬ

Аливси Х., Мексик, Халиско

Бид хичээлийн жил эхлэх бүрд тэмдэглэлийн дэвтэр, төлөвлөгөө болон янз бүрийн зүйлээс бүрдэх бүтээгдэхүүний үнэгүй багц авдаг юм. Би нэг удаа дараалалд зогсон байж, энэхүү багцыг авчхаад, авсан зүйлс маань надад тун их хэрэгтэй болохыг ойлгов.

Орой болоход тэд нэг бүтээгдэхүүнээс хоёрыг өгч байгааг би харлаа. Дахиад дараалалд зогсож, хоёр дахь багцаа авах нь тийм ч хэцүү биш байсан учраас би үүнийг авахаар шийдэв. Эцсийн эцэст, тэдгээр зүйл үнэгүй байсан бөгөөд надад хэрэгтэй байлаа.

Би ариун цэврийн өрөөнд хальт ороод, хэн нэгэн охин гар утсаа

санамсаргүй орхисон байсныг харсан юм. Тэр гар утас сүүлийн үеийн загвартай байсан бөгөөд би долоо хоногийн өмнө утсаа алга болгосон байв. Гэвч би тэр утсыг өөрөө авчихъя гэж бодоогүй. “Тэгэх нь хулгай хийж байгаа хэрэг” гэж би өөртөө хэлсэн.

Тэгээд би хоёр дахь удаагаа үнэгүй багц бүтээгдэхүүн авахаар явж байхдаа багцыг өмнө нь аваагүй гэж худлаа хэлж, дахиад авах нь тэр утсыг өөртөө авсантай адил шударга бус зүйл болохыг ойлгосон юм.

Би надад агуу зүйлийг заасан энэ жижиг үйл явдалд талархдаг.



Би утсыг эзэнд нь эргүүлэн өгөөд, гэртээ зөвхөн нэг дэвтэр, нэг төлөвлөгөө болон нэг өөр бүтээгдэхүүний багцтай харьсан ч жижиг гэлтгүй бүх зүйлд зөв шударга байсандаа сайхан сэтгэгдэлтэй үлдсэн билээ. ■

АРАВНЫ НЭГИЙН ХУУЛИЙГ ДУУЛГАВАРТАЙ ДАГАСНААР АДИСЛАГДСАН НЬ

Сабрина Т., Бразил, Сан Пауло

Намайг бага байхад манай гэр бүл ч мөн би ч санхүүгийн олон хүндрэлтэй учирсан бөгөөд энэ байдал намайг 10 нас хүртэл үргэлжилсэн юм. Эцэг маань өөр ажил олж чадаагүй учир гудамжинд юм зарж, багахан орлого олдог байв. Ээж маань эрэгтэй дүү бид хоёрыг харж гэртээ үлддэг байлаа.

Өчнөөн олон сорилт бэрхшээл тохиолдож байсан ч бид аравны нэгээ болон бусад өргөлийг төлөх талаар гэрчлэлтэй байсан юм. Бид сар бүр аравны нэгээ итгэлтэй төлж, юугаар ч дутагдаагүй байлаа. Их Эзэн хязгааргүй нинжин сэтгэлтэй учраас мөн биднийг зарлигуудыг

нь дуулгавартай дагахад амлалтуудаа биелүүлдэг учраас бид үргэлж адислагдаж байснаа баттай мэддэг.

Бидний санхүүгийн хүнд хэцүү өдрүүд эцэст нь төгсгөл болсон юм. Их Эзэний сүүлийн хэдэн жил бидэнд өгсөн адислалууд гайхалтай байлаа.

Аравны нэгээ итгэлтэй төлдөг, бусдын амьдралыг адислахын тулд өргөлүүдээ хайраар төлдөг хүмүүст надад болон миний гэр бүлд тохиолдсонтой адил юу ч дутагдахгүй, бүр илүү сайн сайхан зүйлс тохиолдох болно гэдгийг би мэднэ. Адислал улам бүр нэмэгдэнэ. Би үүнийг мэднэ. Би үүний дагуу амьдарсан. ■

ИДЧИХМЭЭР ГОЁ БАЙНА УУ?

Дахиад хар. Сатан биднийг жинхэнэ баяр хөөрөө хэзээ ч үл биелэх аз жаргалын хоосон мөрөөдөл төдийгөөр солиосой гэж хүсдэг. Ганц ч хазаж болохгүй.

(Дийтр Ф.Угдорф. "Та одоо босч чадна аа!", 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 65-ыг үзнэ үү.)



“Би хожмын үеийн гэгээнтэн гэдгээсээ болж сургууль дээрээ шоолуулдаг. Би итгэдэг зүйлийнхээ төлөө зогсох хэрэгтэйг мэддэг ч энэ нь үнэхээр хэцүү байдаг! Би хэрхэн хангалттай зоригтой болох вэ?”

Энэ нөхцөл байдалтай тэмцэхэд танд зориг хэрэгтэй. Эцсийн эцэст Есүс Христ “Та нарын гэрэл үндэстнүүдийн хувьд жишиг байж болохын тулд босч мөн урагш гэрэлтүүл” (С ба Г 115:5) хэмээн тушаасан. Гэхдээ гэрлээ урагш гэрэлтүүлэх зоригтой байна гэдэг нь таныг дооглож буй хүмүүсийн эсрэг үнэнийг ярьж болно эсвэл ярихгүй байж болно гэсэн үг юм.

Аль нь ч байсан, аливаа сөрөг зүйлд чамайг сайжруулах боломж олго. Чи гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийн тулд шаргуу ажиллаж байхдаа бусад хүн чамайг дооглож байсан ч үнэнийг ярихад эсвэл зүгээр л зөв зүйлийг үргэлжлүүлэн хийхэд чамд тусалж чадах тийм чимээгүй зоригийг хөгжүүлж чадна.

Бусдаар гоочлуулах нь сэтгэлээр унагаж болох ч бусад хүн чамаар дамжуулан Христийн хайрыг мэдэрч болохын тулд чи энэрлээр дүүргэгдэхийн төлөө залбирч чадна гэдгээ санаарай (Моронай 7:48-ыг үзнэ үү). Нөхцөл байдал бүр өөр өөр байдаг тул тохиолдол бүрд хэрхэн Христийнхтэй адил арга замаар хандаж болохоо мэдэхийн тулд Сүнсний удирдамжийг эрэлхийл.

Нөхцөл байдлаас хамааран, чамайг дооглож тохуурхсан хүмүүстэй ганцаарчлан уулзаж ярилцах эсвэл итгэлийнхээ дагуу үргэлжлүүлэн амьдарснаар нөхөрсөг бус элэг доогийг зүгээр л тоохгүй өнгөрөх нь хамгийн сайн арга зам байж болно. Чиний хэлэх үгсийг бусад хүн сонсохыг хүсэхгүй байвал сайхан сэтгэл, уучлал, чин сэтгэлийн үлгэр жишээ тань чиний тэдэнд илгээж чадах хамгийн сайн захиас болж болох юм.

Жинхэнэ зоригийг харуул

Чи тэднээс шоолохоо болихыг хүсэх хангалттай зоригтой байсан ч чамайг шоолдог хүмүүс шоолохоо болихгүй байж болох юм. Гэвч чи өөрийнхөөрөө, хожмын үеийн гэгээнтэн шиг амьдрах зориг гаргаснаар тэд больж болно. Чамайг үүнийг мэдэхээс өмнө Тэнгэрлэг Эцэгийн баталсан туяа чиний амьдралд буй тэрхүү сэргээгдсэн сайн мэдээг олж харахад тэдний нүдийг нээж болохын тулд чиний дээр гэрэлтэх болно.

Брайт У., 17 настай, Нигери, Имо муж

Энгийн зүйлсээс хүч чадал ол

Залбирал ба мацаг барилт чухал юм. Учир нь Есүс Христ энэ дэлхий дээр байхдаа маш их доог тохуутай учирч байсан шиг чамайг ч гэсэн сургууль дээрх тоглоом шоглоом, түвэгтэй асуудлуудтай тулгарахад залбирал, мацаг барилт тусална. Эдгээр нь чамд бусдыг хайрлах илүү их хайр, тэвчээрийг хөгжүүлэхэд тусална.

Волтэр К., 15 настай, Перу, Хаэн



Залбирлаар удирдуулах нь

Олон жилийн турш би сургуульдаа ганцаараа Сүмийн гишүүн байсан юм. Дотны найзууд маань намайг ойлгож байсан ч сургуулийн бусад найз маань шоолдог байв. Нэгэн өдөр би залбираад, намайг шоолоход бусдыг уриалдаг хүүхдүүдийн нэгтэй ярилцмаар санагдлаа. Би түүнд уурлахгүй байгаагаа тайлбарлаад,

надаар хүндлүүлэхийг хүсвэл намайг ч бас хүндлэхийг түүнээс хүссэн юм. Нэг багш маань бидний яриаг сонссоноосоо хойш, ямар нэгэн зүйл болоход намайг байнга хамгаалдаг болж билээ. Чамайг ийм хүмүүстэй ярилцах үед Их Эзэн чамтай хамт байх болно гэдгийг би мэднэ.

Шанела С., 14 настай, Филиппин, Пангасинан

Гэрчлэлээ хөгжүүл

Эхлээд бусадтай хуваалцмаар байгаа үнэнийхээ талаар бодит гэрчлэлтэй бол. Чамайг тохуурхаж буй хүмүүсийг хайрла, Бурхан зөрчилдөөнийг хэзээ ч дэмждэггүй тул тэдэнтэй бүү маргалд (3 Нифай 11:29-ийг үзнэ үү). Хамгийн чухал нь үргэлж Сүнстэй хамт байхыг хичээ. Сүнс чамайг илүү их хайраар дүүрэн мөн зоригтой байхад тусалж, чиний үгсийг хүчирхэг болгоно.

Жулиа Ф., 19 настай, Герман, Хэссэ



Дайснаа хайрла

Би тиймэрхүү нөхцөлд байж үзсэн. Хэрэв чи итгэлтэй байж, өөрийгөө даруусгавал, “дайснаа хайрлаж, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбирах” хүч чадал, итгэлээр адислагдах болно (Матай 5:44). Би хэрхэн хүчтэй байх талаарх судруудыг судлахыг уриалж байна. Ганцаардсан үедээ итгэлтэйгээр залбир. Ром 8:31-д хэлэхдээ, “Тэгвэл бид эдгээр зүйлийн тухайд юу хэлэх вэ? Хэрэв Бурхан бидний талд юм бол, хэн биднийг

эсэргүүцэх вэ?” гэсэн байдаг. Бурхан чиний дэргэд байна. Бүх зүйл боломжтой.

Рийган Т., 15 настай, АНУ, Юта



Бүү ай

Шашныхаа тухай илүү олон удаа ярих эсвэл ийм боломж олгох зүйлсийг зориуд хий. Би бас иймэрхүү нөхцөлд байж үзсэн ба “Би ХҮГ байхдаа дуртай” гэж үүргэвчин дээрээ бичсэн. Тэгснээр би хэд хэдэн удаа номлогч байх боломжтой болсон бөгөөд бусад хүнд ХҮГ гэдгээ мэдэгдэхээс айдаггүй гэдгээ харуулсан юм. Чи юу ч хийсэн бай, тэдэнд боломж бүү олго. Тэдний төлөө, бас өөрийнхөө төлөө залбир. Удалгүй та бусдын бодгалийг аврахад анхаарч байгаагаан анзаарна. Та Эцэгийн сайн мэдээний үнэнийг тэдэнд хэлэхээс айхаа болино.

Саванна П., 14 настай, АНУ, Техас



ИТГЭЛ ҮНЭМШЛИЙН ЗОРИГ

“Өөр байж, олны дунд ганцаар зогсох нь ихэнхдээ хэцүү байдаг. Бусад хүн юу гэж бодох бол эсвэл юу хэлэх бол гэж санаа зовох нь эгэл хүний шинж чанар юм. Дуулал дахь: ‘Эзэн бол миний гэрэл болон миний аврал юм. Хэнээс би эмээх юм бэ? Эзэн бол миний амийн хамгаалалт юм. Хэнээс би айх юм бэ?’ хэмээх үгс биднийг тайтгаруулдаг [Дуулал 27:1]. Бид Христийг амьдралынхаа төв болгох үед айдас зовнил маань зоригоор солигдох болно.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Үлгэр жишээ мөн Гэрэл байгун,” 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 75.

ДАРААГИЙН АСУУЛТ

“Би Бурхан залбирлыг маань сонсож байгаа гэдгийг хэрхэн мэдэх вэ?”

Хариултаа, хүсвэл өндөр нягтралтай зургийн хамт lahona.lds.org хаягаар, э-мэйл бичих бол lahona@ldschurch.org хаягаар эсвэл шуудангаар илгээх бол 3-р хуудсан дээрх хаягаар 2016 оны 5-р сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Дараах мэдээлэл болон зөвшөөрлийг өөрийн э-мэйл юм уу захидалдаа оруулах хэрэгтэй: (1) овог нэр, (2) төрсөн огноо, (3) тойрог эсвэл салбар, (4) гадас эсвэл дүүрэг, (5) таны хариулт ба гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн чинь бичгээр гаргасан зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлаж магадгүй.



Ахлагч Дэвид
А.Бэднар
Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын ахлагч

Төлөөлөгчид юу хийдэг вэ?

Төлөөлөгчид бол Их Эзэний үйлчлэгчид юм. Тэд дэлхий даяарх Сүмийн гишүүд дээр зочлохын тулд аялдаг.

Би хамгийн анх төлөөлөгчөөр аялахдаа мэргэн ухааны үгийн дагуу амьдарч чадахгүй байсан нэгэн хүнтэй уулзсан юм. Би түүнд “Их Эзэн ‘Та үүнийг хийж чадна’ гэсэн тун энгийн захиасыг өгүүлэхээр намайг энд илгээсэн юм. Та энэхүү сорилттой тулгарах үедээ Түүний тусламжийг авах болно гэдгийг би танд амлаж байна” гэж хэлсэн.

Их Эзэн ганцхан хүнд туслуулах гэж л арванхоёр төлөөлөгчийнхөө нэгийг дэлхийн хагасыг туулах газар илгээнэ гэж үү? Хариулт нь *тийм* юм. Тэр үргэлж ийнхүү илгээдэг. ■

Ахлагч Бэднар, Бэднар эгч хоёртой хийсэн дэлхий даяарх шууд нэвтрүүлгээс.



**Кэрл
Ф.Макконки**

Залуу
эмэгтэйчүүдийн
ерөнхий
ерөнхийлөгчийн
зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх

Зүрх сэтгэлийн амар амгалан



Би найман настайдаа бошиглогч, Ерөнхийлөгч Дэвид О.Маккэйг (1873–1970) харж билээ. Тэрээр АНУ-ын Нью-Йорк мужийн Палмира дахь Сүмийн шинэ барилгыг онцгойлон адислахаар ирсэн байлаа. Манай гэр бүл тэрхүү онцгойлон адислах үйл явцад оролцсон юм. Мөн өөр бусад олон хүн ирсэн байв. Бид бүгдээрээ бошиглогчийг харахдаа баяртай байлаа.

Би жаахан байсан тул түүнийг олон хүний дундаас олж харахад хэцүү байв. Гэхдээ л би ерөнхийлөгч Маккэйгийн хайрыг мэдэрч чадсан. Хэсэгхэн зуур би түүний цагаан үс, элдэг төрхийг ажиглан харав. Би “Бурханы бошиглогч ийн харагддаг байх нь ээ” гэж бодсон.

Би бошиглогчдын талаар судраас уншсан боловч энэ бол миний хувьд анх удаа бошиглогч эсвэл ерөнхий эрх мэдэлтнийг өөрийн нүдээр харсан явдал байлаа. Би бошиглогчид бодит хүн болохыг ойлгосон. Тэд биднийг хайрладаг! Би тэр өдөр мэдэрсэн хайр, амар амгаланг үргэлж дурсах болно.

Намайг арваннэгэн настай байхад тохиолдсон нэгэн явдал зүрх сэтгэлдээ амар амгаланг мэдрэхэд надад тусалсан юм. Гадасны чуулган болох гэж байсан бөгөөд би гадасны найрал дуунд дуулах гэж байв. Би маш их баяртай байлаа! Би сайхан цагаан цамц өмсөөд үнэхээр онцгой сэтгэгдэлтэй байв. Бидний дуулсан дуунд Иохан 14:27-д

байдаг Есүсийн “Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай” хэмээх шүлгийн үгс орсон байв.

Энэ үгс зүрх сэтгэлд минь гүнзгий нөлөөлж, түүнээс хойш би тэдгээр үгийг мартаагүй. Би тэр үгсийг дуулахдаа үнэн гэдгийг нь мэдэж байсан. Есүс Христийг дагах нь амар амгаланг мэдрэхэд тусалдаг гэдгийг Ариун Сүнс надад хэлж буйг би мэдэрсэн. Түүнээс хойш сорилттой тулгарах үед маань энэ судар надад санагдаж, амар амгаланг өгдөг болсон билээ. Бага байхдаа мэдсэн үнэн маань миний амьдралыг бүхэлд нь адисалсан юм. ■

ЭТАНЫ ГЭРЧЛЭЛ

Ларри Хиллер

Бодит түүхээс сэдэвлэв

“Сонс, сонс. Ариун Сүнс шивнэх болно. Намуухан зөөлөн дуу хоолойг сонс, сонс” (Хүүхдийн дууны ном, 106).

Этан хуваалцах цаг дээр сууж байхдаа, гэрчлэлээ хуваалцаж байгаа сайн найз Сэмийг харлаа. Түүний найз Сара бас ээлжээ хүлээгээд сууж байв. Сэм хийсэн үйлчлэлийн төслийнхөө тухай яриу. Түүнд үйлчлэлийн тухай гэрчлэл бий гэж тэр хэллээ. Сара гэр бүлийн талаар гэрчлэлээ хуваалцав. Этаны багш бас гэрчлэлээ хуваалцан, ариун сүмийн ажлын талаар ярилаа. Тэд бүгдээрээ энэ Сүм үнэн гэдгийг гэрчилсэн. Этанаас бусад нь гэрчлэлтэй юм шиг санагдаж байлаа.

Надад ямар гэрчлэл байдаг билээ? гэж Этан бодов.

Тэр хэдэн жилийн өмнө найзуудынхаа хамт баптисм хүртсэн тухайгаа бодлоо. Хүүхдийн ангийн багш Калдэр эгч Ариун Сүнсний тухай үг хэлж байсан.

“Ариун Сүнс та нарын зүрхэнд шатах мэт мэдрэмжийг өгдөг. Тэр та нарыг юу үнэн болохыг мэдэхэд тусална” гэж Калдэр эгч хэлсэн юм. “Та нар итгэдэг зүйлийнхээ талаар ингэж л гэрчлэлтэй болдог.”

Этан зөв гэсэн зүйлийг хийж, Ариун Сүнсийг мэдрэхийг хичээсэн. Тэр судруудаа уншиж, залбирсан. Гэвч түүнд хүмүүсийн яриад байгаа шиг шатах мэт мэдрэмж огт төрж байгаагүй. Тийм болохоор

Этанаас бусад нь гэрчлэлтэй юм шиг санагдаж байлаа.





түүнд гэрчлэл байхгүй гэсэн үг үү?

Маргааш нь өдрийн турш Этан энэ асуулт бодогдсоор байв. Этан хичээлийн дараа Сэмтэй скэйтерээр гулгаж байхдаа ч энэ талаар бодсоор байв. Тэр энэ тухай Сэмээс хэрхэн асуух вэ гэж бодлоо.

“Хүүе Сэм, чи өчигдөр гэрчлэлээ хуваалцахдаа айж байсан уу?” гэж Этан арайхийн асуулаа.

Сэм тавцангаасаа үсэрч буугаад, зүлэг рүү алхав. “Бараг л үгүй” гэж хэлээд тэр доош суулаа. “Би урьд нь гэр бүлийн үдэш дээр гэрчлэлээ хуваалцаж байсан.”

Этан түүний хажууд суугаад, скэйтерээ өвөр дээрээ тавив. “Гэхдээ чи гэрчлэлтэй гэдгээ яаж мэдсэн бэ?”

“Аан, би тэр талаар залбирсан чинь надад сайхан мэдрэмж төрсөн юм.”

Этан толгойгоо удаан гэгч дохиод, скэйтерийнхээ дугуйг гараараа эргүүлэв. Яагаад ч юм, Этан ч бас тийм зүйлийг мэдрэхийг хүсэж байлаа.

Тэр орой гэрт харанхуй, чимээгүй болоход Этан залбирахаар орныхоо дэргэд өвдөг сөгдөн суулаа.

“Тэнгэрлэг Эцэг минь, намайг гэрчлэлтэй болоход туслаач. Сүм үнэн гэдгийг мэдэхэд минь туслаач. Иосеф Смит бошиглогч байсан гэдгийг мөн Мормоны Ном үнэн гэдгийг мэдэхэд туслаач.

Этан залбирч байгаад, түр залбирахаа болив. Тэр минут хэртэй бодлоо. Тэгээд “За, би одоо ямар нэг юм мэддэг болчихсон болов уу?” гэж өөрөөсөө асуув.

Тэгтэл түүнд намуухан, амар амгалан мэдрэмж төржээ. Энэ нь шатах мэт хүчтэй мэдрэмж байсангүй. Гэвч Этан энэ бол Ариун Сүнс байсан гэдгийг мэдэв.

Этанд “Би аль хэдийн мэддэг юм байна шүү дээ” гэх нэгэн бодол төрөв. Тэр энэ талаар бодож байхдаа ийм амар амгалан мэдрэмжийг урьд нь мэдэрч байснаа саналаа.

Түүнд Мормоны Номоо унших бүрд энэ нь сайхан бөгөөд зөв гэж санагддаг байв. Одоо Этан тэр мэдрэмж бол Ариун Сүнс байсан гэдгийг мэдэж авлаа. Түүнийг сүм рүү явахад зөв, сайхан мэдрэмж төрдөг байсан нь бас л Ариун Сүнс байжээ. Тэрээр аль хэдийн өөрийн гэсэн гэрчлэлтэй болсон байж.

Тэр бүх зүйлийг яг одоо мэдэх шаардлагагүй юм. Гэвч тэр Ариун Сүнс байдаг бөгөөд түүнийг гэрчлэлтэй болоход түүнд тусалж чадна гэдгийг мэддэг боллоо.

Тэр дахин залбирч эхлэв. Гэхдээ энэ удаа тэрээр баярлалаа гэж хэлэхээр залбирсан юм. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГТ ӨГӨХ ПЕСО

Анжела Пениа Доли

“Зарлигуудыг сахь. Үүнд аюулгүй байдал ба амар амгалан буй” (Children’s Songbook, 146).

Ана бингээ идэж дууслаа. Бин нь зөөлөн бөгөөд амттай байв.

Ана эмээгийнхээ хийсэн бинд дуртай. Өглөөний ундны хамгийн гоё нь бин байдаг байв.

Абуэла эмээ нь аяга тавгаа угаахыг Ана харлаа.

Энэ бол бусад өглөө шиг жирийн нэг өглөө байв. Гэхдээ нэг л зүйл өөр байлаа.

Абуэла уг нь хоол хүнс авахаар зах руу явдаг байсан юм. Гэтэл өнөөдөр явсангүй. Өнөөдөр хоол хүнс авах мөнгө байсангүй.

“Маргааш бид юу идэх юм бол?” гэж Ана бодлоо.

Дараа нь Ана нэг зүйлийг санав. Тэр хаана мөнгө байгааг мэддэг шүү дээ! Урьд шөнө Абуэла хэдэн песог жижиг цагаан даавуунд хийхийг тэр харсан юм.

“Абуэла, та маргаа юу? Танд хоол авах мөнгө байгаа шүү дээ.”

“Ямар мөнгө?” гэж Абуэла асуулаа.

Ана нөгөө мөнгийг авчрахаар гүйв. Ана зоостой жижиг уутыг сэгсрэн үзүүлэв. *Жин! Жин!*

Абуэла инээмсэглэв. “Ана, наадах чинь бидний аравны нэг. Наадах чинь *Түүний* мөнгө.”

“Гэхдээ маргааш бид юу идэх юм бэ?” гэж Ана асуулаа.

“Санаа зовох хэрэггүй дээ. Тэнгэрлэг Эцэг бидэнд тусална гэдэгт би итгэлтэй байна” гэж Абуэла хэлэв.

Маргааш өглөө нь Абуэла Анад хамгийн сүүлчийн эрдэнэ шишийн бинг өгөв. Тэгээд тэр сандал



дээрээ суулаа. Тэр даашинзан дээр улаан цэцэг хатгангаа өөрийнхөө жаахан байсан үеийн тухай ярьж байв. Тэрээр огт санаа зовсон шинжгүй байв.

Тэгтэл Ана хаалга тогшихыг сонслоо. Ана хаалга нээхээр гүйв.

“Авга ах Педро!”

“Та хоёр дээр очмоор санагдаад” гэж авга ах Педро хэлэв. Тэр ширээн дээр гурван ууттай зүйл тавилаа. Нэг уутанд нь бин хийх эрдэнэ шишийн гурил байв. Нөгөөд нь мах. Бас нэг уутанд захаас авсан шинэ ногоонууд байв.

Абуэла “Өө хайрт хүү минь. Би чамд бөөрөнхий махтай хамгийн гоё шөлөө хийж өгье!” гэлээ.

“Таны хийдэг шөл энэ дэлхийн хамгийн амттай нь” гэж авга ах Педро хэлэв.


Ана инээн, алга ташлаа.

Тэгснээ гэнэт алга ташихаа болив. Түүнд мэдмээр байгаа нэг зүйл байв. “Абуэла, та авга ах Педрог ирнэ гэдгийг мэдэж байсан юм уу? Тэгээд л та санаа зовохгүй байжээ?”

“Үгүй ээ. Намайг аравны нэгээ төлөхөд Тэнгэрлэг Эцэг адислах болно гэдэгт би итгэдэг. Тэр үнэхээр адисалсан!” гэж Абуэла хэллээ.

Ана Абуэлаг тэврэв. Тэр Мексикийн хамгийн аз жаргалтай охин мэт санагдав. Абуэла тэр хоёр Тэнгэрлэг Эцэгт итгэдэг. Одоо тэр Абуэлагийнхаа хийсэн амтат шөлийг идэхийг тэсэн ядан хүлээж байна! ■

Энэхүү өгүүллэйн зохиогч АНУ-ын Хойд Каролинад амьдардаг.





Бошиглогч, төлөөлөгчдийг дагах нь

Женна Кофорд



Бурхан биднийг мэдээсэй
Гэж хүсэж байгаа зүйлээ
бидэнд заалгуулахаар бошиглогч,
төлөөлөгчдийг дууддаг. Бид
судруудаас Ноа, Нифай, Иосеф
Смит зэрэг бошиглогчдын
тухай болон Петр, Паул зэрэг
төлөөлөгчдийн тухай уншдаг.
Өнөө үед бидэнд бошиглогч,
төлөөлөгчид бий.



КЛАК ПРАДСЫН ИХ ЭЗЭН ӨВРИЙН БУХ-ҮГСЭЙГ БИЕЛҮҮЛДЭГ. ДАНКАРТ А. ВЕТЕЛЭНДИЙН БАГА ИОСЕФ СМИТ, ПОЛ МАННЫ ШИНЭ ГЭРЭЭНИЙ ТҮҮХҮҮД ХЭВРИ ТОМЛСОНЫ НИФАЙ, ЛИХАИ ХОЕР ЗАВЬ БАРИХААР ЗААВАРЛАГДСАН НЬ БҮТЭЭЛҮҮДЭС ХЭСЭГЧЛЭН АВАВ. ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ГАРТ БҮНЭР

“Бошиглогч, үзмэрч, илчлэгч” гэж хэн бэ?



Бошиглогч Бурханы өмнөөс ярьдаг.

Үзмэрч өнгөрсөн, одоо, ирээдүйг харж чаддаг.


Илчлэгч Бурханы тааллыг бидэнд илчилдэг (үзүүлдэг).

- Тэргүүн Зөвлөлийн гишүүд бүгдээрээ бошиглогч, үзмэрч, илчлэгчид мөн. Төлөөлөгчид ч мөн адил.
- Зөвхөн Сүмийн ерөнхийлөгч Сүмийг бүхэлд нь удирдах эрх мэдлийг Бурханаас авсан байдаг.
- Бидэнд нийт хэдэн амьд бошиглогч, үзмэрч, илчлэгч байдаг вэ?

12 15 3 1

51 :ивчлөгч

Бошиглогчийг дагах нь яагаад чухал вэ?



Бошиглогч бол цамхгаас харж буй нэгэнтэй адил юм (38-р хуудсыг мөн үзнэ үү). Тэрээр ирж буй аюулыг хараад, бидэнд хэрхэн аюулгүй байхыг хэлж өгдөг. Тэрээр Есүс Христийг дагахад бидэнд тусалдаг.

Бошиглогчид биднийг юу хийхийг урьсан бэ?



Өнөөдөр бидний бошиглогч бол ерөнхийлөгч Томас С.Монсон. Түүний биднээс хийхийг хүссэн зарим зүйлийг доор бичив.

- Есүсийн үлгэр жишээг дагаж, хүн бүрийг хайрла.
- Дравны нэгээ төлж, номлолын санд хандив өргө.
- Муу муухай кино, телевиз болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээс хол бай.
- Бүх унтлагын өрөөндөө ариун сүмийн зураг байрлуул.
- Ерөнхий чуулганы үгсийг судал.
- Өндөр настнуудыг эргэж, сайн хөрш нь бай.

Эдгээрээс энэ сард хийж болох нэг зүйлийг сонго. Та юу хийх вэ? ■

Алма наманчилсан нь

Алма ёс бус Ноа хааны прист байсан. Тэрээр бошиглогч Абинадайн зарлигуудыг заахыг сонссон. Алма ёс бус зүйлс хийхийн оронд амьдралаа өөрчлөн, Бурханыг дагах ёстойгоо мэдсэн билээ. Тэр Абинадайн юу заасныг бичиж авсан. Тэр бусдад сайн мэдээг зааж эхлэв. Хожим нь тэр гэр бүлтэй болсон бөгөөд хөвгүүдийнхээ нэгийг Алма гэж нэрлэсэн.



Би хаалгач байсан бөгөөд маш сайн тоглож байсан. Гэхдээ би өчигдөр муухай зүйл хэлснээ наманчлах ёстойгоо санав. Би наманчлах ёстой байсан ч хөл бөмбөгөө

ид тоглож байлаа. Тэр үед би нэг зүйлийг санав. Та хэрэгтэй бол хаана ч залбирч болно! Наманчилсан болохоор залбирсны дараа надад сайхан санагдсан.

Петр Г., 8 настай, АНУ, Юта



Дэймон Б., 8 настай, АНУ, Юта



Энэ даалгаврын картыг хайчилж аван, нугалаад, хадгал!

Би наманчилж чадна!


- Мозая 18:9-ийг чээжил.
- Ерөнхий чуулган дээр бошиглогчийн хэлсэн ямар нэгэн зүйлийг бичих юм уу зур.
- Сайжирч өөрчлөгдөх нэг арга замыг сонго. Түүнийгээ энэ сард хийхийг хичээ.
- Би өөртөө . . . даалгавар өгөв.

АЛМА

Энэ сарын судрууд

Чи судрын хэсгийг уншсанахаа дараа Мормоны Устай холбоотой дугаар бүхий судрын хэсгийг өнгийн харандаагаар буд.


- 1 Мозая 21:14–16; 32–35
- 2 Мозая 22:2, 10–16
- 3 Мозая 24:8, 10–14
- 4 Мозая 27:8, 11, 18–24
- 5 Мозая 27:30–37
- 6 Мозая 28:3, 5–15, 20
- 7 Алма 8:11–16, 18–27
- 8 Алма 11:38–46



Мормоны Ус

Алма Мормоны Ус хэмээх амар тайван газрын ойролцоо Аёс бус Ноа хаанаас нуугдсан. Олон хүн Алмаг сайн мэдээ зааж байгааг сонсохоор ирэв. Тэд баптисм хүртэхийг хүсжээ. Алмаг тэр хүмүүст баптисм хүртээхэд тэд бидний баптисм хүртэх үедээ хийдэгтэй адил амлалтууд буюу гэрээнүүдийг хийсэн. Та дараагийн хуудаснаас эдгээр амлалтын талаар илүү их мэдээллийг уншиж болно. ■


Алма олон хүнд багтисм хүртээсэн нь



Абинадай бошиглогч байв.
Тэрээр хүмүүст Христэд итгэж, муу зүйлс хийхээ зогсоохыг заасан. Ноа гэгч ёс бус хаан Абинадайд хилэгнэв. Ноа наманчлахыг хүсээгүй юм.




Алма гэгч нэгэн эр Абинадайд итгэжээ. Тэрээр уурлаж хилэгнэсэн хаанаас зугтаж, нуугдав. Тэрээр Абинадайн зааснаар, хийсэн буруу зүйлсдээ гэмшиж, наманчилжээ.



Олон хүн Алмаг Есүс Христийн тухай зааж байгааг сонсохоор ирсэн байв. Хэрэв тэд наманчилж, Есүсийг дагавал баптисм хүртэж болохыг Алма заалаа.

Тэр хүмүүс баярлан алга ташицгаасан. Тэд бусдыг тайтгаруулахаа амлав. Тэд Бурханыг хайрлаж, Түүний тухай бусдад хэлэхээ амлажээ. Тэд баптисм хүртэхэд бэлэн байлаа.





Алма хүмүүст нэг нэгээр нь баптисм хүртээв. Тэд Есүсийн Сүмд нэгдэхдээ үнэхээр их баяртай байв.

Бид баптисм хүртэхдээ Алмагийн хүмүүсийн хийсэнтэй нэгэн адил амлалтуудыг хийдэг. Тэгээд бид ч бас Есүсийн Сүмд нэгддэг! ■

Хүндэтгэлийн өдөр бол онцгой өдөр



ЗУРАГ ЧИМГЭЛЛИЙГ АГРИЛ СТОТ



**Ерөнхийлөгч
Жорж К.Каннон
(1827–1901)**

Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх

СҮНСНИЙ БЭЛГҮҮДИЙГ ЭРЭЛХИЙЛЭХ НЬ

Та нарын хэд нь Бурханы өгнө хэмээн амласан тэдгээр бэлгийг эрэлхийлж байна вэ?

Христийн Сүмийн эрэгтэй, эмэгтэй хүн бүр итгэлийнх нь дагуу Бурханы тааллаар оногдсон Бурханы Сүнсний бэлгүүдийг авч болдог. . . .

Та нарын хэд нь . . . Бурханы өгнө хэмээн амласан тэдгээр бэлгийг эрэлхийлж байна вэ? Та нарын хэд нь гэр бүлээрээ тойрон суухдаа эсвэл өөрийн нууцхан газарт Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө бөхийхдөө өөртөө өгөгдсөн эдгээр бэлэгт сэтгэл хангалуун байдаг вэ? Та нарын хэд нь Есүсийн нэрээр эдгээр хүч чадал, бэлгээр дамжуулан Өөрийгөө харуулахыг Эцэгээс гуйдаг вэ? Эсвэл та хаалга нээгдэж, хаагдаж байдаг шиг энэ тухай ямар нэгэн зүйл мэдрэхгүйгээр мөн итгэлээ ямар нэгэн байдлаар хэрэгжүүлэхгүйгээр баптисм хүртэн, Сүмийн гишүүн болж, Сүмд үлдсэндээ сэтгэл ханан, үүнийг хийсэн учраас аврагдах нь гарцаагүй гэж бодож, өдрийг үлгэн салган өнгөрүүлж байна уу? . . .



. . . Би Бурхан өвчтөнүүдийг дуртайяа эдгээж, сүнснүүдийг ялган таних болон мэргэн ухаан, мэдлэг, бошиглолын бэлгийг мөн бусад хэрэгтэй бэлгийг өгөхөд бэлэн байдаг гэдгийг мэднэ. Хэрэв бидний хэн нь ч төгс биш юм бол биднийг төгс болгох бэлгүүдийн төлөө залбирах нь бидний үүрэг мөн. Би дутагдалтай юу? Би зөндөө их дутагдалтай. Миний үүрэг юу вэ? Би эдгээр дутагдлаа засах бэлгүүдийг өгөхийг гуйн, Бурханд хандан залбирах үүрэгтэй. Хэрэв би ууртай бол удаан тэсвэрлэдэг мөн сайхан сэтгэлтэй энэрлийг гуйн залбирах үүрэгтэй. Би атаархаж, жөтөөрхдөг үү? Тийм бол атаархаж жөтөөрхдөггүй энэрлийг гуйн залбирах нь

миний үүрэг юм. Сайн мэдээний бүх бэлгийн төлөө залбирах хэрэгтэй. Тэдгээр нь үүний тулд өгөгддөг. . . . Ямар ч хүн “Өө, би ийм л юм чинь, үүнийг даван туулж чадахгүй” гэж хэлэх ёсгүй. Ингэлээ гээд тэр зөвтгөгдөхгүй. Учир нь Бурхан төгс бус зүйлсээ засах хүчийг өгч, тэдгээрийг үгүй хийх бэлгүүдийг өгөхөөр амласан. Хэрэв хэн нэгэнд мэргэн ухаан дутагдал, Бурханаас мэргэн ухааныг гуйх нь түүний үүрэг. Бусад бүх зүйлийг гуйж болно. Энэ нь Бурханы Сүмийн зорилго юм. Тэр Өөрийн гэгээнтнүүдийг үнэнд төгс төгөлдөр байгаасай гэж хүсдэг. Иймээс Тэр эдгээр бэлгийг өөрсдийн олон сул талыг үл харгалзан энэ дэлхий дээр төгс хүмүүс байхыг эрэлхийлэгчдэд өгдөг. Бурхан тэдний төгөлдөржихөд шаардлагатай тэрхүү бэлгүүдийг өгөхөөр амласан билээ. ■

The Latter-day Saints Millennial Star, 1894 оны 4-р сарын 23, 258–261-ээс авав; цэг таслал, том үсгийг стандартын дагуу өөрчилсөн болно.

ОЙЛГОЛТ



Эхэн үеийн итгэл нь хэрхэн мэдлэг мөн гэрчлэл болон хөгждөг вэ?

“Би Тэнгэрлэг Эцэгт болон Есүс Христэд итгэдэггүй байсан цаг үеэ огт санадаггүй. Би судраас болон сайн мэдээний түүхүүдээс уншиж өгдөг байсан, миний тэнгэр элч болох ээжийнхээ өвөр дээр сууж байхаасаа л Тэднийг хайрлан, Тэдний талаар суралцсан билээ. Бага насны минь тэрхүү итгэл одоо бидний залбирлыг сонсон хариулдаг хайрт Тэнгэрлэг Эцэгийн талаарх мэдлэг, гэрчлэл болон хувирсан.”

Энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ



Сатаны худал хуурмагийг таних нь

44-р
хуудас

Энэ бол Сатаны худал хуурмагийг Их Эзэний үнэнээс ялган таних нэг гол арга юм.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

60-р
хуудас

ТА ИЧИМХИЙ БАЙСАН Ч

Та өмнө нь сайн мэдээ хуваалцахаас ичиж эсвэл айж байсан уу? Энэ талаар гурван зөвлөгөө өгье.



ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ



Бошиглогч, төлөөлөгчдийг дагах нь

72-р
хуудас

Чи энэ сард бошиглогч, ерөнхийлөгч Томас С.Монсонг дагахын тулд юу хийж чадах вэ?



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ